2. Зөвлөх нь Захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.
3. Захиалагч нь “Автозамын салбарт олон улсын стандарт нутагшуулах, үндэсний стандарт боловсруулах, эрдэм шинжилгээ судалгааны ажил”-ын 12-р багц “Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн Зөвлөх үйлчилгээний ажлыг (цаашид “ажил” гэх) **334,776,700 (Гурван зуун гучин дөрвөн сая долоон зуун далан зургаан мянга долоон зуун төгрөг)-өөр** (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн Зөвлөхийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
4. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 1. Гэрээний ерөнхий нөхцөл;
 2. Гэрээний тусгай нөхцөл;
 3. Ажлын даалгавар, үйлчилгээний цар хүрээ
 4. Тайлан гаргах хуваарь Хавсралт №1
 5. Ажиллах хүчин-Туслан гүйцэтгэгч-Голлох мэргэжилтний ажлын хуваарь Хавсралт №2
 6. Төгрөгөөр тодорхойлсон төсөвт өртөг Хавсралт №3
 7. Гэрээний хэлэлцээрийн протокол
 8. Гүйцэтгэлийн баталгаа



Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Гэрээ нь энд дурдсан Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.

5. Захиалагч болон Зөвлөх нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
6. Зөвлөх нь гэрээний дагуу Захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу Зөвлөхийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ



Д.ДОРЖХАНД

Зам, тээврийн яамны Авто замын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулахын газрын дарга

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ



Н.АДИЛБИШ

“Ар Ди Эй Си” ХХК-ийн зөвлөх инженер

Ч.РЕНЧИНДАМБА

Зам, тээврийн яамны Санхүү, эдийн засгийн хэлтсийн ерөнхий нягтлан бодогч

М.УГТАХБАЯР

Зам, тээврийн яамны Техник, технологи, нормативын хэлтсийн дарга


Л.БАТСҮХ

Зам, тээврийн яамны ТЗУХЭЗГ-ын ахлах мэргэжилтэн

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Чингисийн өргөн чөлөө -11
ЗГ-ын XIII байр
Зам, Тээврийн Яам
Утас: 62263171
Факс:312315

Хан-Уул 15-р хороо 26-19 тоот
Ар Ди Эй Си ХХК-ийн
Банк: Голомт
Дансны дугаар: 3250004589
Регистрийн дугаар:5808324
Утас:99074526



Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ:
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Ж. БАТ-ЭРДЭНЭ

ГҮЙЦЭТГЭГЧ:
“АР ДИ ЭЙ СИ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ
RD&C Co.,Ltd

А. ЗОЛЖАРГАЛ

“АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ТООЛЛОГО, БҮРТГЭЛ ХИЙЖ, ПАСПОРТ, КАРТ ХӨТЛӨН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛД АВАХ СУДАЛГАА, БОЛОВСРУУЛАЛТ”-ЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН 2016 ОНЫ 85 ДУГААР ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ГЭРЭЭ

2016 оны 05 дугаар сарын 20 ны өдөр

Дугаар: 133

Улаанбаатар хот

Нэг талаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-11, Засгийн газрын XIII байрт байршилтай Зам, тээврийн яам (цаашид “Захиалагч” гэх) нөгөө талаас Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг 15-р хороо 26-19 тоотод байршилтай “Ар Ди Эй Си” ХХК, (цаашид “Зөвлөх” гэх) нь 2016 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн байгуулсан 85 дугаар гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлийн 2.4 дэх хэсгийг үндэслэн нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар тохиролцов.

Нэг. Энэхүү нэмэлт гэрээ нь 2016 оны 03 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан 85 дугаар гэрээний салшгүй хэсэг болно.

Хоёр. 2016 оны 85 дугаар гэрээний дараах заалтуудад дор дурдсанаар нэмэлт, өөрчлөлт оруулав. Үүнд:

- 1) “Тусгай нөхцөлийн 2.4 дэх заалт Тогтоосон хугацаа: 3 Тайлан гаргах хугацаа 2016 оны 2-р улирал – **Эхний шатны тайлан**
2016 оны 4-р улирал – **Дунд шатны тайлан**
2017 оны 3-р улирал – **Эцсийн шатны тайлан**” гэж;
- 2) “Гэрээний тусгай нөхцөлийн 6.4 дэх заалт Төлбөрийг дараах хуваарийн дагуу төлнө”
 - а) “Гэрээний үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх дүнг эхний шатны тайлан ирүүлж эрх бүхий албан тушаалтан, итгэмжлэгдсэн төлөөлөгчдөөр зөвшөөрөгдсөний дараа төлнө.
 - б) Гэрээний үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх дүнг дунд шатны тайланг ирүүлж дараах зүйлсийг хийж дууссан тохиолдолд эрх бүхий албан тушаалтан,



Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

итгэмжлэгдсэн төлөөлөгчдөөр зөвшөөрөгдөж хянагдсаны дараа төлнө.

Үүнд:

- Авто зам, замын байгууламжийг тоолж, бүртгэл хөтлөн паспортжуулах, үл хөдлөх үндсэн хөрөнгийн бүртгэлд авах” журмын төслийг боловсруулж, зохих газруудаар хянуулан эцсийн байдлаар бэлэн болгох;
 - Холбогдох материал, эх үүсвэрүүдийг судлан, тооллого, бүртгэл, судалгаанд шаардлагатай өгөгдөл, мэдээллийг гаргаж авах;
 - Баруун, Зүүн, Төв, Говийн бүсэд-Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийг журамд заасны дагуу газар дээр нь очиж, нүд үзэж тоолох, Тэдгээрийн ашиглалтын одоогийн байдалд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах, Авто зам, замын байгууламжийн өнөөгийн байдлыг бүрэн харуулахуйц зураг авч, бичлэг хийх, Авто замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж байгаа цэгүүдийн байршлыг судалж тогтоох, Журамд заагдсан тусгай маягтуудын дагуу бүртгэл хөтлөх;
 - Нийт авто замыг кадастрын зурагт оруулах;
 - Нийт гүүрийг кадастрын зурагт оруулах.”
- в) “Гэрээний үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх дүнг эцсийн шатны тайланд редакц, шүүмж хийлгэж Зам, тээврийн яамны ШУТЗ-өөр хэлэлцүүлэн дэмжигдсэн тохиолдолд төлнө.” гэж
- г) “Гэрээний үнийн дүнгийн 10 хувьтай тэнцэх дүнг ШУТЗ-ийн шийдвэр гарсан тохиолдолд төлнө” гэж;
- 3) “Гэрээний тусгай нөхцөлийн 2.3 дахь заалт Тогтоосон хугацаа 2: Гэрээний хугацаа 2017 оны 3-р улирал” гэж тус тус өөрчлөн найруулав.

Гурав. Энэхүү нэмэлт гэрээгээр 2016 оны 85 дугаар гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулснаар уг гэрээний нийт болон нэгж үнэд өөрчлөлт орохгүй.

Дөрөв. Нэмэлт гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр үйлчилнэ.

Тав. Нэмэлт гэрээг 4 эх хувь үйлдсэн бөгөөд эдгээр нь хууль зүйн хувьд адил хүчинтэй.

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:


ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:



Д.ДОРЖХАНД

Зам, тээврийн яамны Авто замын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:





Н.АДИЛБИШ


“Ар Ди Эй Си”ХХК-ийн Зөвлөх
Инженер



Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт"-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН


Д. ЗАНДАНБАТ
Зам, тээврийн яамны Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга


М. УГТАХБАЯР
Зам, тээврийн яамны Техник, технологи, нормативын хэлтсийн дарга


Д. ТҮВШИНТУЛГА
Зам, Тээврийн яамны Хууль, эрх зүйн албаны дарга

Хаяг

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Чингисийн өргөн чөлөө-11
ЗГ-ын XIII байр
Зам, тээврийн яам
Утас: 62263171
Факс: 312315

Хан-Уул дүүрэг 15-р хороо 26-19 тоот
"Ар Ди Эй Си"ХХК
Банк: Голомт
Дансны дугаар: 3250004589
Регистрийн дугаар:5808324
Утас: 99074526



Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Ажлын даалгавар



"АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ТООЛЛОГО, БҮРТГЭЛ ХИЙЖ, ПАСПОРТ, КАРТ ХӨТЛӨН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛД АВАХ СУДАЛГАА, БОЛОВСРУУЛАЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭЛТ"-ИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

2015 оны 07 сар 28 өдөр

Дугаар: 01

Улаанбаатар хот

1. Төсөл боловсруулах үндэслэл

1. Монгол Улсын Засгийн Газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /Зорилт-108, Арга хэмжээ-33/ Авто замын салбарт 2015-2016 онд хэрэгжүүлэх эрдэм шинжилгээ, судалгаа, инновацын үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө, Авто замын салбарын норматив баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох сан"-гийн хөрөнгөөр 2015-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө.

2. Төслөөр шийдвэрлэх Асуудал

- Улсын болон орон нутгийн чанартай нийт авто зам, замын байгууламжинд техникийн болон үндсэн хөрөнгийн тооллого явуулна.
- Улсын болон орон нутгийн чанартай нийт авто зам, замын байгууламжийн өнөөгийн байдалд үнэлэлт өгч, дүгнэлт гаргана.
- Улсын болон орон нутгийн чанартай нийт авто замын чиглэл, дугаарлалтыг шинэчлэн паспортжуулж, гүүр бусад хиймэл байгууламжуудад карт хөтөлнө.
- Улсын чанартай нийт авто зам, замын байгууламжуудыг кадастрын зураглалд оруулна.
- Улсын болон орон нутгийн чанартай нийт авто зам, замын байгууламжийн дахин үнэлгээ хийж, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээтэй болгоно.

3. Төслийн бүрдэл бүртгэл

Төсөл нь:

- а) Улсын болон орон нутгийн чанартай нийт Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөх судалгаа, боловсруулалтын нэгдсэн тайлан, дүгнэлт
- б) "Авто зам, замын байгууламжийг тоолж, хөтлөн паспортжуулах, үл хөдлөх үндсэн хөрөнгийн бүртгэлд авах" журмыг боловсруулж, батлуулсан

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

байх

в) Энэхүү журмын дагуу хийсэн иж бүрэн тооллогын материал,

г) Тооллогын дагуу хийсэн бүртгэл, түүнийг программд оруулан хөтөлсөн паспорт, карт,

д) Салбарын мэргэжлийн байгууллагууд, инженер тенхикийн ажилтан, авто зам хэрэглэгчид ашиглаж болохуйц, энгийн, тогтмол сайжруулалт, хөгжүүлэлт хийх боломжтой Монгол улсын авто замын сүлжээний цахим сан,

е) Үл хөдлөх үндсэн хөрөнгийн бүртгэл,

ё) Авто зам, замын байгууламжийн кадастрын зураглал-аас бүрдэнэ.


Төслийн хүрээнд дараах ажлуудыг хийж, хэрэгжүүлсэн байна.

Үүнд:

1. Зам тээврийн болон Сангийн сайдын хамтран баталсан Төслийн (а)-д заагдсан журам гаргах.
2. Авто зам, замын байгууламжийг газар дээр нь нүд үзэж тоолох.
3. Авто зам, замын байгууламжийн ашиглалтын байдалд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах.
4. Авто замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж байгаа цэгүүдийн байршлыг судалж тогтоох.
5. Журамд заагдсан тусгай маягтуудын дагуу бүртгэл хөтлөх.
6. Авто зам, замын байгууламжийн байдлыг бүрэн харуулж чадахуйц зураг авч, бичлэг хийх.
7. Талбайд дээр цуглуулсан материалд боловсруулалт хийж зам, замын байгууламжийн бүртгэлмэдээлийн цахим санд оруулах, замын паспорт, гүүрийн карт хөтлөх.
8. Авто зам, замын байгууламжийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг хөрөнгийн үнэлгээний хараат бус байгууллагаар хийлгэх.
9. Олон улс, улсын чанартай зам, замын байгууламжуудыг кадастрын зураглалд оруулах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэх.
10. Авто зам, замын байгууламжийг үл хөдлөх үндсэн хөрөнгийн бүртгэлд авч, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээтэй болгох.
11. Хот, суурингуудын хоорондох албан ёсны тарифт зайг шинэчлэн тогтоох.
12. Авто замын чиглэл тогтоож дугаар олгох асуудлыг шинэчлэн боловсруулах.


4. Төслийн хүрээнд боловсруулах эцсийн үр дүн

- “Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа,



Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

	<p>боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажил хийснээр Монгол Улсын авто замын сүлжээн дэх улсын болон орон нутгийн чанартай нийт авто зам, замын байгууламж нь албан ёсоор үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд орж, эдийн засгийн эргэлтэд орох нөхцөл бүрдэнэ.</p> <ul style="list-style-type: none">- Авто зам, замын байгууламжийн бүртгэл мэдээллийн энгийн, ойлгомжтой, хэн ч ашиглаж болохуйц цахим сан бий болно.- Авто замын сүлжээний ашиглалт сайжирна.
5. Төслийг хэрэгжүүлэх байгууллага	сонгон шалгаруулалтаар эрх авсан хуулийн этгээд
6. Төслийг боловсруулж эхлэх хугацаа дуусах хугацаа	2015 оны III дугаар улирал /Гэрээ байгуулсан өдрөөс/ 2016 оны IV дүгээр улирал
7. Төсөлд шаардагдах Хөрөнгийн хэмжээ	<ol style="list-style-type: none">1. Гадаад болон үндэсний судалгаатай уялдуулах боломжийг судлах.2. Судалгааг боловсруулахад удирдан зохион байгуулах.3. Судалгаанд зарцуулах нийт хөдөлмөр зарцуулалтыг тооцох.4. Судалгаа боловсруулахад ажиллах мэргэжилтний нэг өдрийн дундаж цалинг тооцох зэргийг тооцож үнийн саналыг боловсруулж гаргана.5. Судалгааны төсөлд редакц шүүмж хийлгэх.
8. Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none">- Сүүлийн жилүүдэд авто замын сүлжээний бүртгэл, мэдээллийн чиглэлээр хийгдсэн туршилт судалгааны ажлын үр дүн, тайлан, дүгнэлттэй судалгааны ажлыг нягт уялдуулах.- Төслийн үр дүнг сайжруулахын тулд бусад шаардлагатай онолын судалгаа хийж, гадаад орнуудын сайн туршлагыг судлах, ашиглах.- Судалгааны ажлын үр дүнг цаашид ашиглах, байнга хөгжүүлэх боломжийг бүрэн хангасан байх ба судалгааны ажлын хүрээнд цуглуулсан мэдээлэл, судалгааны үр дүн, тайлан, холбогдох програм хангамж нь Зам, тээврийн яамны өмч байна.- Судалгааны ажлын тайланг “Эрдэм шинжилгээний ажлын тайлан. Бүтэц, шаардлага.” MNS 2492 : 2004 стандартын дагуу гүйцэтгэнэ.- Монгол улсын нийт авто зам, гүүрт хийсэн 1971, 1982 онуудын тооллогын материал судлах;- Улсын чанартай замуудын техник ашиглалтын түвшин тогтоосон /TAT/ 2002 оноос хойших материалыг судалж ашиглах.



Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

- Зам, тээврийн яаманд байгаа улс, орон нутгийн чанартай замуудын өгөгдлийг ашиглах.
- Сүүлийн жилүүдэд /1982 оноос хойш/ ашиглалтад орсон авто зам, гүүрийн улсын комиссын акт, замын паспорт, гүүрийн картыг ашиглах;
- Зам, тээврийн яам, Төрийн өмчийн хорооны бүртгэлд байгаа зам, замын байгууламжийн үндсэн хөрөнгийн бүртгэлийг судлах;
- Зам, тээврийн хөгжлийн төв болон Авто замын хариуцагч байгууллагад /АЗЗА-нуудад/ байгаа бүртгэл, мэдээлийг ашиглах;
- Орон нутгийн чанартай зам, замын байгууламжийн бүртгэлийг шинэчлэн гаргах;
- “Монгол улсын Авто замын сүлжээ” номын эх бэлтгэх;
- Авто замын код эхлэх, төгсөх цэгийн нэр батлах тухай Дэд Бүтцийн Сайдын 1994 оны 165 дугаар тушаалыг шинэчлэн боловсруулах.
- Зам, тээврийн яамнаас томилсон ажлын хэсгээр судалгааны ажлын төсөлд редакц, шүүмж хийлгэнэ.
- Төсөлд хараат бус аудитын байгууллагаар аудит хийлгэсний дараа Зам, тээврийн салбарын шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хуралд оруулж хэлэлцүүлэх, Зам, тээврийн яамаар уламжлуулан Засгийн газарт оруулан шийдвэр гаргуулах;

9. Төсөл хэрэгжүүлэгчийн Чадавхи

1. Төсөл хэрэгжүүлэгч нь Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд болох аж ахуйн нэгж эсвэл төрийн бус байгууллага байна
2. Зөвлөх үйлчилгээ, судалгааны үйл ажиллагаа явуулж байсан туршлагатай.
3. Багийн ахлагч нь автозамын салбарын зөвлөх инженер болон доктор, тухайн салбарт 10-аас дээш жил ажилласан, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байсан, Зөвлөх үйлчилгээ, эрдэм шинжилгээ, судалгааны ажил 3-аас доошгүй жил хийж байсан туршлагатай байна.
4. Багийн үндсэн гишүүдэд дараах шаардлагыг тавина. Үүнд: Тухайн салбарын магистр, мэргэшсэн зөвлөх тухайн салбартаа 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай гишүүн 2-оос доошгүй, судалгаа шинжилгээний ажил 1-ээс доошгүй жил хийж байсан туршлагатай гишүүн 2-оос доошгүй байна.
5. Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

10. Тайлан

Төсөл хэрэгжүүлэгч дараах үндсэн гурван тайлангийн баримт бичгийг боловсруулна.

- Ажлын явцын тайлан: Гэрээ байгуулсан өдрөөс хойш 1 сарын хугацаанд хэрэгжүүлсэн ажлын явц, цаашид хийгдэх ажлын төлөвлөгөөг танилцуулна.

- Дунд шатны тайлан: Судалгааны төслийг боловсруулж редакц, шүүмж хийлгэн хянагдана.

Эцсийн шатны тайлангийн төсөл: Эцсийн шатны тайланг салбарын зөвлөх инженер болон эрдэмтэн, докторууд хянаж судалгааны төслийг эцэслэн боловсруулж Зам, Тээврийн Яамны Шинжлэх ухаан техникийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн байна.

СБТХАГ-ЫН ДАРГА

ХЯНАСАН

С. АДЪЯАСҮРЭН

АЗТБХЗГ-ЫН ДАРГА

Д. ДОРЖХАНД

ТТНХ-ЫН ДАРГА

Ө. ОДГЭРЭЛ

СБТХАГ-ЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Д. ГЭРЭЛНЯМ

АЗТБХЗГ-ЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Н.СУГАРЖАВ

ТЗУХЭЗГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

Л.БАТСҮХ

БОЛОВСРУУЛСАН:

ТТНХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

С. ЭРДЭНЭСАЙХАН



Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Удирдамж

БАТЛАВ.

ЗТЯ-НЫ АВТО ЗАМЫН ТЭЭВРИЙН
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА



Д.ДОРЖХАНД

**АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ТООЛЛОГО, БҮРТГЭЛ, ҮЗЛЭГ,
ХЭМЖИЛТИЙГ ГАЗАР ДЭЭР НЬ ГҮЙЦЭТГЭХ УДИРДАМЖ**

Зам, тээврийн яам, “Ар Ди Эй Си” ХХК /цаашид Зөвлөх гэх/-ийн хооронд байгуулсан “Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт”-ын Зөвлөх үйлчилгээний гэрээг үндэслэн Зөвлөх батлагдсан Ажлын даалгаврын хүрээнд Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл, хэмжилтийг дараах дэс дараалал, арга аргачлалаар гүйцэтгэнэ.

А. ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1. Олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжийн паспортын бүх үзүүлэлтийн болон Орон нутгийн чанартай замын чиглэл, уртын үзлэг, тооллого, бүртгэл, хэмжилтийг Баруун, Төвийн, Говийн, Зүүн гэсэн 4 бүсэд хуваан гүйцэтгэнэ.
2. Нэг удаагийн явалтаар 1 бүсийг бүрэн дуусгах ба нийтдээ 3-4 сард багтаан хээрийн ажлыг дуусгана.
3. Эхний тооллого бүртгэлийн ажилд нэгдсэн баг ажиллах ба цаашидын үйл ажиллагааны аргачлал, зарчмыг тогтоосны үндсэн дээр бусад бүсүүдэд багууд нэгэн зэрэг ажиллана.
4. Хээрийн ажилд гарахын өмнө Багийн ахлагч нар хариуцан өөрийн багт ногдсон замын паспорт, гүүр, хоолойн картыг ЗТЯ-д байгаа мэдээллийн хэмжээнд урьдчилан боловсруулан бэлэн болгож, үүнийг үндэслэн тооллого, бүртгэлийн 8 маягыг бөглөж бэлтгэнэ. Хээрийн ажилд явахдаа энэхүү бэлтгэсэн материалдаа тодотгол хийж, нягтлаад, бүрэн шинэчлэн хүлээлгэж өгнө.
5. Багийн ахлагч нар талбайн тооллого, хэмжилт, судалгаанд ажиллах бүх хүмүүст ажиллах зааварчилгаа өгч, сургалт зохион байгуулна.
6. Аймгийн засаг дарга нарт (аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэс, зам тээврийн улсын байцаагч, газрын харилцааны мэргэжилтэн г.м хүмүүс) болон зам хариуцсан байгууллагын удирдлагуудад хандсан албан бичгийг ЗТЯ ба ЗТХТ-өөс гаргуулан авч, урьдчилан явуулна. Мөн аймгаас сумдын Засаг дарга, газрын харилцаа, байгаль орчны мэргэжилтэн нарт зохих чиглэл, даалгавар өгүүлнэ.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

7. Хилийн зурваст ажиллах үед элдэв саатал гаргахгүйн тулд ХХЕГ-аас зохих зөвшөөрлийг авч, хилийн холбогдох анги, заставт урьдчилан хүргүүлнэ.

Б. БАГИЙН БҮТЭЦ

Нэгдсэн баг:

Нэгдсэн багийн ахлагч-1
Багийн ахлагч-2
Гүүрийн инженер-1
Хэмжилтийн инженер-3
Мэдээлэл боловсруулах инженер-2
Туслах инженер /Жолооч-3

1, 2, 3-р баг тус бүр:

Багийн ахлагч:
Хэмжилтийн инженер
Туслах инженер/ Жолооч

В. БАГТ ХАНГАХ, БАЙВАЛ ЗОХИХ БАГАЖ ХЭРЭГСЭЛ

1. Тооллого, хэмжилтийн шаардлага хангасан GPS-1ш
2. Бичлэг хийдэг зургийн аппарат-1ш
3. Notebook- 2ш
4. ...GB-ийн багтаамжтай Flash Disc-1ш
5. 20м-ийн рулетка/ лазерметр -1ш
6. Шаардлагатай хүснэгт, маягтууд-1ком
7. Бичиг, хэргийн зүйлс-1ком
8. Найдвартай холбооны хэрэгсэл-1ком
9. Интернетийн утасгүй сүлжээний модем-1ш

Г. ТООЛЛОГО, БҮРТГЭЛИЙГ ХЭРХЭН ГҮЙЦЭТГЭХ

1. Аливаа замын тооллого, бүртгэлийг заавал эхлэлийн цэгээс нь эхэлж гүйцэтгэнэ.
2. Авто зам, замын байгууламжийн тооллого бүртгэлийг хийх, тэдгээрийн ашиглалтын байдалд үнэлгээ дүгнэлт өгөх ажилд батлагдсан маягтуудыг ашиглана.
3. Замын паспорт, гүүрийн картад газар орны болон гол усны нэрийг оруулахдаа зам хариуцагч байгууллагын ажилтнууд, нутгийн иргэд, орон нутгаас сайтар асууж тодруулна.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

4. Цэгүүдийн солбицолыг хэмжих
 - Замын км тутамд, мөн хэвтээ муруйн эхлэл, төгсгөлд, шаардлагатай гэж үзсэн зарим онцлог цэг дээр
 - Аймгын төвөөр дайрч байгаа улсын чанартай авто замуудын огтлолцлын цэгийн солбицол
 - Гүүрийн солбицолыг түүний зорчих хэсгийн эхлэл, төгсгөлд замын тэнхлэгийн шугам дээр,
 - Хиймэл байгууламжийн солбицолыг явж буй чиглэл талын буюу баруун гар талын толгойн голд GPS-ээр хэмжиж, үзүүлэлтүүдийг гаргацтай бичнэ. (Бүх багуудын хэрэглэх GPS-ийн үзүүлэлт ба тохиргоо ижил байх ёстой).
5. Уртыг хэмжих
 - Замын уртыг GPS-ээр нарийвчлалтай хэмжинэ.
 - Гүүрийн уртыг түүний зорчих хэсгийн 2 төгсгөлийн хооронд,
 - Хоолойн уртыг 2 толгойн гадна ирмэгийн хооронд, \pm 5см-ийн нарийвчлалтай рулеткаар хэмжиж, үзүүлэлтүүдийг гаргацтай бичнэ..
6. Фото зураг авах
 - Замын ерөнхий байдлын зургийг явж буй чиглэл рүү харсан байдлаар Км тус бүрийн эхэнд, дурангийн нэг тохиргоон дээр фокус сайтай авна.
 - Замын ерөнхий байдлын зургийг явж буй чиглэл рүү харсан байдлаар Км тус бүрийн эхэнд, дурангийн нэг тохиргоон дээр фокус сайтай авна.
 - Гүүрийн зургийг дээр, доор 2 байрлалд, эхлэлийн цэгээс нь мөн явж буй чиглэл рүү харсан байдлаар, бүх хийц, элементийг оруулж авна.
 - Ус зайлуулах хоолойн зургийг эхлээд ус орох талаас, дараа нь гарах талаас нь бүх хийц, элементийг оруулж авна.
 - Автобусны зогсоол, амрах талбай, жорлон, хогийн цэгийн зургийг нэг бүрчлэн авна.
 - Замын дагууд орших бусад байгууламж, ШТС, хоолны газар зэргийн зургийг ерөнхий планаар авна.
 - Даваануудын зургийг орой дээрээснь 2 тийш харсанаар авна.
 - Шаардлагатай гэж үзсэн хэсгүүдэд богино хэмжээтэй бичлэг хийнэ.
7. Өвөл, зунд 2 өөр газраар явдаг зарим замыг албан ёсоор улсын чиглэлд орсон хэсэгт нь тоолж бүртгэнэ.
8. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн хэвийн явагдах боломжгүй болсон, ашиглагдахаа больсон, актлах шаардлагатай зам, гүүрүүдийн жагсаалт гаргах
9. Хөдөлгөөний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж байгаа буюу зам тээврийн осол гарах магадлал өндөртэй цэгүүдийн байршлыг орон нутгийн

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Замын цагдаагийн байгууллагаас авсан мэдээ, материалыг үндэслэн судалж тогтооно.

9. Багууд өдөр тутам хийсэн ажлынхаа тэмдэглэлийг тогтмол хөтөлж байх ба тэдгээрийг эцсийн тайлан боловсруулахад ашиглана.
10. Алдаа мадагтай юм уу эргэлзээтэй зүйл илэрсэн бол тэдгээрийг дахин нягталж үзэх, буцаж хэмжих юм уу шалгах замаар асуудлыг шийдвэрлэх, шинээр авсан зөв мэдээлэл ба үзүүлэлтийг, боловсруулах багт яаралтай илгээнэ.

Д. СУУРИН БОЛОВСРУУЛАЛТЫН АЖЛУУД

1. Талбайд ажилласан багуудаас ирүүлж байгаа бүртгэл, мэдээллийн бэлэн болсон өгөгдлүүдийг хүлээн авч боловсруулалт хийж, программд оруулах ажлыг гүйцэтгэнэ.
2. Бүрэн боловсруулалт хийгдэж, хянагдсан мэдээллийг зам, замын байгууламжийн бүртгэл мэдээллийн санд бүртгэнэ.

Хянасан:

Зам, Тээврийн яамны Техник, технологи,

нормативын хэлтсийн дарга

Авто замын тээврийн хэрэгжилтийг

зохицуулах газрын албаны дарга

Авто замын тээврийн хэрэгжилтийг

зохицуулах газрын мэргэжилтэн

Зам, Тээврийн яамны Техник, технологи,

нормативын хэлтсийн мэргэжилтэн

 М. Угтахбаяр

 Д. Загграднаа

 Ц. Хосгэрэл

 С. Эрдэнэсайхан

ТӨСӨЛ

Сангийн сайд,Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны –р сарын –ний ... тоот тушаалын хавсралт

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ТООЛЛОГО, БҮРТГЭЛ ХИЙХ, ҮНДСЭН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛД АВАХ ЖУРАМ

1. Ерөнхий зүйл

- 1.1. Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийх үндсэн хөрөнгийн бүртгэлд авах энэхүүжурмыг /цаашид журам гэх/, Монгол УлсынТөрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11, 70, 71-р зүйлүүд, Авто замын тухай хуулийн, 10-р зүйлийн 1.1, 1.10-рзаалтууд, 17-р зүйлийн 2, 4-р заалтууд, 27-р зүйлийг үндэслэн боловсруулав.
- 1.2. Журмын зорилго нь олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын автозам, тэдгээрт байгаа гүүрийн тооллого хийж, бүртгэлийг нарийвчлан хөтлөх, орон нутгийн чанартай замын бүртгэлийг гаргах, авто зам, гүүрийн дахин үнэлгээг хийж үндсэн хөрөнгийн бүртгэлд авах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэхэд оршино.
- 1.3. Энэхүү журмын зохицуулалтанд Монгол Улсын нутаг дэвсгэр дэх олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж хамрагдана.
- 1.4. Авто зам, гүүрийн тооллого, бүртгэлхийх, паспорт, карт хөтлөх ажил (цаашид тооллого, бүртгэл гэх)-ыг энэ чиглэлээр мэргэшсэн, тогтмол үйл ажиллагаатай мэргэжлийн байгууллага [цаашид Бүртгэл хариуцсан мэргэжлийн байгууллага (БХМБ) гэх] эрхлэн гүйцэтгэх ба жил бүршинэчлэлт хийж, бүртгэлийг баталгаажуулж байна.

2. Үндсэн ойлголт, тодорхойлолтууд

Энэхүү журманд дараах ойлголт, тодорхойлолтууд ашиглагдана. Үүнд:

Тоон үзүүлэлтүүд:

- Авто замын тоон үзүүлэлт нь хучилттай замын хувьд өнгөн хучлагын хэвтээ тэнхлэг дэх шугаман урт ба өргөнөөр, хөрсөн замын хувьд ирээдүйд зам төлөвлөх боломжтой одоо явж байгаа трассын уртаар,
- Замын байгууламжийн тоон үзүүлэлт нь тухайн байгууламжийн өндөр, өргөн, нүхний тоо ба хэмжээгээр тус тус тодорхойлогдоно.

Анхны тооллого, бүртгэл гэж Зам, тээврийн хөгжлийн яамны хэмжээнд өнөөгийн байдлаар хийгдсэн авто зам, гүүрийн бүртгэл, паспорт, карт, үндсэн хөрөнгийн бүртгэл зэргийг хэлнэ.

Төлөвлөгөөт тооллого, бүртгэл гэж авто зам, замын байгууламжийн анхны тооллого, бүртгэлийн дараа гарсан өөрчлөлтүүдийг газар дээр нь явж нарийвчлан хэмжиж тусгасан, авто зам, гүүрийн техникийн тооллого, бүртгэл, паспорт карт, үндсэн хөрөнгийн бүртгэлийг хэлнэ. Төлөвлөгөөт тооллого, бүртгэлийг 4 жил тутам 1 удаа хийнэ.

Төлөвлөгөөт бус тооллого, бүртгэл гэж, авто зам, гүүр шинээр ашиглалтад орох үед, зарим объектод их засвар, шинэчлэлт, хүчитгэл хийсний дараа, эсхүл тухайн объект их хэмжээгээр эвдэрсэн, устаж үгүй болох нөхцөл үүссэн тохиолдолд, мөн эзэмшигч солигдсон үед хийгдэх үйл ажиллагааг хэлнэ.

Тооллого бүртгэлийн архив (цаашид БХМБ-ийн архив гэх)гэжАвто зам, гүүрийн тооллого, бүртгэл, паспорт, карт хөтлөхтэй холбоотойгоор цуглуулсан, боловсруулж баталгаажуулан БХМБ-д хугацаагүй, тогтмол, тогтоосон журмын дагуу хадгалагдах байгаа баримт бичгийг хэлнэ.

3. Тооллого, бүртгэлийн зохион байгуулалт

- 3.1** Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус тооллого, бүртгэлийг Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны (цаашид Захиалагч гэх) төв байгууллагаас холбогдох хуулийн дагуу сонгон шалгаруулсан хуулийн этгээд (цаашид Гүйцэтгэгч гэх)-ээр гэрээгээр гүйцэтгүүлнэ.
- 3.2** Захиалагч нь гэрээний дагуу Гүйцэтгэгчид холбогдох анхны тооллого, бүртгэлийг гэрээндзаасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 3.3** Захиалагч нь авто замын төлөвлөгөөт тооллого, бүртгэлийг гүйцэтгэх аргачлал, удирдамжийг баталж өгөхийн хамт төрийн захиргааны бусад байгууллага, аймаг, сумдын засаг захиргааны байгууллагуудаас холбогдох мэдээлэл авахад дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.
- 3.4** Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын төлөвлөгөөт тооллого, бүртгэлийг Гүйцэтгэгч өөрөө гардан хийх ба харин нийслэлийн авто зам болон орон нутгийн чанартай замын бүртгэлийг тухайн замын эзэмшигч хийж, Гүйцэтгэгч хянаж, хүлээн авна.
- 3.5** Энэхүү журмын дагуу аль төрлийн тооллого, бүртгэл явуулахтай уялдуулан тухай бүрд нь ажлын төлөвлөгөө, аргачлал, удирдамж, зардлын тооцоог боловсруулан Захиалагчаар батлуулж мөрдөнө.
- 3.6** Энд хавсаргасан жишиг маягтууд нь тооллого, бүртгэлийн үндсэн маягтууд болох бөгөөд шаардлагатай тохиолдолд Гүйцэтгэгч нь Захиалагчтай зөвшөлцсөн зохих өөрчлөлт оруулж болно. (Хавсралтуудыг үз)
- 3.7** Авто замын паспорт, гүүр хоолойн картыг Монгол УлсынАвто замын тухай хуулийн 27.4-р заалтын дагуу Олон улс, улсын болон тусгай зориулалтын авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, мэдээлэх журмын дагуу хөтлөнө.
- 3.8** Тооллого, бүртгэлийн бүх материалыг электрон болон цаасаар үйлдэж, Захиалагч байгууллагад тооллого, бүртгэлийн сан бий болгох бөгөөд хуулбар хувиудыг Зам хариуцагч болон БХМБ-д тус тус хүлээлгэн өгнө. Аливаа өгөгдөлд зөрүү гарсан тохиолдолд цаасан хувийн өгөгдлийг хүчинтэйд тооцно. Тооллого бүртгэлийн санд байгаа материалыг Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр тараах, хэвлэн олшруулахыг хориглоно.

3.9 Нийслэлийн болон орон нутгийн чанартай авто замд тооллого, бүртгэл явуулах журмыг гаргахдаа Монгол Улсын Авто замын тухай хуулийн холбогдох заалтууд болон энэхүү журмын ерөнхий зарчмыг баримтлана.

4. Тооллого, бүртгэлийн үйл ажиллагаа

4.1. Тооллого, бүртгэл хийх, паспорт, карт хөтлөх, үндсэн хөрөнгийн бүртгэлд авахтай холбогдолтой эрх зүйн баримт бичгүүд, Захиалагчаас өгсөн бүх мэдээлэл, өгөгдлүүдийг нарийвчлан судалж, хийгдэх бүх ажлыг түүний ач холбогдол, цар хэмжээ, шаардагдах цаг хугацаа, хүн хүчнээс хамааруулан эрэмбэлнэ.

4.2. Ажлын даалгаврын заалт бүрийг нарийвчлан судалж үзсэний үндсэн дээр тодруулах, магадлах зүйл байвал захиалагчид тавьж хариу авна.

4.3. Тооллого бүртгэлийн нийт зардлын тооцоо, тооллого, бүртгэлийн явцад хийх ажлын төлөвлөгөө, аргачлал, удирдамж, зэргийг боловсруулан батлуулна.

4.4. Ажилд шаардлагатай автомашин, компьютер, төрөл бүрийн хэмжилтийн багаж хэрэгсэл, дүрс бичлэгийн төхөөрөмж, найдвартай холбооны хэрэгсэл, аж ахуйн болон бичиг хэргийн хэрэгцээт зүйлсийг бэлтгэн, тохиромжтой ажлын байрыг тоноглож бэлэн болгоно.

4.5. Шинээр тооллого, бүртгэл хийхдээ урьдах тооллого, бүртгэлийн материалыг газар дээр нь тулган үзэж, гарсан өөрчлөлт бүрийг харьцуулсан байдлаар гаргаж гүйцэтгэнэ. Үүнтэй уялдуулан тооллого, бүртгэлийн жишиг маягтыг шаардлагатай гэж үзвэл шинэчилж болно.

4.6. Урьд нь тооллого, бүртгэлд хамрагдаагүй, мөн паспорт, карт нь дутуу, эсхүл алдаатай хөтлөгдсөн объектын материалыг хянан үзэх ба нөхөж гүйцээнэ.

4.7. Гүйцэтгэгчийн талбайд ажиллах мэрэгжилтэн нь зам, замын байгууламжид үзлэг хийх, геометр хэмжээсийг шалгах, эвдрэлийн байдлыг тогтоох, ашиглалтын бэлэн байдалд үнэлэлт өгөх, хөрөнгийн үнэлгээ хийхэд шаардлагатай өгөгдөл ба мэдээллийг цуглуулах, замын өнөөгийн байдлыг харуулсан зураг авч бичлэг хийх, зохих бүртгэл маягт, хэмжилтийн гар зураглал зэргийг бүрэн хөтлөх, цуглуулсан материал ба мэдээллийг цахим хэлбэрт оруулж хадгалах, суурин боловсруулалт хийж буй баг руу илгээх, тэндээс шаардсан үед алдаа мадагтай юм уу эргэлзээтэй зүйлсийг дахин нягталж хариу өгөх, нэмэлт мэдээллээр хангах зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

4.8. Хээрийн хэмжилт, тооллого, бүртгэл, судалгааны материалд суурин боловсруулалт хийж, үндсэн баримт материалуудыг эцэслэн боловсруулж, хугацаат тайлангуудыг бэлтгэж гаргана.

5. Авто зам, замын байгууламжид дахин үнэлгээ хийх, үндсэн хөрөнгийн бүртгэлд авах

- 5.1.** Монгол улсын авто зам, гүүрийн барилга байгууламжийн дахин үнэлгээг Олон улсын үнэлгээний стандарт, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт, Монгол улсын үнэлгээний хууль, Зам гүүрийн барилга байгууламжийн нэгжийн жишиг төсөвт өртөг, норм норматив болон бусад холбогдох эрх зүйн актуудад үндэслэн хийнэ.
- 5.2.** Авто зам, замын байгууламжийн шинэчилсэн үнэлгээг Монгол улсын холбогдох эрх зүйн актуудын дагуу үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний хөндлөнгийн компаниар хийлгэнэ. Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний байгууллага нь Авто зам, замын байгууламжийн үнэлгээ хийх аргачлалаа Захиалагч байгууллагатай зөвшөлцөнө
- 5.3.** Зам, гүүрийн үнэлгээ хийхдээ тухайн авто замд тооллого, үзлэг хэмжилт хийсэн мэргэжлийн багийн үнэлэлт, дүгнэлтийг ашиглана.
- 5.4.** Шинэчилсэн үнэлгээг хийхдээ инфляци, валютын ханшны өсөлт, үнийн өсөлтийн индекс, бүрэн сэргээн босголт, элэгдлийн хувь, зарцуулсан арчлалт, засварын хөрөнгийн хэмжээ г.м санхүү, эдийн засгийн болон авто зам, гүүрийн урт, насжилт, ашиглалтын байдлын үнэлгээ, г.м техник-ашиглалтын үзүүлэлтүүдтэй уялдуулан гүйцэтгэнэ.
- 5.5.** Дахин үнэлгээг хийхдээ тухайн объектыг хөрөнгө оруулалтын ямар хэлбэрээр барьж байгуулсан, засаж сэргээсэнтэй нь уялдуулан, барилгын ажил гүйцэтгэх гэрээ, Захиалагч байгууллага дээр байгаа материалуудыг үндэслэн авто зам, гүүрийн нарийвчилсан зураг төслийн үнэ, барилгын ажлын хяналтын зардлын хэмжээгээр тухайн объектын үнэлгээний нийт дүнг нэмэгдүүлж болно.
- 5.6.** Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.3, Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллого зохион байгуулах тухай Сангийн сайдын 2016 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 126 тоот тушаалын дагуу Авто зам, замын байгууламжийн тооллого, дахин үнэлгээний дүнг хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргаж, НББ-ийн хуулийн 15.1,2 заалт, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.8.3 заалтыг үндэслэн Санхүүгийн тайланд тусган хэрэгжүүлнэ.
- 5.7.** Дахин үнэлгээг хийж, авто зам, гүүрийн өнөөгийн бодит үнэ цэнийг тодорхойлсон, хөндлөнгийн аудитын байгууллагаар хянагдаж, Захиалагч байгууллагаар зөвшөөрөгдөн тогтоосон өртөг нь авто зам, гүүрийг улсын бүртгэлд авах үнэ болно.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Журмын хавсралтууд

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэлийн маягтуудын жагсаалт

д/д	Тооллогын бүртгэл гаргах зам, замын байгууламжийн нэр	Маягтын дугаар
1	Олон улс, улсын чанартай замуудын тооллого, бүртгэл Хучилтын төрөл	ТБ-01 ТБ-01.01
2	Олон улс, улсын чанартай замууд дахь гүүрүүдийн тооллого, бүртгэл Насжилт, овор хэмжээ	ТБ-02 ТБ-02.01
3	Олон улс, улсын чанартай замууд дахь хоолойнуудын тооллого, бүртгэлийн товчоо	ТБ-03
4	Олон улс, улсын чанартай замд байгаа тэмдэг, тэмдэглэгээ, заалт, тоноглолын тооллогын бүртгэл	ТБ-04
5	Замын бусад /давуулах далан, хамгаалалтын хийцүүд, бэхэлгээтэй шуудуу, уулын шуудуу г.м/ байгууламжууд	ТБ-05
6	Замын дагуух үйлчилгээний /зогсоолын талбай, нийтийн үйлчилгээний газрууд, замын хэсгүүд, төлбөр хураах цэг, хөд.эрчмийн тооллогын цэг, пүү г.м/ объектууд	ТБ-06
7	Замын зурвас дахь ногоон байгууламжууд	ТБ-07
8	Цас, халиа тошин, уруйнаас хамгаалсан хийц	ТБ-08

Олон улс, улсын чанартай замуудын тооллого, бүртгэлийн нэгдсэн товчоо Авто зам, замын байгууламжуудын тооллогын бүртгэл ТБ-01

No	Улсын чанартай авто замын чиглэлийн дугаар	Авто замын чиглэлийн нэр	Замын дугаар	Замын нэр	Яамны бүртгэлд байгаа Урт. Км	Хэмжилтээр гарсан бодит урт. Км	Хучилтын төрөл	Замын ангилал	Хөндлөн огтлол		Замын зэрэг	Ашиглалтад орсон он	Анхны өртөг	Засвар хийсэн		Нийт өртөг Сая ₮ (8+10)	Замын уур амьсгалын бүс	Ашиглалтын байдлын дундач үнэлгээ
									Зорчих хэсгийн өргөн /м/	Хөвөөний өргөн /м/				Он	Зарцуулсан хөрөнгө			

Олон улс, улсын чанартай замын хучлагын төрөл Авто зам, замын байгууламжуудын тооллогын бүртгэл ТБ-01.01

No	Улсын чанартай авто замын чиглэлийн дугаар	Авто замын чиглэлийн нэр	Замын дугаар	Замын нэр	Яамны бүртгэлд байгаа Урт. Км	Хэмжилтээр гарсан бодит урт. Км	Хучлагатай			Хучлаггүй			НИЙТ УРТ	Ашиглалтын байдлын дундач үнэлгээ
							Асфальтбетон	Цементбетон	Хөнгөвчилсэн	Бүгд	Хайрган	БҮГД		

Олон улс, улсын чанартай замууд дахь гүүрүүдийн тооллого, бүртгэл Замын байгууламжуудын тооллогын бүртгэл ТБ-02

No	Улсын чанартай авто замын чиглэлийн дугаар	Авто замын чиглэлийн нэр	Замын дугаар	Замын нэр	Яамны бүртгэлд байгаа Урт. Км	Хэмжилтээр гарсан бодит урт. Км	Үндсэн хийцүүдийн материал												Гүүрийн					
							Төмөрбетон						Мод											
							Жижиг (25м-ээс бага уртай)		Дунд (25-100м уртай)		Том (100м-ээс дээш уртай)		Дүн		Том (100м-ээс дээш уртай)		Дүн			Жижиг (25м-ээс бага уртай)		Дунд (25-100м уртай)		Том (100м-ээс дээш уртай)
							Тоо (ш)	Бүгд урт (м)	Тоо (ш)	Бүгд урт (м)	Тоо (ш)	Бүгд урт (м)	Тоо (ш)	Бүгд урт (м)	Тоо (ш)	Бүгд урт (м)	Тоо (ш)	Бүгд урт (м)	Тоо (ш)	Бүгд урт (м)	Тоо (ш)	Бүгд урт (м)	Нийт тоо (ш)	Нийт урт (м)

Олон улс, улсын чанартай замууд дахь гүүрүүдийн насжилт, овор хэмжээ Замын байгууламжуудын тооллогын бүртгэл ТБ-02.01

No	Улсын чанартай авто замын чиглэлийн дугаар	Авто замын чиглэлийн нэр	Замын дугаар	Замын нэр	Зам хариуцагч байгууллага	Авто замын дугаар	Гүүрийн төрөл	Гүүрийн нэр /байршил/	Байршлын солилцоо	Ашиглалтад орсон Огноо	Гүүрийн овор хэмжээ, Г...	Гүүрийн урт, у/м
----	--	--------------------------	--------------	-----------	---------------------------	-------------------	---------------	-----------------------	-------------------	------------------------	---------------------------	------------------

Олон улс, улсын чанартай замууд дахь ус өнгөрүүлэх хоолойн тооллого, бүртгэлийн товчоо Авто зам, замын байгууламжуудын тооллогын бүртгэл ТБ-03

No	Улсын чанартай авто замын чиглэлийн дугаар	Авто замын чиглэлийн нэр	Замын дугаар	Замын нэр	Яамны бүртгэлд байгаа Урт. Км	Хэмжилтээр гарсан бодит урт. Км	Нүхний хэлбэр						Хоолойн нийт тоо (А+Б+В+Г+Д)
							Дугуй			Дөрвөлжин			
							Төмөрбетон (А)	Төмөр /ган/ (Б)	Бүгд	Төмөрбетон (В)	Мод (Г)	Чулуу (Д)	Бүгд

Тодруулга: Хоолойн энэ товчоонд, дугуй хоолойн хувьд нүхний тоо, диаметр, дөрвөлжин хоолойн хувьд нүхний тоо, хөндлөн огтлолын хэмжээ, хоолойн ус орох гарах амсарын бэхэлгээ, хоолойн ашиглалтын байдал зэргийг нарийвчлан гаргасан хүснэгтүүдийг хавсаргана.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт"-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Авто зам, замын байгууламжуудын тооллогын бүртгэл ТБ-04

ОЛОН УЛС, УЛСЫН ЧАНАРТАЙ ЗАМД БАЙГАА ТЭМДЭГ, ТЭМДЭГЛЭГЭЭ, ЗААЛТ, ТОНГОЛЫН ТООЛОГЫН БҮРТГЭЛИЙН ТОВЧОО

No	Улсын чанартай авто замын чиглэлийн дугаар	Авто замын чиглэлийн нэр	Замын дугаар	Замын нэр	Яамны бүртгэлд байгаа Урт. Км	Хэмжилтээр гарсан бодит урт. Км	Тэмдгийн төрөл, тоо						Домоны шонгийн төрөл, тоо				Хэвтээ тэмдэглэл (м)			Хурд сааруулагч (м)	Замын зэрэг
							Гурвалжин	Дугуй	Мэдээллийн тэмдэг	Км-ийн	Мэдээллийн самбар	Бүгд	Ашиглалтын байдал ба үнэлгээ	Төмөр/бетон	Төмөр (хоолой)	Модон	Бүгд	Ашиглалтын байдал ба үнэлгээ	Ургэлжилсэн (м)		

Авто зам, замын байгууламжуудын тооллогын бүртгэл ТБ-05

ОЛОН УЛС, УЛСЫН ЧАНАРТАЙ ЗАМЫН ХАМГААЛАЛТЫН БАЙГУУЛАМЖУУДЫН ТООЛОГЫН ТОВЧОО

No	Улсын чанартай авто замын чиглэлийн дугаар	Авто замын чиглэлийн нэр	Замын дугаар	Замын нэр	Хэмжилтээр гарсан бодит урт. Км	ШУУДУУ, у/м		БЭХЭЛГЭЭТЭЙ ШУУДУУ, у/м		ДАВУУЛАХ ДАЛААН, у/м		ЗАМ ХАМГААЛАХ ХИЙЦҮҮД		НОГООН БАЙГУУЛАМЖ		ЗОГСООЛЫН ТАЛБАЙ		ЦАСНЫ ХАМГААЛАЛТ	
						өөрийн	уулын	чулуун	бетон	дундагч өргөн, м	бетон	хийц	у/м	Зүлэг, бут сөөг-м2	мод-ш	у/м	м2	хийц	у/м

Авто зам, замын байгууламжуудын тооллогын бүртгэл ТБ-06

ОЛОН УЛС, УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМЫН ДЭРГЭДЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛАМЖУУДЫН ТООЛОГЫН БҮРТГЭЛИЙН ТОВЧОО

No	Улсын чанартай авто замын чиглэлийн дугаар	Авто замын чиглэлийн нэр	Замын дугаар	Замын нэр	Яамны бүртгэлд байгаа Урт. Км	Хэмжилтээр гарсан бодит урт. Км	Амрах талбай		Автобусны буудал		Гуанз, зочид буудал, бие засах газар		Төлбөр хураах цэг		Пүү тоологын цэг		ЗЦХ, тээврийн пост		Овоо
							Тоо	Байршил км...+...	Тоо	Байршил км...+...	Тоо	Байршил км...+...	Тоо	Байршил км...+...	Тоо	Байршил км...+...	Тоо	Байршил км...+...	

Авто зам, замын байгууламжуудын тооллогын бүртгэл ТБ-07

Орон нутгийн чанартай Авто замын бүртгэл

д/д	Зам болон замын хэсгүүдийн нэр	Тухайн замын урт /км/	Үүнээс Орон нутгийн чанартай замд хамаарах урт, км	Улсын чанартай болон бусад замд хамаарах урт, км	Орон нутгийн чанартай замын				Орон нутгийн замд байгаа 6.0м-с дээш урттай гүүрүүдийн бүртгэл			Тэмдэгжүүлэлтийн байдал: -бүрэн, -дутуу, -байхгүй	Авто замын уур амьсгалын бүсчлэл	Зам хариуцагч байгууллагын нэр
					Хучилтын төрөл	Ашиглалтад орсон он	Балансын үнэ, сая.₮	Авто замын ашиглалтын байдлын ерөнхий үнэлгээ	Гүүрийн нэр, байршил	овор, хэмжээ	Материал, хийц			

“АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ТООЛЛОГО, БҮРТГЭЛ ХИЙЖ, ПАСПОРТ, КАРТ ХӨТЛӨН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛД АВАХ СУДАЛГАА, БОЛОВСРУУЛАЛТ”-ЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ ХӨТӨЛБӨР, АРГАЧЛАЛ

I. БЭЛТГЭЛ АЖИЛ

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, картыг шинэчлэн хөтлөх, үндсэн хөрөнгийн бүртгэлд авч дахин үнэлгээ хийх, тэдгээрийг кадастрын зурагт оруулах, орон нутгийн замын бүртгэлийг шинээр боловсруулах чиглэлээр хийгдэх судалгаа, боловсруулалтын ажлыг тогтоосон хугацаанд нь чанартай сайн гүйцэтгэхийн тулд үндсэн ажлын бэлтгэлийг дараах байдлаар хангана. Үүнд:

1. Ажлын даалгаврын заалт бүрийг нарийвчлан судалж үзсэний үндсэн дээр тодруулах, магадлах зүйл байвал захиалагчид тавьж хариу авах ба хийгдэх бүх ажлыг түүний ач холбогдол, цар хэмжээ, шаардагдах цаг хугацаа, хүн хүчнээс хамааруулан эрэмбэлнэ.
2. Тухайн ажлын эрэмбэтэй уялдуулан гүйцэтгэх хугацааг нарийвчлан тооцож ажлын графиктаа тусгана.
3. Хийвэл зохих бүх ажлыг багийн гишүүдийн мэргэжил, ажлын туршлага, нас, чадвар зэрэгт тохируулан, жигд бөгөөд хэн нэгнээс шалтгаалсан ямар нэгэн саатал гарахааргүйгээр хуваарилж өгнө.
4. Тооллого, бүртгэлд хамрагдах бүх зам, гүүрийн зураг, төсвийг олдсон хэмжээнд нь танилцаж судлана.
5. Урьд нь хөтөлж байсан замын паспорт, гүүрийнкарт, замын объектуудыг ашиглалад оруулсан акт, ТАТ-ын судалгааны үр дүнг дээрх ажлуудад шаардлагатай боломжит бүх материалыг холбогдох газруудаас олж авна. Үүнд:
 - Монгол улсын нийт авто зам, гүүрт хийсэн 1971, 1982 онуудын тооллогын материал,
 - Улсын чанартай замуудын техник ашиглалтын түвшин тогтоосон /ТАТ/ 2002-2004 онуудын материал,
 - ЗТЯ-нд байгаа улс, орон нутгийн чанартай замуудын өгөгдлүүд,
 - Сүүлийн жилүүдэд /1982 оноос хойш/ ашиглалтад орсон зам, гүүрийн улсын комиссын акт, замын паспорт, гүүрийн карт,
 - ЗТЯ, Төрийн өмчийн хорооны бүртгэлд байгаа зам, замын байгууламжийн үндсэн хөрөнгийн бүртгэлүүд,
 - Авто замын ашиглагч байгууллагад /АЗЗА-нуудад/ байгаа бүртгэл, мэдээлэл ба материалууд г м.
6. Авто замын засвар, арчлалтын чиглэлээр урьд нь ажиллаж байсан болон одоо ажиллаж байгаа хүмүүсээс асууж лавлах замаар нэмэлт судалгаа авна.
7. Дээр дурдсан материалууд болон судалгааны үр дүнг сайтар судалж, шаардлагатай мэдээллийг нэгтгэн авч, журам боловсруулах болон тооллого, бүртгэлийн ажлыг гүйцэтгэх үндэслэлийг гаргаж авна.
8. Авто зам, замын байгууламжийг кадастрын зурагт оруулах, тэдгээрийн үндсэн хөрөнгийн үнэлгээ хийх байгууллагуудтай харилцан тохиролцож, 2 төрлийн гэрээг байгуулна.
9. Газар дээр хийгдэх хэмжилт, тооллого, судалгааны ажилд шаардлагатай газрын зураг, зам, замын байгууламжийн бүртгэл, паспорт, картыг шинэчлэхэд хэрэглэх программ хангамжийг судалж холбогдох байгууллагуудаас худалдаж авна. Жишээ болгож, Оросын Indor Road программын товч танилцуулгыг орчуулан хавсаргав.
10. Дээрх программ дээр ажиллах 4-5 хүнийг гадаадад явуулж, газар дээр нь тусгай сургалт, дадлагад хамруулна.
11. Хээрийн хэмжилт, тооллогын ажил гүйцэтгэх тус бүр 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй 3 багийг зохион байгуулж ажиллуулна.
12. Эдгээр багт шаардлагатай автомашин, компьютер, төрөл бүрийн хэмжилтийн багаж хэрэгсэл, найдвартай холбооны хэрэгсэл, аж ахуйн болон бичиг хэргийн хэрэгцээт зүйлсийг сайтар бэлтгэн хангаж өгнө.
13. Хээрийн хэмжилт, тооллого, бүртгэл, судалгааны суурин боловсруулалт хийж, үндсэн баримт материалуудыг эцэслэн боловсруулах, хугацаат тайлангуудыг бэлтгэж гаргах,

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

багийн өдөр тутмын болон бусад шаардлагатай бичиг хэргийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай ажлын байрыг олж түрээслэн, тоноглож бэлэн болгоно.

II. ҮНДСЭН АЖИЛ

А.АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ТООЛЛОГО, БҮРТГЭЛ, ПАСПОРТЖУУЛАЛТ БА КАРТЖУУЛАХ АЖИЛ

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэлийг доорх дэс дараалал ба аргачлалаар гүйцэтгэнэ.

1. Юуны түрүүнд ажлын даалгавар заасны дагуу “Авто зам, замын байгууламжийг тоолж, бүртгэл хөтлөн паспортжуулах, үл хөдлөх үндсэн хөрөнгийн бүртгэлд авах” журмын төслийг шаардлагатай маягт, хүснэгт, паспорт, картын хамт иж бүрнээр нь, зохих мэргэжлийн хүмүүсийг оролцуулан яаралтай боловсруулна.
2. Бэлэн болсон журмын төслийг Захиалагчаас чиглэл болгосон холбогдох газруудаар хянуулан, тэдгээрээс өгсөн санал шүүмжийг тусган эцсийн байдлаар бэлэн болгоно.
3. Дээрх журмыг албан ёсны болгох ажлыг Захиалагчтай хамтран зохион байгуулж, Зам тээврийн болон Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлуулах ба энэхүү төслийн ажлыг гүйцэтгэхэд мөрдөж ажиллана.
4. Бэлтгэл ажлын 7,8-д дурдсаны дагуу бэлэн болгосон өгөгдөл, үндэслэлд тулгуурлан талбайд тооллого, бүртгэл, судалгааны болон тэдгээртэй зэрэгцэн хийгдэх ажлуудыг хэрхэн гүйцэтгэх зааврыг нарийвчлан боловсруулж дотооддоо мөрдөнө. Үүнд:
 - Зам, гүүрийг газар дээр нь хэрхэн тоолох,
 - Авто зам, замын байгууламжийн одоогийн байдлыг ямар үзүүлэлтээр хэрхэн үнэлэх,
 - Дүгнэлтийг хэрхэн гаргах,
 - Авто зам, замын байгууламжийн өнөөгийн байдлыг харуулсан зураг, бичлэгийг яаж хийх,
 - Хөдөлгөөний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж байгаа цэгүүдийн байршлыг ямар үзүүлэлтээр, хэрхэн судалж тогтоох,
 - Тооллогын үр дүнг хэрхэн бүртгэх,
 - Бүртгэлийн материалыг программд хэрхэн оруулах, бүртгэл мэдээллийн цахим санг хэрхэн бүрдүүлэх,
 - Замын шинэчилсэн паспорт ба гүүрийн картыг хэрхэн бөглөх, эдгээр болно.
5. Талбайн тооллого, хэмжилт, судалгаанд ажиллах бүх хүмүүст дотооддоо мөрдөх дээрх заавруудыг хэрхэн хэрэгжүүлж ажиллах талаар танхимын богино хугацааны сургалт явуулж, дадлагажуулна.
6. Олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжийн үзлэг, тооллогыг Баруун, Төвийн хойд, Төвийн урд, Зүүн гэсэн бүсчилсэн байдлаар хийхээр төлөвлөж байгаа бөгөөд ингэхдээ¹ удаагийн явалтаар 1 бүсийг бүрэн дуусгахаар тооцож байна. Бие даасан 3 баг нэг явалтдаа 3 зам дээр зэрэг ажиллах ба тухайлбал баруун бүсэд тус бүрдээ календарийн 35-40 хоногт 1643 км замын тооллого, судалгааг дуусгана. Ийм байдлаар буюу Төвийн бүсэд 18-23 хоногт 900км-ийн, Говийн бүсэд 17-22 хоногт 835км-ийн, Зүүн бүсэд 18-23 хоногт 865км-ийн ажлыг тус тус дуусган нийтдээ 3-4 сард багтаан хээрийн ажлыг дуусгахаар төлөвлөж байна. Багуудын ажиллах замын бүдүүвчийг Хавсралт 1-4-д үзүүлэв.
7. Дээрх ажилтай зэрэгцүүлэн орон нутгийн чанартай засмал замуудын бүртгэлийг давхар хийхээр зохион байгуулна.
8. Зам дээр үзлэг, тооллого, судалгаа явуулах, зураг авах, бичлэг хийх, тэмдэглэл хөтлөх гм нь нэг талаас ихээхэн хугацаа , нарийн нягт ажиллагаа шаардсан ажлууд бөгөөд нөгөө талаас бүртгэл, тооллогын материалын эцсийн боловсруулалт болон бусад баримт бичгийн боловсруулалтад түүнээс багагүй цаг зарцуулах тул нийт төслийг хэрэгжүүлэхэд төлөвлөсөн хугацааг хэмнэх үүднээс говийн болон зүүн аймгийн замууд дээр энэ оны 11-12-р сард ажиллаж харин бусад бүсийн замуудын үзлэг, тооллого болон бусад ажлыг 2016 оны 4-р сараас эхлэхээр тооцлоо. Ажлын графикийг үзнэ үү.

9. Талбайд ажиллах багийн гишүүд нь зам, замын байгууламжид нүдэн баримжаагаар үзлэг хийх, геометр хэмжээсийг шалгах, эвдрэлийн байдлыг тогтоох, ашиглалтын бэлэн байдалд үнэлэлт өгөх, тэнхлэгийн солбицолыг хэмжих, хөрөнгийн үнэлгээ хийхэд шаардлагатай өгөгдөл ба мэдээллийг цуглуулах, хөдөлгөөний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж байгаа ба болзошгүй цэгүүдийн байршлыг судлах, хот, суурингуудын хоорондох зайг нарийвчлан тогтоох, замын өнөөгийн байдлыг харуулсан зураг авч бичлэг хийх, зохих бүртгэл журналыг бүрэн хөтлөх, цуглуулсан материал ба мэдээллийг цахим хэлбэрт оруулж хадгалах, суурин боловсруулалт хийж буй баг руу илгээх, тэндээс шаардсан үед алдаа мадагтай юм уу эргэлзээтэй зүйлсийг дахин нягталж хариу өгөх, нэмэлт мэдээллээр хангах зэрэг ажлыг гүйцэтгэнэ.
10. Хээрийн ажлыг явуулж байхын зэрэгцээ талбайд ажилласан багуудаас бүртгэл, мэдээллийн бэлэн болсон өгөгдлүүдийг хүлээн авч боловсруулалт хийж, программд оруулах ажлыг 2016 оны 5-р сарын 10-наас эхлэн гүйцэтгэж 10 сарын 10-нд дуусгана.
11. Бүрэн боловсруулалт хийгдэж, хянагдсан материалаар зам, замын байгууламжийн бүртгэл мэдээлийн цахим сан байгуулах ажлыг 7-р сарын 1-нээс 10-р сарын 20-ны хооронд хийнэ.
12. Олон улс, улсын чанартай нийт авто зам болон нийт гүүрийг шинэчилсэн паспорт, карттай болгох ажлыг бүрэн дуусгаж, 2016 оны 12-р сарын 20-нд Захиалагчид хүлээлгэн өгнө.

Б. АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛ

Монгол улсын Авто замын сүлжээний урт /зөвхөн улс, орон нутгийн чанартай зам/ 49250 км, үүнээс 12722 км нь олон улс, улсын чанартай замбөгөөд 667 цэгт 32628.6 у/м гүүртэй. Нийтдээ 3 орчим их наяд төгрөгний өртөгтэй авто зам, гүүр байна гэсэн багцаа тоо бий. Монгол улсын хуулиар, олон улс, улс, орон нутгийн чанартай зам, гүүрүүд нь Монголын бүх ард түмний нийтийн зориулалттай өмч бөгөөд одоохондоо зам, гүүрийн техникийн шинж чанартай бүртгэл байхаас биш өмч, үндсэн хөрөнгөтэй холбоотой нарийн бүртгэл ба үнэлгээ байхгүй байна.

Манай улс түүхэндээ авто зам, замын байгууламжаа 1971, 1982 онуудад 2 удаа тоолж дүн, бүртгэл гаргасан бөгөөд сүүлчийн тооллогоос хойш 33 жил өнгөрчээ. Улсын энэ их хөрөнгө эзэнгүй юм шиг байгаад дүгнэлт хийж, нийт зам гүүрт тооллого явуулж, үзлэг шалгалт хийсний үндсэн дээр ашиглалтын байдлыг тогтоож, чанарын үнэлгээ өгөх, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ хийлгэх, үндсэн хөрөнгийн бүртгэлд авах, кадастрын зураглалд оруулах г.м ажлуудыг хойшуулшгүй хийхээр Захиалагч шийдвэрлэсэн байна.

Иймд дээрхээс үндэслэн ажлын даалгаварт тусгагдсан олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжийн хөрөнгийн үнэлгээний ажлыг бид дараах дэс дараалал ба аргачлалаар гүйцэтгэнэ.

1. Авто зам, замын байгууламжийн үндсэн хөрөнгийн үнэлгээ хийлгэх ажлын даалгаврыг боловсруулж бэлэн болгоно.
2. Үндсэн хөрөнгийн үнэлгээ хийх эрх бүхий, урьд нь энэ чиглэлээр тодорхой ажлууд гүйцэтгэж байсан хангалттай туршлагатай, хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагыг сонгож, ажил гүйцэтгэх гэрээ байгуулна..
3. Одоо байгаа авто замын бүртгэл мэдээллийн сан, үндсэн хөрөнгийн бүртгэлийн материалыг авч судалгаа хийж, ашиглах боломжтой мэдээллийг бэлтгэнэ.
4. Авто замын бүртгэл, мэдээллийн талаар хэрэгжсэн, хэрэгжиж байгаа төслүүдийн үр дүнгийн талаар судалж, дээрх ажилтай холбож болох эсэхийг тогтоох ба боломжтой зүйлийг ашиглана.
5. Нийт зам, гүүрийн үндсэн хөрөнгийн үнэлгээ хийхэд шаардлагатай судалгааг мэргэжлийн хүнээр газар дээр нь иж бүрэн хийлгэнэ.
6. Авто зам, замын байгууламжийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг шинээр гаргасан журмын дагуу хөрөнгийн үнэлгээний хараат бус байгууллагаар хийлгэнэ.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

7. Нийт зам, гүүрийг үл хөдлөх үндсэн хөрөнгийн бүртгэлд оруулан үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээтэй болгох ажлыг 8-р сарын 1-нээс эхлэнэ. Энэхүү үнэлгээний ажлыг бүхэлд нь 2017 оны 12-сарын 1-нд дуусгасан байна.

В. АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙГ КАДАСТРЫН ЗУРАГТ ОРУУЛАХ АЖИЛ

Монгол улсын Авто замын сүлжээний олон улс, улсын чанартай зам, нийт гүүрийг үндсэн хөрөнгийн бүртгэлд хамруулж үнэлгээ хийхийн тулд тэдгээрийг заавал кадастрын зурагт оруулсан байх шаардлагатай. Ийм учраас энэхүү төслийн даалгаварт тусгасан ажлыг бид дараах дэс дараалал ба аргачлалаар гүйцэтгэнэ.

1. Олон улсын болон улсын чанартай авто зам, тэдгээрт байгаа нийт гүүрийг кадастрын зурагт оруулах ажлын даалгаврыг нарийвчлан боловсруулна.
2. Авто замын геодезийн буюу кадастрын зураглал хийх эрх бүхий, урьд нь энэ чиглэлээр тодорхой ажлууд гүйцэтгэж байсан хангалттай туршлагатай, хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагыг сонгож, ажил гүйцэтгэх гэрээ байгуулна.
3. Талбайн хэмжилтэд гарахын өмнө ажил гүйцэтгэх хүмүүстэй уулзаж, ажлын даалгавар, хийх ажлыг дахин нарийвчлан танилцуулж, хүлээн авах үр дүнгийн талаар тохиролцох ба ажлын бэлтгэлийг шалгаж үзнэ.
4. Тухайн зам, гүүрийг ашиглалтад оруулсан үеийн акт, материалыг судалж үзэх ба гүйцэтгэлийн зургуудаас ашиглах боломжтойг авч бэлтгэнэ.
5. Кадастарт оруулах зам, гүүрүүдийн тэнхлэгийн солбицолыг газар дээр нь явж хэмжиж тогтооно.
6. Бэлэн материал болон талбайн хэмжилтийн үр дүнг ашиглан нийт зам гүүрийг кадастрын зурагт оруулна. Энэ ажлыг бүхэлд нь 2017 оны 11-р сарын 1-нд дуусгана.

Г. ОРОН НУТГИЙН ЗАМУУДЫН БҮРТГЭЛИЙН АЖИЛ

Монгол улсын Авто замын сүлжээний нийт замын 74.2%-ийг эзлэх 36528 км урттай орон нутгийн чанартай замуудын бүртгэлийг олон улс, улсын чанартай замуудын тооллого, бүртгэл, судалгааны ажлын зэрэгцээгээр зохион байгуулахаар төлөвлөж байна.

Д.БУСАД АЖИЛ

Төслийн ажлын календарчилсан графикт тусгагдсан бусад ажлыг дараах байдлаар гүйцэтгэнэ. Үүнд:

1. Хот, суурингуудын хоорондох албан ёсны тарифт зайг шинэчлэн тогтоох ажлыг замын бүртгэл, тооллын ажилтай нэгэн зэрэг гүйцэтгэх ба 2016 оны 9 сард багтаан эцэслэн дуусгана.
2. "Монгол улсын Авто замын сүлжээ" номын эх бэлтгэх ажлыг тооллого, судалгааны ажлын үр дүнг боловсруулах ажилтай ойролцоо буюу 2016 оны 6-р сарын 20-ноос эхлэн гүйцэтгэж 2017 оны 12-р сарын 10-ны дотор дуусгасан байна.

Е. БОЛОВСРУУЛСАН МАТЕРИАЛУУДЫГ ХЯНУУЛЖ БАТЛУУЛАХ АЖИЛ

Тухайн төслийн боловсруулсан материалыг хянуулж батлуулах ажлыг дараах байдлаар зохион байгуулна.

1. Төслийн хүрээнд хийгдсэн бүх ажлын баримт бичгийн боловсруулалтын төгсгөлийн шатанд нэг удаа хэлэлцүүлэг зохион байгуулна. Хэлэлцүүлэгт Захиалагчийн холбогдох хүмүүс, мөн тэндээс санал болгосон бусад хүмүүс, мэргэжилтнүүдийг бүрэн хамруулна.
2. Захиалагчаас санал болгосон холбогдох бүх газруудаас санал авч тусгана.
3. Эцсийн тайлан ба нийт баримт бичигт яамнаас тусгайлан томилсон багаар шүүмж хийлгэж дүгнэлт гаргуулах ба санал шүүмжийг нь тусгана.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

4. Боловсруулсан материалыг Авто замын салбарын Шинжлэх ухаан техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хурлаас гарсан зөвлөмжийг тусгана.
5. Улмаар Зам, Тээврийн Яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хуралд оруулж хэлэлцүүлнэ.
6. Засгийн газраар гаргуулах аливаа шийдвэрийн эх материал нь заавал аудитаар орж хянагдсан байх шаардлагатай тул бид энэхүү төслийн хүрээнд боловсруулагдсан бүх баримт бичигт хараат бус аудитын байгууллагаар аудит хийлгэж дүгнэлт гаргуулна.
7. Эцэст нь уг асуудлыг албан ёсны болгох ажлыг Захиалагчтай хамтран зохион байгуулж, Зам, Тээврийн яамаар уламжлуулан Засгийн газарт оруулан зохих шийдвэр гаргуулна.

АР ДИ ЭЙ СИ ХХК

2.2 Тооллого, бүртгэлийн ажил гүйцэтгэсэн зөвлөхийн баг

Тооллого, бүртгэлийн ажлыг Монгол улсын Зөвлөх инженер Д.Баасанхүү, Н.Адилбиш, Р.Балжир, Х.Гантөмөр нар, залуу инженерүүд А.Золжаргал, Ё.Эрдэнэжаргал, Д.Түвшин, Л.Эрдэнэбаатар, А.Жавхлантөгс нартай хамтран гүйцэтгэлээ.

Монгол улсын Зөвлөх инженерүүд /цаашид Зөвлөхүүд гэх/ нь Монгол улсын авто замын сүлжээг хөгжүүлэх үйлст бүх насаа зориулсан, салбарын удирдах байгууллагад он удаан жил ажилласан, Авто зам, гүүрийн барилга, засварын ажлыг гардан гүйцэтгэж байсан үйлдвэрлэлийн нөр их туршлагатай, Авто замын сүлжээний дунд хугацааны хөтөлбөрүүдийг гаргахад биечлэн оролцож байсан, 1982 оны Улсын чанартай нийт зам, гүүрийн тооллого хийлцсэн, Авто замын бүртгэл, мэдээллийн сангийн холбогдолтой баримт бичгүүдийг боловсруулан гаргахад үнэтэй санал гаргаж, зөвлөгөө өгч байсан, энэ салбарын шилдэг инженерүүд билээ.

Зөвлөхүүдийн товч танилцуулгыг дор харуулав.



Монгол улсын Зөвлөх инженер ДОРЖЦЭВЭЭНИЙ БААСАНХҮҮ, 1950 онд төрсөн, Москвагийн Авто замын дээд сургууль төгссөн, Улаанбаатар хотын Авто замын байгууллага, АЗЕГ, Зам, тээврийн яаманд инженер, захирал, хэлтсийн дарга, төслийн удирдагч, газрын даргын алба хашиж байсан, Монгол улсын Авто замын сүлжээг 2020 он хүртэл хөгжүүлэх дунд хугацааны мастер төлөвлөгөөг боловсруулсан, 1982 оны тооллогод оролцсон, орос, англи хэлтэй, Зүүн бүсийн тооллогын багийн ахлагч



Монгол улсын Зөвлөх инженер НЯМЖАВЫН АДИБИШ, 1956 онд төрсөн, Харьковын Авто замын дээд сургууль төгссөн, УА-ыг Төрийн удирдлагын магистраар төгссөн, Төв аймгийн замын байгууллага, АЗЕГ, Зам, тээврийн яаманд инженер, мэргэжилтэн, хэлтсийн дарга, төслийн удирдагчаар ажиллаж байсан, авто замын ашиглалтын удирдлагын чиглэлээр 2000, 2016 онуудад гарсан норм, дүрэм, боловсруулсан, орос, англи хэлтэй, Баруун бүсийн тооллогын багийн ахлагч, энэ төслийн Зөвлөх.



Монгол улсын Зөвлөх инженер РАВЖИРЫН БАЛЖИР, 1956 онд төрсөн, Харьковын Авто замын дээд сургууль төгссөн, Баруун чиглэлийн хатуу хучилттай замын барилгын ажлыг эхлүүлсэн АЗЕГ, Зам, тээврийн яаманд мэргэжилтэн, хэлтсийн дарга, төслийн удирдагч, УБ хотын замын байгууллагын ерөнхий инженерээр ажиллаж байсан, авто замын ашиглалтын удирдлагын чиглэлээр 2000, 2016 онуудад гарсан норм, дүрмийг боловсруулсан, орос, англи хэлтэй, Төвийн бүсийн тооллогын багийн ахлагч

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



Монгол улсын Зөвлөх инженер ХУУШААНЫ ГАНТӨМӨР, 1969 онд төрсөн, Ереваны Барилга, архитектурын их сургууль төгссөн, Авто замын институтэд гүүрийн зураг хийж ажлын гараагаа эхэлсэн, АЗГ, Зам, тээврийн яаманд хяналтын инженер, хэлтсийн дарга, төслийн удирдагч, газрын орлогч даргын алба хашиж байсан, Монгол улсын Авто замын сүлжээний дунд хугацааны мастер төлөвлөгөөг боловсруулсан, орос, англи хэлтэй. Гүүр, хоолойн тооллого бүртгэлээр дагнаж ажилласан

Эдгээр инженерүүд нь 3 бүсэд тооллого, бүртгэлийн багийг ахлан, тус бүрдээ 2 сар шахам хугацаанд Монгол улсын улсын чанартай бүх замууд, зарим орон нутгийн болон, тусгай зориулалтын замыг тууллаа.

Зам, гүүрийн дахин үнэлгээ хийх, кадастрын зурагт оруулах ажлыг Монгол улсын Тэргүүлэх үнэлгээчин, Эдийн засгийн шинжлэх ухааны доктор ScD Ц.Баатарын ахалсан баг гүйцэтгэсэн.



Монгол улсын Тэргүүлэх үнэлгээчин, ScD, профессорЦ.Баатар, 1953 онд төрсөн, МУИС төгссөн, ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнд ЭША, АНУ-ын Иллинойс, Индианагийн их сургуулийн зочин профессор, Санхүүгийн судалгаа, хөрөнгийн үнэлгээний “Итгэлт-Бээс” ХХК-ийн зөвлөхийн ажилтай, Хөгжлийн гадаад хүчин зүйлийн харьцуулсан судалгаа шинжилгээний нэгэн сэдэвт 6 бүтээл англи, монгол хэлнээ туурвисан, энэхүү судалгааны ажилд кадастрын зураглал, зам, гүүрийн дахин үнэлгээний Зөвлөхөөр ажилласан.

Хэдийгээр хязгаарлагдмал төсөвтэй, хугацаанд хавчигдсан, зардал ихтэй ажил байсан ч Зөвлөхүүд, залуу хойч үедээ, Авто замын иж бүрэн тооллого, бүртгэлийн суурь, судалгааны материалыг бэлтгэн хүлээлгэн өгөх дэврэнгүй сэтгэлдээ хөтлөгдөн, өөрсдийнхөө хувийн унаагаар, жолооч хөлслөн, албаны болон амин хувийн бусад ажлаа хойш нь тавьж жил гаруй хугацаанд хөдөлмөрлөснийг дурдах нь зүйтэй.

Энэ хугацаанд Авто замын тооллого, бүртгэлийн ажлыг цаашид илүү боловсронгуй байдлаар, чанартай гүйцэтгэх тогтолцооны эх суурийг тавьсан болно.

2.3 Хээрийн тооллого, бүртгэлт, хэмжилт

Монгол улсын нутаг дэвсгэрийг Зүүн, Төв, Баруун гэсэн 3 бүсэд хувааж тус бүрд нь 2 инженер, нэг туслах ажилтны бүрэлдэхүүнтэй 3 баг хээрийн тооллого, хэмжилтийн ажил гүйцэтгэсэн. Багуудын бүрэлдэхүүн:

1-р баг /Зүүн бүсийн/ Зөвлөх инженер Д.Баасанхүү- багийн ахлагч

Замын инженер Б.Түвшин- багийн гишүүн

Замын инженер Т.Цогтбаяр-багийн гишүүн

Замын инженер А.Гарьд -багийн гишүүн

2-р баг /Баруун бүсийн/ Зөвлөх инженер Н.Адилбиш- багийн ахлагч

Мэдээлийн технологи инженер Б.Болдсайхан –багийн гишүүн

Туслах ажилтан Б.Отгонбаатар –багийн гишүүн

3-р баг /Төвийн бүсийн/ Зөвлөх инженер Р.Балжир –багийн ахлагч

Замын инженер Ё.Эрдэнэжаргал –багийн гишүүн

Туслах ажилтан Б.Батзориг –багийн гишүүн

3 баг, улсын чанартай 12722 км замуудыг газар дээр нь явж ,нүд үзэж тоолсон. Тооллогын ажлыг дараах байдлаар зохион байгуулж хийсэн. Үүнд:

- Бүх багууд Налайх-Зуунмодны А25 зам, А0201 замд байгаа Түргэний голын гүүрийн тооллого хэмжилтэд хамтдаа гарч, хийх ажлынхаа талаар товчхон сургалт зохион байгуулсан.
- Урьд нь гарсан замын паспорт, гүүр, хоолойн хоолойн картыг үзэж судалж, хэвлээд машиндаа авч явсан. ЗТЯ-наас авсан эдгээр паспорт, картууд нь газар дээрээ ихээхэн зөрүүтэй байсан учир нэг их хэрэг болоогүй, харин хоолойн картууд алдаг оног таарч байсан.
- Авто замын байршлын эхлэлийн цэг, төгсгөлийн цэгийг олж, тэндээс хэмжилтээ эхэлсэн. Аймгуудын зам хариуцагч байгууллагуудын инженерүүдтэй уулзан тэднээс зарим мэдээлэл авсан.
- Аймгуудын төвөөр дайран өнгөрч байгаа улсын чанартай замуудын хувьд эхлэл, төгсгөлийн цэгийг “аймгийн захиргаа /нутгийн удирдлагын ордон/ руу салдаг хамгийн ойр уулзварын гол цэг” гэсэн зарчмаар тодорхойлж, солбицолуудыг авсан. Харин гар GPS, видео бүртгэгчийн координат тодорхойлогч нь 3-10м хүлцэх алдаатай тул, суурин боловсруулалтын үед ArcGIS, BASECAMP, GOOGLEpro зэрэг програмуудын тусламжтайгаар солбицолуудыг дахин нягталж илүү нарийвчлалтай болгосон.
- Өдөрт дунджаар 80-250км орчим замыг туулж бүртгэл, тэмдэглэл хөтөлж, тасралтгүй бичлэг хийж, зураг авч явлаа.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Олон улс болон улсын чанартай замуудын үзлэг, тооллого, бүртгэл хийсэн өдрүүд

Хүснэгт 2.3.1

Замын дугаар	Замын нэр	Замын урт. Км	Ажилласан өдрүүд		Аль цэгээс эхэлсэн	
			7-р сар	8-р сар	Эхлэлийн цэгээс	Төгсгөлийн цэгээс
A0101	Улаанбаатар /12-р км/-Налайх-Чойр	224.5		15,16	+	
A0102	Чойр-Сайншанд	221.4		17	+	
A0103	Сайншанд-Замын-Үүд боомт	216		18	+	
A0201	Улаанбаатар /29-р км/-Мандалговь	271.5		23		+
A0202	Мандалговь-Даланзадгад	305.1		22,23		+
A0203	Даланзадгад-Гашуунсухайт боомт	299.9		20,21		+
A0301	Улаанбаатар /19-р км/ -Арвайхээр	412.3	20,21,22	16	+	
A0302	Арвайхээр-Баянхонгор	209.5	18,19		+	
A0303	Баянхонгор-Алтай	395.9	20,23		+	+
A0304	Алтай-Ховд	438.9	25		+	+
A0305	Ховд-Өлгий	225.2	28		+	
A0306	Өлгий-Цагааннуур боомт	99.3	31		+	
A0401	Улаанбаатар /19-р км/-Дархан	232.2		11,12		+
A0402	Дархан-Сүхбаатар	89		9,10	+	
A0403	Сүхбаатар-Алтанбулаг боомт	24		10	+	
A0501	Улаанбаатар /28-р км/ - Өндөрхаан	306.1	27,28		+	
A0502	Өндөрхаан-Чойбалсан	330.2		6		+
A0503	Чойбалсан-Сүмбэр боомт	413.9		1,2	+	
A0601	Элсэнтасархай-Хархорин	77	26,27			+
A0602	Хархорин-Цэцэрлэг	116.2	29		+	
A0603	Цэцэрлэг-Тосонцэнгэл-Нөмрөг	462.3	30,31	1	+	
A0604	Нөмрөг-Тэс-Арцсуурь боомт	196.7				
A07	Өлгий-Увсын Өлгий	213.1		4	+	
A08	Хархорин-Хужирт-Арвайхээр	90.3	25,26			+
A0901	Дашинчилэн-Булган	131.5		7,8	+	
A0902	Булган-Мөрөн	343.6		3,4,5,6,7		+
A1001	Дархан /11км/ - Эрдэнэт	169.5		9		+
A1002	Эрдэнэт-Булган	53.7		8		+
A1101	Ханх боомт-Хатгал-Мөрөн	293.9		2		+
A1102	Мөрөн-Улиастай	390.9		1		+
A1103	Улиастай-Алтай	189.4	22		+	
A1104	Алтай-Бургастай боомт	326	24		+	
A12	Бууцагаан-Цагаанхайрхан	238.6	21		+	
A13	Хутаг-Өндөр—Тэшиг-Бага илэнх боомт	134.9		4,5	+	

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

A14	Манхан /Ховд/-Булган боомт	355.3	26		+	
A15	Өлгий-Даян боомт	184.4	29		+	
A16	Улаангом-Үүрэгнуур-Цагааннуур	181.8	31	9	+	+
A1701	Ховд-Улаангом	243.9		4, 10	+	+
A1702	Улаангом-Боршоо боомт	116		9	+	
A18	Нөмрөг-Сонгино-Наранбулаг-Улаангом	358.2		8	+	
A19	Өндөрхаан-Норовлин-Баян-Уул-Ульхан боомт	272.7		8	+	
A2001	Өндөрхаан-Баруун-Урт	178.0	29		+	
A2002	Баруун-Урт-Бичигт боомт	290.1	30		+	
A21	Чойбалсан—Баян-Уул	240.7	5			+
A2201	Баруун-урт-Чойбалсан	183.2	31			+
A2202	Чойбалсан-Эрэнцав боомт	235.2		3	+	
A23	Энгэршанд-Хавирга боомт	74.9		3	+	
A24	Налайх-Тэрэлж	30.4		12	+	
A25	Зуунмод-Налайх	28.2	6		+	
A26	Баянхонгор-Шаргалжуут	54.2	19		+	
A27	Лүн-Дашинчилэн-Өгийнуур-Батцэнгэл-Ихтамир	330.9	27,28		+	
A28	Хархорин - Хөшөөцайдам - Өгийнуур	88.9	26		+	
A29	Арвайхээр-Гучин-ус-Шивээхүрэн боомт	454.6	23,24,25		+	
A30	Хатгал-Жанхай-Тойлогт	34.1		2	+	
A31	Улиастай - Сархайрхан-Мянгад	438.9		5		+
A32	Шаамар-Зүүнбүрэн-Зэлтэр боомт	107.7		11	+	

2.4 Хэмжилт, хяналтад ашигласан техник хэрэгсэл

Замын өргөн, гүүрийн урт, өргөн, хайс, дугуй цохигчийн өндөр, талбайн хэмжээ, налуу, шуудууны хэмжээг энгийн 10м урттай эвхдэг метр ашиглан хэмжсэн. Хоолойн уртыг хэмжихдээ зарим тохиолдолд лазер хэмжигч ашигласан.

Зам, гүүр, хоолойны байршил, хиймэл байгууламж, тоноглолын эхлэл төгсгөлийн цэгийн байршлыг Garmin-ий хамгийн сүүлийн үеийнгар GPS, 135⁰-ын өнцгөөр бичлэг хийж, зураг авч болдог Garmin-ий видео бүртгэгч /видеорегистатор/-ийн цэг бүрийн солбицолуудаар тодорхойлсон.

Замын ерөнхий байдал, эвдрэлтэй болон анхаарал татах хэсгийн зураг, гүүрийн бүх талыг харуулсан зураг, хоолойн орох гарах амсарын зургийг хангалттай нягтаршилтай зургийн аппаратаар авч, паспорт, картад хавсаргасан.

Видео бичлэгийг машины урд шилэн дээр байрлуулсан видео бүртгэгчийн камераар хийсэн. Хангалттай өргөн өнцгөөр бичдэг учраас 100м өргөнтэй замын зурвас бүрэн хамрагдаж чадсан. Энэхүү GARMIN фирмийн 15.24см-ийн дэлгэцтэй, 800х600 пикселийн нягтралтай Nuvi CAM GPS-ийг ашиглаж, тооллого, бүртгэлд хамрагдсан нийт замын туршид тасралтгүй бичлэг хийсэн болно.Энэ бичлэгээс замын зурвасын ерөнхий байдал, замын тоноглолууд, замын ашиглалтын байдал, эвдрэлийг харах боломжтой.

Зам, гүүр дээр байнга ажиллах учраас, аюулгүй байдлыг хангах үүднээс, мөн хийж байгаа үйл ажиллагаагаа бусдад ойлгуулах зорилгоор багийн бүх бүрэлдэхүүнд гэрэл ойлгогчтой “Авто замын тооллого” гэсэн бичиг бүхий шар өнгийн хантааз өмсгөсөн.

Байршил тодорхойлох 2 төрлийн GPS ашигласан. Видео бүртгэгчийн Доктор компанийн Монгол орны газрын зурагтай GPS нь тогтмол шинэчлэлт хийдгээр онцлог байсан. Нөгөөх нь түгээмэл хэрэглүүлж байгаа GeoNet хэмээх арилжааны зорилготой GPS. Эдгээр GPS-үүд нь ойр зуурын хэрэглээнд боломжийн ч гэсэн, нилээд учир дутагдалтай. Улс, орон нутгийн чанартай урд нь тогтсон замууд хагас дутуу орсон учраас яг бидний ажилд шууд хэрэглэх боломжгүй, төөрөгдүүлэх магадлалтай байсан. Тухайлбал, А31 замаар, Дөргөнөөс Сар хайрханы гүүр чиглэлд явахад Хар нуурын хөвөөгөөр зам явахаар зурсан байх жишээтэй, зуны улиралд түүгээр явах ямарч боломжгүй. Тийм учраас Монгол оронд хэрэглэж байгаа Монгол хэл бүхий GPS-дэд ЗТХЯам зөвшөөрөл өгдөг байх шаардлагатай байна.


Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Garmin-ий хамгийн сүүлийн үеийн Nuvicam GPS, 135⁰-ын өнцгөөр бичлэг хийсэн төхөөрөмж



Зураг 2.4.1

Garmin-ий 64s загварын гар GPS



Зураг 2.4.2

2.5 Хээрийн хэмжилт хийсэн үйл ажиллагаа

Замын тооллого бүртгэлийн ажил гүйцэтгэхээр яваа бүх хүмүүс маш анхааралтай, өөр зүйлд сатаарахгүй, зөвхөн өөрийн үүрэгт ажлаа гүйцэтгэж, бусдад саад болохгүй байх шаардлагатай гэсэн зарчим баримталсан. Бага зэрэг л анхаарлаа сарниулахад ямар нэгэн зүйл аль хэдийн болоод өнгөрдөг тул, зогсох юм уу, буцаж явах зэргээр цаг алдаж, хэмжилтэд алдаа гарах эрсдэл үүсдэгийг байнга анхаарах хэрэгтэй. Хэмжилтийн хурдыг 40 км/цаг-аас хэтрүүлэх хэрэггүй юм байналээ.

Багийн нэг гишүүн бүртгэлийн журнал /ПК-ын журнал/ хөтөлж, нэг гишүүн нь GPS-ээс зай болон солбицолын өгөгдлүүдийг дуудаж, замын ашиглалтын байдлын ерөнхий үнэлгээ, тоноглолуудын байршлыг бичүүлнэ. 3 дахь гишүүн зураг авч, хэмжилт хийнэ. Гүүрэн дээр багийн бүх гишүүд ажилласан.

Замын уртыг гар GPS, видео бүртгэгчийн өгөгдлөөр хэмжсэн. Эдгээр багаж нь машин дотор тодорхой өндөрт байрлаж, хэмжиж байгаа газрын гадаргуугийн рельефийг өөрчлөлт болгонд давхар тодорхойлж өгдгөөрөө онцлогтой. Машины спидометрийг бараг ашиглаагүй, цаашид машины спидометрийг ашиглан замын урт хэмжихийг хориглох хэрэгтэй. Яагаад гэвэл дугуйн хэмжээ, дугуйн элэгдсэн байдлаас шалтгаалан машины, зай хэмжигч нь бодит хэмжээнээс зөрүүтэй заалт гаргадаг. Жишээ нь, 65-тай дугуй хэрэглэх ёстой машин 70-тай дугуй хэрэглэсэн үед, 100м замд 3.6 м дутуу хэмжиж, 96.4м гэх жишээтэй. Энэ нь 1км-т 36м, 10 км-т 360м, 100км-т 3.6км, 1000км-д 36км алдана гэсэн үг.

Замд тавьсан км-ын заалтын тэмдэгүүдийн байршил нь наанаа цаанабайснаас тооллогын баг ашиглах боломж муутай байсан. Ихэндээ замын тэмдэгүүд өм цөм алга болсон байв. Замын баруун, зүүн талд, хөвөө, хажуу бермд г.м-ээр замбараагүй байрлуулсан, тавьсан тоо нь аль цэгээс гэдэг нь ойлгомжгүй, хоорондын зай нь хол ойр г.м. Жишээ нь: Алтай-Дэлгэрийн хоорондох замд хоорондоо 600 м-ийн зайтай км-ын тэмдэг байсан. Өлгий-Ховдын км-ын тэмдэг буруу талдаа байх жишээтэй. Цаашид зам тэмдэгжүүлэх маш тодорхой заавар, дүрэмтэй болох шаардлагатай байна.

Бүх гүүр, хоолойнууд дээр зогсож хэмжилт хийж, зураг авсан. Гүүрийн хийц, ашиглалтын байдлын зураг авч, 100-аас дээш у/м гүүрүүдийн 2 захад солбицол авсан. Хоолойнуудын байршлын солбицолыг авч, ус орох, гарах амсаруудын фото зураг авсан. Мөн уртыг хэмжсэн.

Гүүрүүд дээр голдуу урсгалын дээд талаас нь фото зураг авч, тэдгээрийн урт, зорчих хэсэг, хайс хашлага, дугуй цохигч, явган хүний зам, алгасал, дам нуруу, дамжих хавтан зэргийг хэмжиж, дам нуруу, хөл тулгуур, тулах хэсгийн төрлийг тэмдэглэж, солбицолыг жижиг гүүрэн дээр нэг талд нь, том гүүрүүд дээр 2 талд нь тэмдэглэв.

Замын дэргэдэх байгууламжууд, зогсоолын талбай, давуулах далан, өөрийн болон уулын шуудуу, хамгаалалтын төхөөрөмжүүдэд хэмжилт хийж зураг авсан.

Зам дээр өдөр нь хийсэн бүх өгөгдлүүд, авсан зураг, хийсэн бичлэгүүдийг орой нь компьютер, хатуу дискүүдэд оруулан, хуулан авч байсан. Үндсэндээ нэг хоногт 12-16 цаг ажилласан. Тооллого, бүртгэлийн ажлаар явж байх үед амрах, байгалийн сайхантай танилцах, дуртай үедээ буудаллах бараг боломжгүй бөгөөд ингэх тохиолдолд бүх хэмжилтүүдийг зогсоож, дахин нөгөө цэгээс бүх зүйлээ шинээр эхлэх шаардлагатай болж, цаг хугацаа маш их алддаг.

Тухайн өдөр тооллого, бүртгэл хийсэн авто зам, замын байгууламжийн талаарх мэдээлэл, замын ашиглалтын байдлыг талаарх үнэлэлт, дүгнэлтээ тэр дор нь бичих юм уу,

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН


тэмдэглэж, 1-3 хоног дотроо дүнгээ гаргаж байсан болно. Шаардлагатай үед видео бичлэг үзэж нэмэлт тодруулга хийж байсан.

Баг тус бүрийн бүртгэл тооллого үеэр хөтлөж байсан ПК журнал буюу тэмдэглэл

DOSSIER : ETABLI PAR :	А 0401. 46-Дархан Хурлын (илтгэлийг хийсний дараа 2016 оны 11 сарын 14 өдөр /Шалгаралтын ажлын үндсэн дээр /Хурал /Хурлын үеэр 2016 оны 11 сарын 14 өдөр	Лууцаа № 03(7) Date: 12.08.2016
<p>Handwritten diagrams on grid paper showing various engineering calculations. The diagrams include:</p> <ul style="list-style-type: none"> Plan views (top-down) showing circular structures with dimensions like $d=1.6$, $d=1.4$, $d=1.46$, etc. Side elevations (vertical sections) showing heights and slopes. Technical drawings of pipes or conduits with diameters like $\varnothing 13.5$, $\varnothing 12.5$, etc. Handwritten notes in Mongolian explaining calculations and materials used. Reference to tables (e.g., Table 1, 2, 3, 4) and specific formulas like $L = 0.7$, $B = 0.4$. Material specifications such as "Асфальт-цементтэй хамтаар" (along with asphalt-cement). 		

Зураг 2.5.1

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



Зураг 2.5.2

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт"-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

✓		750 К/ШОН (304)	✓	814 К/ШОН	
✓		759 Х0=271	✓	813 К/ШОН	
✓		758 К/ШОН (303)	✓	812 Х0=295	
✓		757 Х0=270	✓	811 Х0=294	
✓		756 О/Х	✓	810 К/ШОН	
✓		755 К/ШОН 302	✓	809 К/ШОН	319
✓		754 Х0=269	✓	808 Х0=293	315
✓	□	753 □	✓	807 К/ШОН	317
✓		752 А-002	✓	806 Х0=292	
✓	○	751 ○	✓	805 К/ШОН; Х0=291	316
✓	○	750 ○	✓	804 Х0=290	
✓	△	749 △	✓	803 Х0=289	
✓		748 Х0=268	✓	802 К/ШОН; ХУУР	315
✓	○	747 ○	✓	801 ○	
✓	□	746 □	✓	800 ○	
✓		745 К/ШОН 301	✓	799 Х0=288	
✓	△	744 4 зам уурбар	✓	798	
✓	○/К	745 ШТС	✓	797 К/ШОН	317
✓		742 К/ШОН	✓	796 Х0=287	ХУУР
✓		741 △	✓	795 Х0=286	
✓	○/К	740 4 зам уурбар (14х)	✓	794 Х0=285	
✓		739 △	✓	793 К/ШОН	313
✓		738 ШТС	✓	792	
✓		737 □	✓	791	
✓	ХУУР	736 Салбар (заман)	✓	790 Х0=284	
✓		735 ○	✓	789 К/ШОН	312
✓	○	734 ○	✓	788 Х0=283	ХУУР
✓		733 К/ШОН (300)	✓	787 Х0=282	
✓		732 Х0=267	✓	786 Х0=281	
✓	Салбар	731 Салбар	✓	785 △	
✓		730 Х0=266	✓	784 ○	
✓	2 гудан	729 Хамт тогтоон	✓	783 Х0=280	
✓		728 Х0=265	✓	782 К/ШОН	311
✓		727 К/ШОН 299	✓	781 ○	
✓	2 гудан	726 Хамт тогтоон	✓	780 Х0=279	
✓		725 Х0=264	✓	779 К/ШОН	310
✓		724 К/ШОН 298	✓	778 Х0=278	
✓		723 Х0=263	✓	777 К/ШОН Х0=277	309
✓		722 К/ШОН 297	✓	776 К/ШОН	308
✓		721 Х0=262	✓	775	
✓		720 К/ШОН 296	✓	774 Х0=276	
✓		719 Х0=261	✓	773 Х0=275	307
✓	△	718	✓	772 ○	ХУУР
✓	△	717	✓	771	ХУУР
✓	○	716	✓	770 ○	
✓		715 ○	✓	769 К/ШОН	306
✓	△	714	✓	768 Х0=274	○/К
✓		713 Х0=260	✓	767 △	
✓		712 К/ШОН 295	✓	766 К/ШОН	305
✓		711 Х0=259	✓	765 Х0=273	
✓	К-234	710 △	✓	764	
✓	№45.34420	709 △	✓	763 △	
✓	Е108.98651	708 △	✓	762 ○	
✓		707 Х0=258	✓	761 Х0=272	

Зураг 2.5.3

2.6 Тооллого, бүртгэлийн ажилд орон нутгийн байгууллагуудын оролцсон байдал

Тооллого, бүртгэлийн ажилд орон нутгийн байгууллага болох аймаг сумдын захиргааны холбогдох мэргэжилтэн, аймаг бүрт байгаа Зам хариуцагч байгууллагын инженерүүдийг хамтатган оруулах чиглэл, удирдамжтай ажилласан. Энэ талаар Зам, тээврийн хөгжлийн сайд, аймгуудын Засаг дарга нарт албан тоот илгээж, орон нутгийн чанартай авто замын талаарх мэдээллийг Зөвлөхүүдийн багтай уулзаж өгөхийг хүссэн. 2-3 аймгаас бусад нь ямар ч хариу өгөөгүй. Яг сонгуулийн дараа үе байсан болоод ч тэр үү, уулзах хүн бараг олдоогүй.

Орон нутгийн замын сүлжээний мэдээлэл ирүүлэх талаар ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын албан тоотыг бүх аймгуудын захиргаа, зам хариуцагч байгууллагад явуулсан боловч 6 аймгаас бусад нь ямар нэгэн хариу өгөөгүй, ирүүлсэн материал нь шаардлага хангахааргүй байсан

Улсын чанартай замын тооллого, бүртгэлийн талаар, орон нутгийн чанартай замын дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлэх талаар аймгуудын зам хариуцагч байгууллагуудын ерөнхий инженерүүдтэй ЗТХ-ийн төвд уулзаж, товч семинари өгч мэдээлэл ирүүлэх маягт, холбоо барих хаягийг өгсөн боловч мөн хэдхэн /8 / аймгаас хагас дутуу материал ирүүлсэн.

Тооллого, бүртгэлийн ажил хийж байх явцдаа, зарим аймгуудын зам хариуцагч байгууллагаар орж, мэдээлэл авч, зарим чиглэлийн замаар хамтдаа явлаа.

Орон нутгийн төр, захиргааны байгууллагуудад орон нутгийн чанартай авто замын талаархи дэлгэрэнгүй, нарийвчилсан бүртгэл, мэдээлэл байдаггүй, багцаа баримжаа төдий хагас дутуу, материалтай юм байна гэдэг нь олон зүйлээр нотлогдлоо. Энэ нь, явуулсан албан тоотод хариу өгөхгүй байгаагаар, уулзсан ганц нэг хүмүүс нь тийм нарийн мэдээлэл ч байхгүй дээ гээд чимээгүй болдогоор, мөн энэ чиглэлийн ажлыг мэргэжлийн, тогтвортой хүнд хариуцуулж, төрийн ажлын залгамж чанарыг хадгалж чадаагүйгээр нотлогдож байгаа юм. Ер нь нийт зам бараг эзэнгүй болсон байна.

Орон нутгийн чанартай авто замын бүртгэлийг үнэн зөв гаргах зорилгоор Зөвлөх компаний зүгээс тухайн аймгийн орон нутгийн замыг сайн мэдэх, олон жил энэ чиглэлээр ажилласан албан бус зөвлөхүүдийн жагсаалт гарган, тэдэнтэй нэгбүрчлэн уулзаж, ярьж бүртгэлээ хянуулсан боловч зарим нь бас л хойрго, нэр төдий хандлаа.

Зөвлөхүүдийн энэ удаагийн явалтаар хийсэн улсын чанартай замуудын тооллого бүртгэлийн ажил нь өгсөн зардалд дөнгөж багтсан бөгөөд орон нутгийн замын үзлэг тооллогыг нарийвчлан хийхэд тодорхой хэмжээний нэмэлт зардал болон хугацаа зайлшгүй шаардлагатай болох юм байна гэдэг нь тодорхой болж, нэн яаралтай орон нутгийн замын бүртгэл тооллогыг хийж, татвар төлөгчдийн мөнгөөр барьсан олон арван зам, гүүрийг эзэнтэй болгож, үнэлж, холбогдох хуулийн дагуу үндсэн хөрөнгийн бүртгэлд авч, жил болгон тооллогод хамруулж байх нь зүйтэй юм гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД**

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: 6226 3168, Факс: (976-11) 312 315,
E-mail: info@mrt.gov.mn, http://www.mrt.gov.mn

2016.05.10 № 01/1978

танай _____-ны № _____-т

АЙМГУУДЫН ЗАСАГ ДАРГА
НАРТ

Орон нутгийн чанартай замын
сүлжээний талаар

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Авто замын салбарын норматив баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр 2015-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор “Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажил хийгдэж байна.

Энэ ажлын үр дүнд Монгол Улсын нийт ард түмний өмч болох нийтийн зориулалттай авто зам, замын байгууламж нь албан ёсоор үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд орж, эдийн засгийн эргэлтэд орох нөхцөл бүрдэж, Авто зам, замын байгууламжийн бүртгэл мэдээллийн энгийн, ойлгомжтой цахим сан бий болж, авто замын ашиглалт сайжрах болно.

Үүнээс гадна Та бүхний гаргаж өгсөн мэдээлэлд үндэслэн аймаг бүрт байгаа орон нутгийн чанартай замуудын дэлгэрэнгүй бүртгэл гаргаж, аймаг, сум, баг, суурин газрын хоорондох замын чиглэл, зураглалыг тодорхой болгож, замын сүлжээний уртыг баталгаажуулна. Мөн орон нутагт яаралтай засах шаардлагатай замуудын жагсаалт, ажлын тоо хэмжээг гаргах боломжтой болох юм.

Иймд аймаг, сум бүрийн авто замын сүлжээний зураглалыг багийн төв, суурин газрууд, бусад шаардлагатай цэгүүдийг оролцуулан 2016 оны 7дугаар сарын 05-ны дотор гаргаж, дээрх ажлыг гүйцэтгэхээр Зам, тээврийн яамтай гэрээ байгуулан ажиллаж байгаа “Ар Ди Эй Си” ХХК-ийн Зөвлөх инженерүүдийн багт албан ёсоор дараах хаягаар хүлээлгэн өгөхийг хүсье.

Зөвлөхүүд аймаг бүрт очиж, газар дээр нь хэмжилт судалгааны ажил хийж, хянаж баталгаажуулах болно.

Зөвлөхийн нэр: “Ар Ди Эй” ХХК
Холбогдох утас: 99110615 Монгол Улсын Зөвлөх инженер Н.Адилбиш
Цахим хаяг: adilbish2000@yahoo.com
Байршлын хаяг: Улаанбаатар, Баянгол дүүрэг, 3-р хороо,
Дунд голын гудамж, Далан даваа ХХК байр, МАЗИН оффис 502 тоот

САЙД



М.ЗОРИГТ

081155

Зураг 2.6.1

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: 6226 3168, Факс: (976-11) 312 315,
E-mail: info@mrt.gov.mn, http://www.mrt.gov.mn

2016.05.05 № 02/1921
танай _____-ны № _____-т

“ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВ” ТӨҮГ, УЛСЫН ЧАНАРТАЙ
АВТО ЗАМЫН ЗАСВАР АРЧЛАЛТ
ХАРИУЦАГЧ БАЙГУУЛЛАГУУДАД


Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол, Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Авто замын салбарын норматив баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр 2015-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор “Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт”-ын ажил хийгдэж байна.

Иймд дээрх ажлыг гүйцэтгэхээр Зам, тээврийн яамтай гэрээ байгуулан ажиллаж байгаа “Ар Ди Эй Си” ХХК-ийн ажилтан Зөвлөх инженерүүдэд улсын, орон нутгийн чанартай замуудын тооллого, бүртгэл, паспортжуулалттай холбоотой Ажлын даалгаварт тусгагдсан мэдээллүүдийг саадгүй шуурхай гарган өгч, батлагдсан удирдамжийг хэрэгжүүлэхэд нь бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэхийг үүгээр мэдэгдэж байна.

Хувийг: “Ар Ди Эй Си” ХХК-д ✓

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
БӨГӨӨД ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГА, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Н.ГАНИБАЛ

082689

Зураг 2.6.2

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт"-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: 6226 3168, Факс: (976-11) 312 315,
E-mail: info@mrt.gov.mn, http://www.mrt.gov.mn

2016.05.05 № 02/1921
танай _____-ны № _____-т

"ӨВӨРХАНГАЙ АЗЗА" ТӨХК-Д

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол, Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Авто замын салбарын норматив баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр 2015-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор "Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт"-ын ажил хийгдэж байна.

Иймд дээрх ажлыг гүйцэтгэхээр Зам, тээврийн яамтай гэрээ байгуулан ажиллаж байгаа "Ар Ди Эй Си" ХХК-ийн ажилтан Зөвлөх инженерүүдэд улсын, орон нутгийн чанартай замуудын тооллого, бүртгэл, паспортжуулалттай холбоотой Ажлын даалгаварт тусгагдсан мэдээллүүдийг саадгүй шуурхай гарган өгч, батлагдсан удирдамжийг хэрэгжүүлэхэд нь бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэхийг үүгээр мэдэгдэж байна.

Хувийг: "Ар Ди Эй Си" ХХК-д

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
БӨГӨӨД ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГА, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Н.ГАНИБАЛ

082702

Зураг 2.6.3

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Орон нутгийн замын мэдээллийг гарахын тулд зам хариуцагч байгууллагын инженерүүдтэй хамтран ажиллахаар 2017 оны 3-р сарын 20-нд уулзалт зохион байгууламж, зам хариуцагч байгууллагуудад хүсэлт хүргүүлсэн.

20/03/2017

Орон нутгийн чанартай Авто замуудын үндсэн мэдээлэл авах хүснэгт тараасан жагсаалт

№	Зам хариуцагч компани	Албан тушаал	Нэр	Утас	Имайл хаяг
1	Архангай АЗЗА	инженер	Н. Сүрэнжамц	99975814	Yondoo.1892-t
2	Багануур АЗЗА				
3	Жол ХХК	Ерөнхий инженер	М.Мүрэтбег	95420222	mahmetmuratbet @ychoo.com
4	Их богд зам ХХК				
5	Булган АЗЗА	Ерөнхий инженер	Т.Мөнх-Ариун	99053406	e.melodyya @mo.t.com
6	Говь-Алтай АЗЗА	Ерөнхий инженер	Б.Горгорын	99105183	duyara.mgl @ychoo.com
7	Дархан АЗЗА				
8	Дорноговь АЗЗА	Ерөнхий инженер	Ш.Эрмэнсавсар	99257339	ERDENE.SALZ @ychoo.com
9	Дорнод авто зам ХХК	Ерөнхий инженер	Т.Тогтог	99225517	Doornalartodon @ychoo.com
10	Завхан АЗЗА	Ерөнхий инженер	Г.Тогтог	96960696	Zurakh Aibol @ychoo.com
11	Орхон АЗЗА	Инженер	Т.Чинтэдаа	99091709	Chintuyata @ychoo.com
12	Өвөрхангай АЗЗА	Инженер	Г.Мягмар	99327599	g.miyamar @ychoo.com
13	Талын зам ХХК	Инженер	Н.Наранцэцэг	9528867	narantseceg @ychoo.com
14	Сэлэнгэ АЗЗА	инженер	Д.Наранцэцэг	99019156	Selenge.naran @ychoo.com
15	Төв АЗЗА	Ерөнхий инженер	Х.Батсайх	99091134	batoo-zam @ychoo.com
16	Увс АЗЗА	Ерөнхий инженер	Энх-Ормон	99954976	enkhorgil @ychoo.com
17	Хархорин АЗЗА	Инженер	Эрдэнэбат	99034295	erdenebat @ychoo.com
18	Ховд АЗЗА	Ерөнхий инженер	О.Ормон	99487545	ovoo-azza @ychoo.com
19	Хөвсгөл АЗЗА	инженер	Н.Батбаяр	91914709	nyambayar @ychoo.com
20	Хөвсгөл зам ХХК	инженер	Д.Солонго	98030375	solongod @ychoo.com
21	Харгуй ХХК	Ерөнхий инженер	Тимурбоатар	99048492	khargui-azza @ychoo.com
22	Эрдэнэсант АЗЗА		Ц.Батмунх	99712187	
23	Налайх АЗЗА	инженер	Ф.Мөнхтүвшин	95111012	mnkhuvshin @ychoo.com
24	Баянчандмань АЗЗА				
25	Борхойн зам ХХК	Ерөнхий инженер	С.Ододбаяр	96910726	orkhoiinzam @ychoo.com
26	Саруул харгуй ХХК				
27	Даш зам ХХК	Ерөнхий инженер	Г.Одод	88016646	dash-zam @ychoo.com
28	Ялгуусан ХХК	инженер	В.Батмунх	88097684	batmunkh-azza @ychoo.com
29	Халд ихг АЗЗБ	байцаагч	С.Тангир	99974369	bjnzrg @ychoo.com

Зураг 2.6.4

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



Зураг 2.6.5



Зураг 2.6.6

Уулзалтын дараа нийт 7 аймгаас орон нутгийн замын мэдээлэл ирснийг хавсралтаар орууллаа.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Зөвлөх компаний зүгээс орон нутгийн чанартай авто замын бүртгэлийг үнэн зөв гаргах зорилгоор тухайн аймгийн орон нутгийн замыг сайн мэдэх, олон жил энэ чиглэлээр ажилласан албан бус зөвлөхүүдийн жагсаалт гарган, ихэнх хүмүүстэй биечлэн уулзаж, утсаар холбогдож өөрсдийнхөө хүсэлтийг ойлгуулж туслалцаа хүссэн.

Орон нутгийн чанартай авто замын сүлжээг гаргахад ажилласан зөвлөхүүд

д/д	Аймгуудын нэр	Зөвлөхүүдийн нэр	Зөвлөхүүдийн ажлын туршлага	Холбоо барих утас, хаяг
1	Архангай	А.Баясгалан	Ахмад инженер, энэ аймгийн замын байгууллагын даргаар олон жил ажилласан	99089367
2	Баян-Өлгий	Б.Пунцаг	МУ-ын Хөдөлмөрийн баатар, Гавъяат барилгачин, автогрейдерчин	98155194
3	Баянхонгор	О.Мишиг	Ахмад инженер, энэ аймгийн уугуул	99145344
4	Булган	О.Бямбажав	Зөвлөх инженер, энэ аймгийн замын байгууллагын инженерээр олон жил ажилласан	99894888
5	Говь-Алтай	Загдбазар	Ахмад инженер, энэ аймгийн замын байгууллагын инженер, даргаар олон жил ажилласан	99053141
6	Говьсүмбэр	Р.Балжир	Зөвлөх инженер, энэ аймагт авто замын төсөл хэрэгжүүлсэн	99097571
7	Дархан-Уул	У.Эрдэнэбилэг	Ахмад инженер, энэ аймгийн замыг олон жил хариуцан ажилласан	99019804
8	Дорноговь	Чинбаатар	Энэ аймгийн замын байгууллагын ахмад ажилтан	99091478
9	Дорнод	Б.Лувсан	Зөвлөх инженер, энэ аймгийн уугуул, өмнөх МУ-ын авто замын сүлжээг боловсруулсан	99139413
10	Дундговь	Хүүхэнбаатар	Энэ аймгийн засаг даргаар ажиллаж байсан.	99996832
11	Завхан	Я.Цэндсүрэн	Зөвлөх инженер, энэ аймгийн замын байгууллагын инженерээр олон жил ажилласан	99075351
12	Орхон	Цогтгэрэл	Ахмад инженер, энэ аймгийн замын байгууллагын инженер, даргаар олон жил ажилласан	99356235
13	Өвөрхангай	З.Батбаяр	Мэргэшсэн инженер, энэ аймгийн уугуул, уяач	99113140
14	Өмнөговь	Мөнхжаргал	Өмнөговийн замын хэсгийн даргаар олон жил, аймгийн Газрын албаны даргаар ажиллаж байсан	99036012
15	Сүхбаатар	Батбаяр	Автто замын компаний захирал, энэ аймгийн уугуул	99113140
16	Сэлэнгэ	Булгантамир	Ахмад инженер, энэ аймгийн замын байгууллагын инженер, даргаар олон жил ажилласан	99021255
17	Төв	Д.Галбадрах	Энэ аймгийн зам, тээврийн байгууллагын ахмад ажилтан, даатгалын компанийн захирал	99059205
18	Увс	Л.Адилбиш	Зөвлөх инженер, энэ аймгийн уугуул, замын байгууллагын инженерээр олон жил ажилласан	99114526
19	Ховд	У.Пүрэвжав	Зөвлөх инженер, доктор, энэ аймгийн уугуул	99097358
20	Хөвсгөл	Болдбаатар	Энэ аймгийн замын байгууллагын болон аймгийн ИТХ-ын даргаар ажиллаж байсан	91910815
21	Хэнтий	Алтанзаяа	Энэ аймгийн замын байгууллагын болон аймгийн ИТХ-ын даргаар ажиллаж байсан	99990624

Зураг 2.6.7

2.7 Тооллого, бүртгэлийн суурин боловсруулалтын ажил

Суурин боловсруулалтын ажил нь бараг хээрийн тооллого, бүртгэлийн ажилтай зэрэгцэж эхэлсэн. Суурин боловсруулалтын ажлыг Зөвлөх “Ар Ди Эй Си” компанийн захирал, Авто замын инженер А.Золжаргал удирдлаа. Суурин боловсруулалтын ажил нь холбогдох программуудыг суулгах, багтаамж сайтай хатуу дискүүдийг худалдан авч, зохих багуудад хүргүүлэх, ирүүлсэн задгай мэдээллүүдийг цэгцлэх, багуудаас материал хүлээн авч эмхлэх, багуудыг мэдээллээр хангах зэрэг үйл ажиллагаанаас эхэлсэн.

2.7.1 Тооллогын бүртгэл

Хээрийн тооллого, бүртгэл, хэмжилтийг үндэслэн үндсэн 6 төрлийн тооллогын бүртгэл хөтлөв. Үүнд:

- Авто замын тооллогын бүртгэл – ТБ-01
- Гүүрийн тооллогын бүртгэл - ТБ-02
- Хоолойн тооллогын бүртгэл -ТБ-03
- Замын тэмдэг, тэмдэглэгээ, тоноглолын тооллогын бүртгэл - ТБ-04
- Замын хамгаалалтын байгууламжуудын тооллогын бүртгэл - ТБ-05
- Замын дэргэдэх үйлчилгээний байгууламжуудын тооллого, бүртгэл – ТБ-06

эдгээр болно.

Тооллогын бүртгэл хөтлөхдөө багуудын газар дээр нь явж хийсэн тооллого, хэмжилт, бүртгэлийг үндэслэв. Мөн видео бичлэгүүдийг ашиглаж, дахин нягталж, тодруулгыг хийлээ. Эдгээр үндсэн 6 тооллогын бүртгэлийн хүснэгт нь тооллогын товчоо нь юм. Эдгээр товчоо нь цаашаа нарийвчлан, нилээд явцуурч задарна. Тухайлбал: Авто замын тооллогын бүртгэл нь, Замын хучлагын төрлөөр ТБ-01.01, зам цаг уурын бүсчлэлээрТБ-01.02 гэж, ТБ-01.01 нь Асфальтбетон хучлагатай замын тооллогын бүртгэл ТБ-01.01.01, Цементбетон хучлагатай замын бүртгэл ТБ-01.01.02 гэх мэтээр задарна. /Боть1-д орууллаа./

Энэ 6 бүртгэл нь Авто замын бүртгэл мэдээллийн сангийн үндэс суурь нь болох бөгөөд, энэ бүртгэлд байгаа зам, гүүрүүдийн байршлыг нь үндэслэн кадастрын зураглал /замын зурвасын хязгаарын зураг/гаргаж, бүртгэлийг нь үндэслэн дахин үнэлгээ хийж, хөрөнгийн бүртгэлд авах шийдвэрийн төсөл бэлтгэсэн юм.

Эдгээр тооллогын бүртгэлийг үндэслэж, Зам, тээврийн хөгжлийн яамны бүртгэлд хөдөлгөөн хийж, бүртгэлийг шинэчлэх, нэгдсэн санд бүртгэх сайдын шийдвэр гарах болно. Энэ тухай Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулгын **10 дугаар зүйлд. Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх:** 10.1.10.олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах, **бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, үндсэн хөрөнгийн бүртгэлд оруулах, элэгдэл хорогдлыг тооцох, бүртгэлээс хасах ажлыг зохион байгуулах;**гэж яамны бүрэн эрхийг тодорхойлсон байгаа.

Тооллогын бүртгэлийг Авто замын тухай хуулийн 27.2-р заалтын дагуу Олон улс, улсын чанартай авто замын хэмжээнд гаргалаа. Хуулийн шинэчилсэн найруулгын дагуу тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журмыг Засгийн газар батлахаар байгаа. Энэ журам хараахан гараагүй байгаа учраас, ийм замууд л Тусгай зориулалтын замд орох болов уу гэсэн замуудыг зөвхөн бүртгэж, мэдээллийн санд орууллаа.

2.7.2 Олон улс болон улсын чанартай авто замуудын чиглэл, уртын шинэчлэлт

Ажлын даалгаварт тусгагдсаны дагуу, олон улс болон улсын чанартай нийт авто замын чиглэл, дугаарлалтыг шинэчилж, тэдгээрийг паспортжуулж, гүүр бусад хиймэл байгууламжуудад карт хөтлөв.

Бид одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрх зүйн баримт бичгүүдийн хүрээнд ажлаа дуусгаад, шийдвэрийн төсөл боловсруулан оруулах боломжтой байсан ч тэгээгүй, 2017 оны 5-р сард шинэчилсэн найруулга нь батлагдсан Авто замын тухай хуулийн дагуу, улсын чанартай авто замуудын шинэ чиглэл нэмэх, нэр, дугаарт өөрчлөлт оруулах шийдвэр гаргуулахаар ЗТХЯ, ЗТХ-ийн төвийн, энэ чиглэлээр олон жил ажилласан мэргэжилтнүүд, инженерүүдтэй хамтарсан хэлэлцүүлэг зохион байгуулж, 2017 оны 8-р сарын 08-ны өдөр “Авто замын чиглэлийн нэр, дугаар шинэчлэн батлах тухай” ЗТХ-ийн сайдын 159 тоот тушаал гаргуулж, 9-р сарын 01-нээс эхлэн мөрдөж байна.

Энэ тушаалын дагуу урьд нь бэлтгэсэн бүх тооллого, бүртгэлийн материалдаа өөрчлөлт оруулав. Мөн нэмэлт шинэ 9 чиглэлийн замыг паспортжуулах ажлыг хийсний дараа энэ тайлангийн “Хавсралт тайлан”-г гарна.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт"-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 159

Улаанбаатар хот

“Олон улс, улсын чанартай авто замын чиглэлийг шинэчлэн батлах тухай”

“Авто замын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.2; 15.3; 15.4 дэх хэсгүүдийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Олон улсын чанартай авто замын чиглэлийн нэр, дугаарын жагсаалтыг нэгдүгээр, Улсын чанартай авто замын чиглэлийн нэр, дугаарын жагсаалтыг хоёрдугаар, олон улсын болон улсын чанартай авто замуудын эхлэл, төгсгөлийн цэгийн тодорхойлолтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталж 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Улсын чанартай авто замын сүлжээнд шинээр чиглэл нэмэгдсэнтэй холбогдуулан тухайн замуудыг паспортжуулах, засвар арчлалт хариуцагчийг тогтоох, хөдөлгөөний бэлэн байдлыг хангаж ажиллахыг Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Доржханд/, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ /Р.Буд/-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Гомбосүрэн/-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 144 дүгээр, Зам, тээврийн сайдын 2016 оны 50 дугаар тушаалыг тус тус хүчингүйд тооцсугай.

САЙД

Д.ГАНБАТ

пЯ 432

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 08 дугаар сарын 08 -ны өдрийн 139 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМЫН ЧИГЛЭЛИЙН НЭР, ДУГААРЫН ЖАГСААЛТ

№	Авто замын чиглэлийн дугаар	Авто замын дугаар	Замын нэр	Замын урт, км
			УХА0382 5919467 1116126781	
		Улаанбаатар-Налайх-Чойр-Сайншанд-Замын үүд боомт		661.9
1	A01	A0101	Улаанбаатар-Чойр	224.5
2		A0102	Чойр-Сайншанд	221.4
3		A0103	Сайншанд-Замын-Үүд боомт	216.0
		Улаанбаатар-Мандалговь-Даланзадгад-Гашуунсухайт боомт		876.5
4	A02	A0201	Улаанбаатар -Мандалговь	271.5
5		A0202	Мандалговь-Даланзадгад	305.1
6		A0203	Даланзадгад /Цогтцэций/-Гашуунсухайт боомт	299.9
		Улаанбаатар-Арвайхээр-Баянхонгор-Алтай-Ховд-Өлгий-Цагааннуур боомт		1781.1
7		A0301	Улаанбаатар -Арвайхээр	412.3
8	A03	A0302	Арвайхээр-Баянхонгор	209.5
9		A0303	Баянхонгор-Алтай	395.9
10		A0304	Алтай-Ховд	438.9
11		A0305	Ховд-Өлгий	225.2
12		A0306	Өлгий-Цагааннуур боомт	99.3
		Улаанбаатар-Дархан-Сүхбаатар-Алтанбулаг боомт		345.2
13	A04	A0401	Улаанбаатар -Дархан	232.2
14		A0402	Дархан-Сүхбаатар	89.0
15		A0403	Сүхбаатар-Алтанбулаг боомт	24.0
		Улаанбаатар-Өндөрхаан-Чойбалсан-Сүмбэр боомт		1050.2
16	A05	A0501	Улаанбаатар- Өндөрхаан	306.1
17		A0502	Өндөрхаан-Чойбалсан	330.2
18		A0503	Чойбалсан-Сүмбэр боомт	413.9
		Элсэнтасархай-Хархорин-Цэцэрлэг-Тосонцэнгэл-Нөмрөг-Тэс-Арцсуурь боомт		852.2
19	A06	A0601	Элсэнтасархай-Хархорин	77.0
20		A0602	Хархорин-Цэцэрлэг	116.2
21		A0603	Цэцэрлэг-Тосонцэнгэл-Нөмрөг	462.3
22		A0604	Нөмрөг-Тэс-Арцсуурь боомт	196.7
23	A07	A07	Өлгий-Увсын Өлгий сум	213.1
24	A08	A08	Хархорин-Хужирт-Арвайхээр	90.3
		Дашинчилэн-Булган-Мөрөн		475.1
25	A09	A0901	Дашинчилэн-Булган	131.5
26		A0902	Булган-Мөрөн	343.6
		Дархан-Эрдэнэт-Булган		223.2
27	A10	A1001	Дархан - Эрдэнэт	169.5
28		A1002	Эрдэнэт-Булган	53.7
		Ханх боомт-Хатгал-Мөрөн-Улиастай-Алтай-Бургастай боомт		1200.2
29	A11	A1101	Ханх-Хатгал-Мөрөн	293.9
30		A1102	Мөрөн-Улиастай	390.9
31		A1103	Улиастай-Алтай	189.4
	Аттрибут хүснэгтийн талбар	Талбарын тайлбар
1	ROADCODE	Замын дугаар
2	ROADNAME	Замын нэр
3	AXIS	Тэнхлэг
4	N	Х тэнхлэг дэхь утга /DD буюу аравтын градус/
5	E	Ү тэнхлэг дэхь утга /DD буюу аравтын градус/
6	POINTS	Цэгүүд
7	LENGTH	Урт /м/
8	ID	ID
9	ZONE	Бүс

Хүснэгт 3.1.6

Замын зурвас газрын хүснэгтэн мэдээллийн тайлбар

Д/Д	Замын зурвас газрын хүснэгтэн мэдээллийн тайлбар	
	Аттрибут хүснэгтийн талбар	Талбарын тайлбар
1	ROADCODE	Замын дугаар
2	ROADNAME	Замын нэр
3	AREA	Талбай /га/

Хүснэгт 3.1.7

Гүүрийн хүснэгтэн мэдээллийн тайлбар


Д/Д	Гүүрийн хүснэгтэн мэдээллийн тайлбар	
	Аттрибут хүснэгтийн талбар	Талбарын тайлбар
1	ROADCODE	Замын дугаар
2	ROADNAME	Замын нэр
3	Road_maintenance	Зам хариуцагч байгууллага
4	Category	Гүүрийн төрөл
5	BRIDGENAME	Гүүрийн нэр/байршил/
6	N	Байршлын солбицол
7	E	
8	DATE	Ашиглалтанд орсон Огноо
9	SIZE	Гүүрийн овор хэмжээ, Г...
10	LENGTH/m/	Гүүрийн урт, у/м
11	STATUS	Гүүрийн ашиглалтын байдлын ерөнхий үнэлгээ

3.2 Авто зам, замын байгууламжийн мэдээллийн сан

3.2.1 Мэдээллийн сан үүсгэх

Авто зам болон замын байгууламжид хийсэн хээрийн хэмжилтийн материалыг багажнаас авч хүснэгт 3.1.2, 3.1.3, 3.1.4, 3.1.5, 3.1.6, 3.1.7 дугаар хүснэгтэд өгөгдсөн нэрээр бэлтгэсэн суурь өгөгдлийг ашиглан ArcGIS програмын.gdb өрөгтгөлтэй Database үүсгэсэн.


Нийт замын дугаар тус бүрээр 32 ангилалын 56 чиглэлийн авто зам, олон улсын чанартай авто зам, гүүр, хот суурин, улсын хил гэсэн ангилалаар нийт 60ш Dataset үүссэн байна.




Зураг 3.2.1

Dataset тус бүр нь дараах элементүүдийг агуулахаар үүсгэсэн.


Dataset доторх элементүүд:



Авто замын зурвас газар



Авто замын зурвас газрын цэгийн солбицол



Авто замын тэнхлэгийн цэг




Авто замын тэнхлэг

Зураг 3.2.2

3.2.2 Цэгэн элемент үүсгэх

Авто замын тэнхлэгийн дагуу хээрийн хэмжилтийн өгөгдлийг цэгэн мэдээлэл болгон зам тус бүрээр мэдээлэл үүсгэсэн.

Мэдээлэл үүсгэхдээ суурь “..”.gpx өргөтгөлтэй өгөгдлийг “..”.xls өргөтгөлтэй болгон өөрчлөн хувиргаж ArcGIS програмын “x,y” data add командыг ашиглан “Цэг” нэртэй “feature class” буюу авто замын тэнхлэгийг цэгэн элемент болгон замын өгөгдөл тус бүрийг хувиргаж оруулсан.



Зураг 3.2.2.1

Мэдээллийн сан үүсгэсэн байдлаас хархад нийт 56 чиглэлийн авто замын тэнхлэгийн дагуу 222565 цэг байна.

Авто замын тэнхлэгийн цэгэн элементийг хүснэгтэн мэдээлэл буюу “attribute table”-ийг замын дугаарыг тэнхлэгийн дугаараар, замын нэрийг замын замын эхлэл, төгсгөлийн газрын нэр, солбицол, хучилтийн төрөл, Shape-ийг үүсгэсэн хэлбэр “point” гэсэн өгөгдлөөр үүсгэсэн байдлыг зураг 3.2.2.2-т харуулав.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Авто замын тэнхлэгийн цэгэн элементийн хүснэгтэн мэдээлэл буюу attribute table


OBJECTID *	Замын дугаар	Замын нэр	N	E	Хүчилтэн төрөл	Shape *
1	A32	Шаамар-Зүүнбүрэн-Зэлтэр	50.1123	106.21822	сайжруулсан хөрсөн	Point
2	A32	Шаамар-Зүүнбүрэн-Зэлтэр	50.11226	106.21803	сайжруулсан хөрсөн	Point
3	A32	Шаамар-Зүүнбүрэн-Зэлтэр	50.11226	106.21803	сайжруулсан хөрсөн	Point
4	A32	Шаамар-Зүүнбүрэн-Зэлтэр	50.11226	106.21803	сайжруулсан хөрсөн	Point
5	A32	Шаамар-Зүүнбүрэн-Зэлтэр	50.11226	106.21803	сайжруулсан хөрсөн	Point
6	A32	Шаамар-Зүүнбүрэн-Зэлтэр	50.11226	106.21803	сайжруулсан хөрсөн	Point
7	A32	Шаамар-Зүүнбүрэн-Зэлтэр	50.11226	106.21803	сайжруулсан хөрсөн	Point
8	A32	Шаамар-Зүүнбүрэн-Зэлтэр	50.11226	106.21803	сайжруулсан хөрсөн	Point
9	A32	Шаамар-Зүүнбүрэн-Зэлтэр	50.11226	106.21803	сайжруулсан хөрсөн	Point
10	A32	Шаамар-Зүүнбүрэн-Зэлтэр	50.11226	106.21803	сайжруулсан хөрсөн	Point
11	A32	Шаамар-Зүүнбүрэн-Зэлтэр	50.11226	106.21803	сайжруулсан хөрсөн	Point
12	A32	Шаамар-Зүүнбүрэн-Зэлтэр	50.11226	106.21803	сайжруулсан хөрсөн	Point
13	A32	Шаамар-Зүүнбүрэн-Зэлтэр	50.11225	106.21793	сайжруулсан хөрсөн	Point
14	A32	Шаамар-Зүүнбүрэн-Зэлтэр	50.11211	106.21713	сайжруулсан хөрсөн	Point
15	A32	Шаамар-Зүүнбүрэн-Зэлтэр	50.11177	106.21499	сайжруулсан хөрсөн	Point

Зураг 3.2.2.2

Мөн Гүүрүүдийг хэмжилт хийсэн газрын солбицлоор цэгэн элементээр оруулж материалын төрлөөр 3 ангилав.

Нийт 348 гүүрээс ган гүүр 1ш, төмөрбетон гүүр 289ш, модон гүүр 58ш байна.


Гүүрүүдийг солбицол, төрлөөр нь ангилан оруулсан байдлыг зураг 3.2.2.3-д үзүүлэв.



Зураг 3.2.2.3

3.2.3 Шугаман элемент үүсгэх

Шугаман элемент буюу авто замын тэнхлэгийг үүсгэхдээ Arctoolbox цэсний Data Management Tools хэрэгслийн Points To Line командаар цэгэн элементийг ашиглан үүсгэлээ.




Зураг 3.2.3.2

ArcGIS программд мэдээллийн сан үүсгэхэд авто замын хучилтын төрлөөр нь нэгтгэн мэдээллийн сан үүсгэхдээ зураг 3.2.3.2-д тэнхлэгийг ангилсан байдлаар үүсгэсэнийг зураг 3.2.3.3 харуулав.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Хучилтын төрлөөр харагдах байдал, хүснэгтэн мэдээ



A0203_Trass

OBJECTID *	Shape *	Замын дугаар	Замын нэр	Замын үрт /км/	Хучилтын төрөл
1	Polyline	A0203	Даланзадгад-Гашуунсухайт боомт	231	асфальт бетон
3	Polyline	A0203	Даланзадгад-Гашуунсухайт боомт	10	хайрга
5	Polyline	A0203	Даланзадгад-Гашуунсухайт боомт	0.2	асфальт бетон
6	Polyline	A0203	Даланзадгад-Гашуунсухайт боомт	58.3	ердийн хөрсөн

4 (0 out of 4 Selected)


Зураг 3.2.3.3

Улсын чанартай авто замд одоогийн байдлаар асфальтбетон, цементбетон 24 зам, баригдаж байгаа 6 зам, хучилтын төрлөөр холилдсон 27 зам, ердийн хөрсөн 4 зам байна.

3.2.4 Полигон үүсгэх

Мэдээллийн санд олон улсын болон улсын чанартай авто замын зурвас газрыг тодорхойлон оруулах даалгаврын дагуу зурвас газрыг полигоноор дүрсэлсэн бөгөөд авто замын зурвас газрыг тодорхойлохдоо тэнхлэгээс нэг талдаа 50м буюу тус бүр тэнхлэгээс 2 тийш 50 м нийт 100 м-т үүсгэлээ. Авто замын замын зурвасыг үүсгэхдээ ArcGIS программын Geoprocessing цэсний Buffer tool ашиглан PLANAR аргаар үүсгэсэн.


Buffer үүсгэж буй байдал



Зураг 3.2.4.1

Замын зурвас газрын хүснэгтэн мэдээллийг үүсгэсэн байдлыг зураг 3.2.4.2-т харуулав.


Үүсгэсэн Buffer буюу замын зурвас газар түүний хүснэгтэн мэдээ



Зураг 3.2.4.2

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Нийт 56 чиглэлийн авто замын зурвас газарт 150000 га газар хамаарагдаж байна. Үүний дараа үүсгэсэн Buffer-ыг ашиглан зурвас газрын солбицлыг Construct point командыг ашиглан тодорхойлсон байдлыг зураг 3.4.3.3-д харуулав.



Зураг 3.4.3.3

Зурвас газрын солбицлыг тодорхойлсын дараа “..”.xls өргөтгөлтэй болгон хувиргаж хэвлэхэд бэлэн болгох ажил хийгдсэн бөгөөд түүнийг зураг 3.4.3.4-т харуулав.

Замын зурвас газрын солбицол

A0203 дугаартай Даланзадгад-Гашуунсухайт боомт чиглэлийн авто замын зурвас газрын солбицол

Д/Д	Тэнхлэг	Газарзүйн солбицол /DD/		Цэгүүд	Урт/м/	Д/Д	Тэнхлэг	Газарзүйн солбицол /DD/		Цэгүүд	Урт/м/
		N	E					N	E		
1	Баруун	43.92894	104.9473	1-2	50.00	1	Зүүн	43.92924	104.9485	1-2	50.00
2	Баруун	43.92854	104.9476	2-3	50.00	2	Зүүн	43.92885	104.9488	2-3	50.00
3	Баруун	43.92818	104.9479	3-4	50.00	3	Зүүн	43.9285	104.9492	3-4	50.00
4	Баруун	43.92782	104.9483	4-5	50.00	4	Зүүн	43.92812	104.9495	4-5	50.00
5	Баруун	43.92743	104.9486	5-6	50.00	5	Зүүн	43.92776	104.9499	5-6	50.00
6	Баруун	43.9271	104.949	6-7	50.00	6	Зүүн	43.92746	104.9504	6-7	50.00
7	Баруун	43.9268	104.9495	7-8	50.00	7	Зүүн	43.92716	104.9508	7-8	50.00
8	Баруун	43.9265	104.95	8-9	50.00	8	Зүүн	43.92686	104.9513	8-9	50.00
9	Баруун	43.9262	104.9504	9-10	50.00	9	Зүүн	43.92656	104.9517	9-10	50.00
10	Баруун	43.9259	104.9509	10-11	50.00	10	Зүүн	43.92626	104.9522	10-11	50.00
11	Баруун	43.9256	104.9514	11-12	50.00	11	Зүүн	43.92596	104.9527	11-12	50.00
12	Баруун	43.9253	104.9518	12-13	50.00	12	Зүүн	43.92566	104.9531	12-13	50.00
13	Баруун	43.925	104.9523	13-14	50.00	13	Зүүн	43.92536	104.9536	13-14	50.00
14	Баруун	43.9247	104.9528	14-15	50.00	14	Зүүн	43.92503	104.954	14-15	50.00
15	Баруун	43.92436	104.9532	15-16	50.00	15	Зүүн	43.92471	104.9544	15-16	50.00
16	Баруун	43.92404	104.9536	16-17	50.00	16	Зүүн	43.92443	104.9549	16-17	50.00

Зураг 3.4.3.4

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Төслийн ажлаар нийт 56 чиглэлийн авто замын зурвас газрын 550000 цэгийг тодорхойлов.

Төслийн ажлаар хийгдсэн хээрийн хэмжилт нь Монгол улсад мөрдөгдөж байгаа Собицолын WGS-84 систем, UTM тусгагт хийгдсэн болно.

Хээрийн хэмжилтийн боловсруулалтыг хийж Монгол улсын Геодези зураг зүйн улсын нэгдсэн мэдээллийн сангаас авсан солбицолын WGS-84 систем, UTM тусгагт хийсэн монгол орны суурь зурагт оруулсан байдлыг зураг 3.4.3.5-аар үзүүлэв.

Олон улсын болон Улсын чанартай авто замын сүлжээ, гүүрүүдийн байршил



Зураг 3.4.3.5

Энэ ажлын үр дүнд Монгол улсын олон улсын болон улсын чанартай авто замуудын тэнхлэг, зурвас газрыг кадастрын зураглалд оруулах өгөгдлүүд бэлэн болж холбогдох шийдвэр гаргах нөхцөл бүрдсэн гэж үзэж байна.

БҮЛЭГ 4

ОЛОН УЛС, УЛСЫН ЧАНАРТАЙ ЗАМ, ГҮҮРҮҮДИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭ, БҮРТГЭЛ

Авто зам, гүүрийн барилга байгууламжийн дахин үнэлгээг өртгийн хандлагын аргаар хийв. Орлох өртгийг, *Монгол улсын хөгжлийн нийгэм, эдийн засгийн хөтөлбөрүүдийн тооцоо судалгаанд ашиглах зорилгоор гаргасан нэгж хүчин чадлын төсвийн жишиг үнэлгээнд хэрэглэх барилга угсралтын ажлын үнийн өсөлтийн индексийг Үндэсний статистикийн хороотой зөвшилцөн жил бүр баталж, нийтэд мэдээлж байх үүргийг Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүлээлгэсэн*, Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 336 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, “Дэд бүтцийн байгууламж, инженерийн шугам сүлжээний нэгж хүчин чадлын төсвийн жишиг үнэлгээ”-гээр тооцсон.

Зам, гүүрийн дахин үнэлгээг хийхдээ орлуулах өртгийг 336-р тогтоолын 2-р хавсралт болох доорхи хүснэгтэд тусгасан нэгжийн үнэлгээгээр авсан болно.

6. Гүүр			
№	Гүүрийн төрөл	Гүүрийн зорчих хэсгийн өргөн	1 м-ийн төсвийн жишиг үнэлгээ /сая.төг/
1	Төмөр бетон	7 м	13.5
2	Модон	7 м	3.29
7. Авто зам			
№	Авто замын төрөл	Авто замын зорчих хэсгийн өргөн	100 м-ийн төсвийн жишиг үнэлгээ /сая.төг/
1	Асфальтан хучилттай	7 м	42.6
2	Хайрган хучилттай	7 м	24.6
3	Сайжруулсан шороон хучилттай	7 м	0.58

2009 онд зам, гүүрийн дахин үнэлгээ хийж байсан материалыг бид олж үзсэн. Гэхдээ энэ тооцоо хараахан албажаагүй бололтой юм билээ. Энэ талаар гарсан ямар нэгэн шийдвэр бид олж чадаагүй. Энэхүү дахин үнэлгээг мөн орлуулалтын өртгийн аргаар хийж байсан байна. Гэхдээ орлуулах өртгийг чухам ямар эх үүсвэрээс авсан нь тодорхой бус. Энэ үнэлгээг хийхдээ, зам, гүүрт элэгдэл тооцсон байна. Хэдийгээр энэ баримт бичиг албан бус боловч, дахин үнэлгээ хийж байсан оролдлого, эх сурвалж учраас бид анхаарлаа хандуулсан юм.

ЗТХЯ-ны яамны бүртгэлд байгаа зам, гүүрийн нарийвчилсан задаргааг холбогдох хүмүүсээс нь авч үзсэн. Тэр баримт бичгийг бид аль болохоор ашиглах гэж хичээсэн ч ямар ч боломжгүй байсан. Цахим программд оруулсан үндсэн хөрөнгийн нэрнээс эхлээд, объектуудад хэрхэн хуваасан нь ойлгомжгүй, анхны төсөв өртөг нь буруу байж болзошгүй ийм л баримт бичиг байсан. Тухайлбал: Үндсэн хөрөнгийн нэр гээд 3 үсэг тавьчихсан байх, Ховд талаас –р км гээд

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

биччихсэн, аль замынх нь бүү мэд, Өндөрхаан талаас гээд км бололтой тоо тавьчихсан 10 гүүрийн төсөвт өртөг яг адилхан байх жишээтэй.

Энэ жагсаалтыг хэрхэн хийсэн талаар мэдэх хүн бараг байхгүй учраас буруу зөвийг нь тунгаахад хэцүү байсан тул Зөвлөхүүд, тооллого, бүртгэлийн ажлынхаа үр дүнд тулгуурлан, шинэчилсэн бүртгэл гаргаж дахин үнэлгээ хийлээ.

Газар дээр нь хийсэн тооллого, бүртгэлийн үр дүнгээр, аль болохоор замын хэвшмэл болгосон багцуудаар, ашиглалтад орсон оноор, гүүр нэг бүрээр бүртгэлийг гаргалаа. Мөн хэсэгчилэн шинэчилсэн замуудыг гэрээнд заасан хүчин чадлаар бүртгэлд оруулав.

Зам, гүүрийн насжилтыг ашиглалтад орсон оноос эсвэл бүрэн шинэчлэлт хийсэн оноос тооцлоо. Зөвхөн харьцуулалт хийж харуулах зорилгоор зарим объектуудын балансын үнийг дээр дурдсан 2009 оны дахин үнэлгээний материалаас сонголоо.

Засгийн газрын 2010 оны 336-р тогтоолыг хэрэгжүүлэхээр, Зам, тээврийн сайдын баталсан “Авто замд үнийн индекс тооцох заавар батлах тухай” 2016 оны 42 тоот тушаалын дагуу 2010 оноос хойшхи үнийн өсөлтийн индексийн тооцож орлуулах өртгийг өсгөсөн. Ингэж үнийн өсөлтийг тооцсон орлуулах өртгийг гаргасан, өөрөөр хэлбэл бүртгэлд авах өртөгийг гаргасан.

Авто замын Зөвлөхүүд энэ үнэлгээг хүлээн зөвшөөрсөн боловч ашиглалтын байдалтай холбоо бүхий дараах 3 хүчин зүйлийг дахин үнэлгээнд тооцохыг санал болгож, аргачлалаа гаргаж өгсөн. Үүнд:

1. Газар дээр нь явж үзлэг, тооллого хийсэн Зөвлөхүүдээс зам, гүүрийн ашиглалтын байдалд өгсөн бодит үнэлгээг тооцох
2. Зам, гүүрийн насжилтыг тооцох
3. Тухайн объектод 1998 оноос хойш зарцуулсан засвар, арчлалтын хөрөнгийг тооцох

Эдгээр 3 хүчин зүйлийг тооцоод, ашиглалтын байдал, тухайн замд жил тутам зарцуулсан хөрөнгийн хэмжээг харгалзан бүртгэлд авах бодит үнэлгээг гаргасан. Зөвлөхүүд энэ үнэлгээгээр, бүртгэлд оруулах өртөг тооцож гаргахыг санал болгож байна.

Мөн зам, гүүрийн бүрэн сэргээн засах элэгдлийг тооцон гаргав. Үүнийг 2009 онд мөрдөж байсан аргачлалаар бодсон болно. Зам, гүүрийн өртгийг анхны балансын үнээс элэгдэл байгуулж өнөөгийн бодит өртгийг гаргах нь ихээхэн учир дутагдалтай болох нь харагдлаа. Яагаад гэвэл одоо ашиглагдаж байгаа өртөг, зардлаа аль хэдийн нөхчихсэн зарим зам, гүүрүүд хэвийн ашиглагдаж үүргээ гүйцэтгэж байна. Тухайлбал: Бүдүүний гүүр, Сайханы гүүр, Өвөрхангай чиглэлийн зам, Дархан чиглэлийн зам г.м. Зарим зам, гүүрүүд өртгөө нөхөж дуусаагүй хэрнээ эвдэрч, ашиглалтын шаардлага хангахгүй болсон байна. Тухайлбал: Ээвийн гүүр, Тэрхийн гүүр, Өндөрхаан чиглэлийн зам г.м

Ийм учраас элэгдэл тооцож зам, гүүрийн үлдэгдэл өртөг гаргах нь ашиглалтын бодит нөхцөлбайдалтай уялдахгүй хийсвэр үнэлгээ болно гэж үзээд Зөвлөхүүд энэ үнэлгээнээс татгалзаж байна. Цаашид зам, гүүрийн элэгдэлийг хэрхэн тооцож байх тухай нарийвчилсан заавар гаргажэдийн засгийн ямар тооцоололд ашиглах талаар чиглэл өгөх нь зүйтэй гэж үзэж байна.

Зөвлөхүүд, 2016 оны жилийн эцсийн байдлаар Олон улс, улсын чанартай авто замын /6.0 м-с доош урттай гүүр болон бусад бүх замын байгууламжууд орсон /нийт үнэ 4,583,830.43 сая төгрөг, 6.0м-с дээш урттай гүүрүүдийн нийт үнэ 318,811.69 сая төгрөг, бүгд 4,265,018.73 сая төгрөгийн

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

зам, гүүрийг төрийн нийтийн өмч болгон ЗТХЯ-ны үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд авах нь зүйтэй байна гэсэн тооцоо гаргаад байна.

4.1 Авто зам, гүүрийн дахин үнэлгээний товч тайлан

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

- 1.1. Үнэлгээний зорилго, зориулалт, хугацаа
- 1.2. Үнэлгээний ажлын тухай товч мэдээлэл
- 1.3. Үнэлгээний ажлын хууль эрх зүйн үндэслэл

ХОЁР. ҮНЭЛСЭН ХӨРӨНГИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

- 2.1 Зам, гүүрийн байгууламжийн бүртгэлийн талаар
- 2.2 Авто зам, замын байгууламжийн үнэлгээнд тавигдах шаардлага
- 2.3 Авто зам, гүүрийн байгууламжийн дахин үнэлгээний онцлог, харгалзах хүчин зүйлүүд
- 2.4 Монгол улсын авто зам, гүүрийн барилга байгууламжийн дахин үнэлгээнд баримталсан арга аргачлал
- 2.5. Зам, замын байгууламжийн ангилах тухай
- 2.6. Авто зам, гүүрийн барилга байгууламжийн дахин үнэлгээг орлуулах өртгийн хандлагын аргаар хийхдээ дараах эрх зүйн баримтуудын эх сурвалж, тайлбар

ГУРАВ. АВТО ЗАМ, ГҮҮРИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИНД ОРЛУУЛАХ ӨРТГИЙН ХАНДЛАГЫН АРГААР ХИЙСЭН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

- 3.1 Зам, гүүрийн дахин үнэлгээний дүн
- 3.2. Дахин үнэлгээний дүнг санхүүгийн тайланд тусгах тухай
- 3.3. Үнэлгээний баталгаа
- 3.4. Зөвлөмж

НЭМЭЛТ. ШОРООН ЗАМЫН БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ НӨЛӨӨЛӨЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Захиалагч: “Ар Ди Эй Си” ХХК

Захирал : А. Золжаргал

Гэрээний дугаар: 01

Гэрээ хийсэн огноо: 2016.04.10

Захиалагчийн хаяг: ХУД, Гутал оффис 302тоот

Цахим шуудан: rdac8888@gmail.com

Утас/факс: (976-99074526

Гүйцэтгэгч: “Итгэлт Бээс” ХХК-ий захирал, хөрөнгийн мэргэшсэн үнэлгээчин Ц.Баатар “Практикал даатгал” компанитай 2017 оны 1 дүгээр сард 1 жилийн хугацаатай байгуулсан мэргэжлийн хариуцлагын даатгалтай. Хөрөнгийн үнэлгээний ажлын 17 жилийн дадлага туршлагатай.

Хаяг: УБ хот, ЧД, 1-р хороо, Жигжиджавын гудамж-5, “Жи И Би”ХХК-ий байр 5 дугаар давхар 409 тоот.

Шуудангийн хаяг: УБ-13, ш/х-501

Цахим шуудан:tsend_baatar@yahoo.com

Утас/факс: (976-11) 70000601, 99151209

1.1. ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ЗОРИУЛАЛТ, ХУГАЦАА:

Үнэлгээний зорилго нь Монгол улсын Олон улсын, улсын чанартай Зам, гүүрийн байгууламжийн дахин үнэлгээг Санхүүгийн тайлагналын зориулалтаар үнэлэхэд оршино. Үнэлгээний ажлыг 2017 оны 10 сарын 2-ны өдрөөр дуусгавар болгон тайланг үйлдэв.

1.2. ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ:

Захиалагчийн ирүүлсэн үнэлгээнд холбогдолтой баримт мэдээлэлтэй танилцаж, зарим шаардлагатай нэмэлт материалыг Захиалагчаас гаргуулж авсан. Үнэлгээний ажилд зам гүүрийн зөвлөх инженерүүдийг татан оролцуулж, ашиглалтын болон чанар байдал, насжилт зэрэгт дүгнэлт гаргуулж үнэлгээнд ашигласан.

1.3. ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ:

- ✓ Үнэлгээний ажлын хууль эрх зүйн үндэслэл: Монгол улсын “Хөрөнгийн үнэлгээний тухай хууль”(2010.01.21)
- ✓ Хөрөнгийн мэргэшсэн үнэлгээчин Ц.Баатарт олгосон Хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийн 071200038 тоот гэрчилгээг Сангийн сайдын 2017 оны 44 тоот тушаалаар 3 жилээр сунгасан.
- ✓ Үнэлгээний ажлын арга зүйн үндэс: - Үнэлгээний олон улсын стандарт (ҮОУС, 2011 оны ес дэх хэвлэл), НББОУС, СТОУС, Монгол улсын холбогдох хууль эрхийн нормативын актууд.

Төслийн ажлын даалгаварт “Монгол улсын зам гүүрийн байгууламжийг дахин үнэлж, үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгах” гэж байгаа тул Үнэлгээний Олон Улсын Стандарт(ҮОУС)-д ийм төрлийн үнэлгээг улсын секторын санхүүгийн тайлагналын зориулалттай үнэлгээний ангилалд авч үздэг.

Санхүүгийн тайлангийн зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ нь өнөөгийн үнэ цэнийг тогтоох, тайлагнах явцыг хэрэгжүүлнэ.

ХОЁР. ҮНЭЛСЭН ХӨРӨНГИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1 ЗАМ, ГҮҮРИЙН БАЙГУУЛАМЖИЙН БҮРТГЭЛИЙН ТАЛААР

Монгол улсын эдийн засаг нийгмийн амьдралд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг дэд бүтцийн бие даасан томоохон салбар бол зам, гүүрийн барилга байгууламж юм. Энэ салбарын өнөөгийн байдлаас үзэхэд улсын хэмжээд нэгдсэн тооллого явуулж, дахин үнэлгээ хийж бүртгэлд авах асуудал төдийлэн нэг мөр болоогүй явж ирсэн нь ажиглагдаж байна. Тухайлбал, гүүрийн хувьд балансын өртөг байхгүй, зарим замын ашиглалтанд орсон хугацаа байхгүй, бүртгэлд тусгаагүй байх жишээтэй. Түүнчлэн хэдэн онд ямар арчлалт засвар хийсэн болох нь тодорхой бус гарсан зардлыг нийтэд нь тэгшитгэн хуваарилсан гэх мэт нь үнэлгээнд ашиглах боломжгүй, тодорхой бус байдал бий болгож байна. Замын ашиглалт, чанар байдлын хувьд шинэ хуучин замд харилцан адилгүй байна. Олон жилийн өмнө ашиглалтанд орсон зам гүүрийн ашиглалт сайн байгаа нь түүний чанартай холбоотой ч замын ачаалал, байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөл, засвар арчлалтын байдал зэрэг олон хүчин зүйлсээс хамааралтай байдаг аж. Бид үнэлгээнд дээрх тодорхой бус байдлыг Замын зөвлөх инженерүүдээс тусламж авч тодруулга хийсэн.

Дахин үнэлгээнд **ТООЛЛОГЫН ДҮНГЭЭР ГАРСАН ЗАМЫН УРТ 12587,26КМ, 15,221,05 У/М ГҮҮРИЙН УРТ** хамрагдсан.

Бүртгэлийн мэдээллээс үзэхэд зарим нэг зам, гүүрийн талаар мэдээлэл байхгүй, тодорхойгүй эсвэл насжилт өндөртэй байсан тул төслийн багийн зөвлөхүүдийн тусламжтайгаар зам гүүрийн урт, насжилтыг тодорхой болгосон. 2010 оноос өмнө баригдсан зам, гүүрийн байгууламжийн талаар бүртгэлд тусгасан үнийг МУ-ын ЗГ-ын 2010 оны 336 тогтоолын дагуу **“НЭГЖ ЧАДЛЫН ТӨСВИЙН ЖИШИГ ҮНЭ”**-ээр дүйцүүлэн 2010 оны орлуулалтын өртөгт шилжүүлэн үнэлэв. Харин 2010 оноос хойшхи бүртгэлд тусгасан шинээр тавьсан зам, гүүрийн санхүүжилтын мэдээллийг балансын өртөг болгон ашигласан болно. Үүн дээр үнийн өсөлтийг индексээр өнөөгийн үнэ цэнийг тооцоолов.

Төслийн багийн зөвлөхүүдийн өгсөн **АВТО ЗАМ, ГҮҮРИЙН АШИГЛАЛТЫН БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ**-нд үндэслэн зам гүүрийн ашиглалтын байдлын үнэлгээг тооцов. Өөрөөр хэлбэл элэгдлийг насжилтаар бус өнөөгийн чанар байдалтай уялдуулан мэргэшсэн зөвлөхүүдийн дүгнэлийг ашиглан орлуулалтын өртгийг бууруулсан. 2016.4.26 өдрийн 152 тушаалын дагуу “Авто зам, гүүрийн арчлалт, засварын ажлын зардлын суурь норм” ЗЗБД 84-021-2016-ыг ашиглан зохицуулах итгэлцүүр тооцон улсын чанартай зам, гүүрийн нэгж хэмжээнд ногдох засварын хөрөнгийн хэмжээний хувийг тогтоож, арчлалт, засварын ажлын зарцуулах нийт хөрөнгө оруулалтын хэмжээг гаргаснаар ашиглалтын байдал, тухайн замд жил тутам зарцуулсан хөрөнгийн хэмжж харгалзсан бүртгэлд авах бодит тоо буюу дахин үнэлгээний дүнг гаргасан.

2.2 АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ҮНЭЛГЭЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Зам гүүрийн байгууламжийг санхүүгийн тайлагналын зорилгоор үнэлгээ хийхэд хөрөнгөнд дараах шаардлагын 1-ээс доошгүйг биелүүлж байх ёстой. Үүнд:

- ✓ Хөрөнгийг цаашид ашиглах нь хууль зүйн хувьд зөвшөөрөгдсөн, бодит байдлын хувьд хэрэгжих боломжтой, эдийн засгийн шаардлагыг хангасан;
- ✓ Хөрөнгө нь цаашид тодорхой хугацаанд ашиглагдах боломжтой байна;
- ✓ Хариуцлагатай өмчийн эзэн, чадварлаг менежменттэй;
- ✓ Хөрөнгийг цаашид ашиглахгүй байх нь эдийн засгийн хувьд гарзтай тул зайлшгүй ашиглах шаардлагатай;
- ✓ Одоогийн эсвэл түүнтэй төстэй хэрэглэгчид өнөөгийн ашиглалтыг цааш нь үргэлжлүүлэх бололцоотой;
- ✓ Үзүүлж байгаа ажил, үйлчилгээ /бүтээгдэхүүн/ нь зах зээлтэй, хөрөнгө оруулагчдын анхаарлыг татах үндэслэлтэй

А. Санхүүгийн тайлангийн зориулалтаар хийсэн дахин үнэлгээ нь дараахи зарчмыг хангаж байх ёстой.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

- ✓ Монгол улсын хууль, тогтоол, тушаал, дүрэм, журманд нийцэж байх
- ✓ ОУНББС, СТОУС, ҮОУС зэрэгт нийцэж байх
- ✓ Тогтоосон орлуулах өртөг нь нөхөн үйлдвэрлэлийн зарчмыг хангаж байх
- ✓ Замын болон гүүрийн байгууламжийн үнийг тусад нь тогтоох

Б. Санхүүгийн тайлангийн зориулалтаар үл хөдлөх эд хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэхэд үйлчлүүлэгчээс дараах зүйлсийг бэлтгэн ирүүлсэн болно.

- ✓ Үнэлгээнд хамрагдах зам гүүрийн жагсаалт, тодорхойлолт/хүснэгтээр/
- ✓ Норм нормативийн баримт бичгүүд
- ✓ Балансын өртөг\ хагас дутуу\

В. Авто замын барилга байгууламжийн дахин үнэлгээ хийхэд мөрдөн ажилласан Олон Үнэлгээний болон Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын шаардлага, тодорхойлолтууд

НББОУС 16.6-д Бодит үнэ цэнэ гэдгийг дараах байдлаар тодорхойлсон байдаг. “Бодит үнэ цэнэ нь холбоогүй талуудын ажил гүйлгээгээр зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хооронд хөрөнгийг солилцох эсвэл өр төлбөрөөр тооцож болох дүнг хэлнэ”.

СТОУС нь өмч хөрөнгийн тайлагналын хоёр хэлбэр болох өртгийн болон зах зээлийн үнэ цэнийн загварыг хүлээн зөвшөөрдөг. ҮОУСХ-1-ийн 5.4-д заасны дагуу:

- ✓ Барилгын бодит үнэ цэнийг ихэвчлэн мэргэжлийн үнэлгээчин зах зээлийн нотолгоонд үндэслэн тогтооно. Үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь ихэвчлэн үнэлгээгээр тодорхойлогдсон зах зээлийн үнэ цэнэ байна. (НББОУС 16.32)
- ✓ Тасралтгүй үргэлжлэх бизнесийн үйл ажиллагааны салшгүй хэсэг болохоос бусад тохиолдолд үндсэн хөрөнгийн өвөрмөц шинж чанар болон ховор арилжаалагддаг байдал зэргээс шалтгаалан бодит үнэ цэнийг тогтооход зах зээлийн нотолгоо байхгүй үед тэдгээр хөрөнгийг орлогын болон элэгдэл тооцсон орлуулалтын өртгийн хандлагаар үнэлнэ. (НББОУС 16.33)

Тухайн хөрөнгөнд идэвхтэй зах зээл байгаа нөхцөлд бодит үнэ цэнийн ухагдахуун зах зээлийн үнэ цэнэтэй ижил утгаар хэрэглэгдэнэ.

Г. Үнэлгээний объектоо холбоотой үнэлгээний олон улсын стандартын тодорхойлолтууд

1) Хөрөнгө, түүнийг хүлээн зөвшөөрөх: Өнгөрсөн үйл явцын үр дүнд бий болсон, ирээдүйд ашиг авчрахаар хүлээгдэж байгаа тухайн аж ахуйн нэгжийн хяналтанд байгаа нөөц. Аж ахуйн нэгжид хөрөнгөөс орж ирэх ирээдүйн ашиг нь бодитой болсон бөгөөд өртөг, үнэ цэнийг нь бодитойгоор хэмжих боломжтой болсон үед түүнийг балансад хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. (Үнэлгээний нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, 3.4., 3.4.2)

2) Үл хөдлөх хөрөнгө: Биет байдлаараа газар, газраас салгаж үл болох хүний бүтээсэн эд зүйлс. (Үнэлгээний нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, 3.1)

3) Үл хөдлөх өмч: Үл хөдлөх хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бүх эрх, ашиг сонирхол, өгөөжийг агуулсан ойлголт бөгөөд өмчлөлийн баталгаа (өмчлөлийн гэрчилгээ)-аар илэрхийлэгдэнэ. (Үнэлгээний нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, 3.2)

4) Үнэ: Бараа үйлчилгээнд хүссэн, санал болгосон буюу төлсөн мөнгөн дүн. (Үнэлгээний нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, 4.2)

5) Өртөг: Бараа үйлчилгээнд төлсөн үнэ эсвэл бараа үйлчилгээг үйлдвэрлэн бүтээхэд шаардагдах дүн. Бараа үйлчилгээнд төлсөн дүн нь худалдан авагчийн хувьд өртөг болно. (Үнэлгээний нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, 4.3)

6) Үнэ цэнэ: Бараа үйлчилгээний арилжаанд оролцогч талуудаар тогтоогдсон үнэтэй холбоо бүхий эдийн засгийн ухагдахуун. Үнэ цэнэ нь бараа үйлчилгээний зарагдаж болох үнийн тооцоо/үнэлгээ юм. (Үнэлгээний нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, 4.5)

7) Бодит үнэ цэнэ: Холбоогүй талуудын ажил гүйлгээгээр зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хооронд мөнгө солилцох эсвэл өр төлбөрөөр тооцож болох дүнг хэлнэ (НББОУС 16. 6, 17, 4, ҮОУС-2, 3.2).

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

8) Үнэлгээний хандлага: Ерөнхийдөө нэг буюу түүнээс дээш тооны үнэлгээний хандлагуудыг ашиглан үнэ цэнийг тогтоох арга зам. Үнэлэгдэх хөрөнгийн мөн чанар, зориулалтаас хамаарч үнэлгээний 3 хандлагыг хэрэглэнэ. Үүнд: зах зээлийн жишиг үнийн хандлага, орлого капиталжуулалтын хандлага, өртгийн хандлага зэрэг орно. Эдгээр хандлагууд нь үнэлгээчинд зах зээлийн үнэ цэнийг эсвэл зах зээлийн бус үний цэнийг тодорхойлох боломж олгоно. (ҮОУС-ын ХЗ 4, 3.23, ХЗ 5, 3.20, ХЗ 6, 3.38)

9) Зах зээлийн жишиг үнийн хандлага: Ижил төстэй болон орлуулагч хөрөнгийн борлуулалт ба холбогдох зах зээлийн мэдээллийг харгалзан харьцуулалт хийх замаар үнэ цэнэ тогтоодог хандлага. Ерөнхийдөө үнэлэгдэж буй хөрөнгө нь зах зээл дээр арилжаалагдаж байгаа ижил төстэй хөрөнгийн борлуулалттай жишигдэнэ. (Үнэлгээний нийтээр дагаж мөрдөх зарчим, 9.2.1.1)

10) Орлого капиталжуулалтын хандлага: Үнэлэгдэж буй өмчтэй холбоотой орлого, зарлын мэдээг судлан капиталжуулах үйл явцаар үнэ цэнэ тогтоодог хандлага. Энэ хандлагад цэвэр орлого болон хорогдуулах хувийн харилцан уялдааг авч үздэг. (Үнэлгээний нийтээр дагаж мөрдөх зарчим, 9.2.1.2)

11) Өртгийн хандлага: Тодорхой өмчийн худалдан авалтыг нэг бол ижил төрлийн өөр хөрөнгөөр эсвэл яг адил ашигт чанар бүхий хөрөнгөөр орлуулах боломжит өртгөөр үнэ цэнэ тогтоодог хандлага. Энэ хандлагаар үнэлэх үнэлгээчний үнэлгээ нь хуримтлагдсан элэгдлийг хассан тухайн хөрөнгийн нөхөн үйлдвэрлэлтийн эсвэл нөхөн орлуулалтын өртөгт үндэслэнэ. (Үнэлгээний нийтээр дагаж мөрдөх зарчим, 9.2.1.3)

12) Элэгдэл тооцсон орлуулалтын өртөг: Хөрөнгийг тухайн үеийн адил хөрөнгөөр орлуулан биет болон бүх төрлийн элэгдэл хоцрогдол болон оновчлолыг хассан өнөөгийн өртөг. (ҮОУСХэрэглээ 3, 3.1)

13) Элэгдэл тооцсон орлуулалтын өртөг нь зах зээлийн шууд нотолгоо хязгаарлагдмал үед санхүүгийн тайлагналын зориулалтаар тусгай хөрөнгийг үнэлэхэд хэрэглэгддэг өртгийн хандлагын хэрэглээ юм. Өртгийн хандлагын хэрэглээ болохын хувьд энэ нь орлуулалтын зарчимд нийцдэг. (ҮОУС-ын ХЗ 8, 1.2)

14) Элэгдэл тооцсон орлуулалтын өртгийг зах зээлийн нотолгоо хангалтгүй үед зах зээлийн үнэ цэнийг тооцоход хэрэглэнэ. (ҮОУС-ын ХЗ 8, 4.1)

15) Дээд зэргийн үр ашигтай хэрэглээ: Биет байдлаараа боломжтой, зохих ёсны үндэслэлтэй, хууль ёсоор зөвшөөрөгдсөн, санхүүгийн хувьд биелэгдэх, өндөр үнэ цэнээр үнэлэгдэх өмчийн хамгийн боломжит ашиглалт. (Үнэлгээний нийтээр дагаж мөрдөх зарчим, 6.3)

16) Ашигтай хугацаа: Хөрөнгийг ашиглахаар тооцоолж буй хугацаа. (НББОУС 16. 6, 36.6, СТОУС 17.13)

17) Үнэлгээний тайлан: Үнэлгээний үндэслэл, зорилго болон үнэ цэнийн саналд хүргэдэг судалгаа, шинжилгээний үр дүн, ажлын зааварчилгаа, удирдамжуудыг тусгасан баримт бичиг. Тайлангийн агуулга, төрөл, хэлбэр хэмжээ нь хэрэглэгч, эрх зүйн шаардлага, ажлын шинж чанар, нарийн төвөгтэй байдал зэргээс хамаарна. (ҮОУС 3, 3.5)

18) Хөрөнгийн үнэлгээний тайлан нь дараахь шаардлагад нийцсэн байна. (Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 9.2) Үүнд:

а. Хөрөнгийн үнэлгээний суурийг тодорхойлохдоо тухайн хөрөнгийн үнэлгээний зүйлийн шинж байдал, онцлогт үндэслэсэн байх;

б. Хөрөнгийн үнэлгээ хийх явц дахь хөрөнгийн үнэлгээний стандарт, дүрэм, журам, норм, нормативыг зөрчсөн аливаа тохиолдлын талаар тэмдэглэсэн байх;

с. Хөрөнгийн үнэлгээний зүйлийн тогтоосон үнэ цэнэ зохих үндэслэл бүхий, тодорхой байх.

Бид үнэлгээ хийхдээ дээрх шаардлага, тодорхойлолтуудыг удирдлага болгосон. Үнэлж буй хөрөнгүүдийн бодит үнэ цэнийг үнэлгээний өдрөөр тогтоож, тухайн хөрөнгийн бизнесийн ач холбогдлыг тодорхойлох зориулалттай. Дээрх зориулалтаар үнэлэгдэх хөрөнгийн үнэлгээнд холбогдох үнэлгээний олон улсын стандартуудыг ашиглав. Үүнд:

- ✓ Үнэлгээний олон улсын стандарт 101. Үнэлгээний ажлын хамрах хүрээ
- ✓ Үнэлгээний олон улсын стандарт 102. Хэрэгжилт

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт"-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

- ✓ Үнэлгээний олон улсын стандарт 103. Тайлагнал
- ✓ Үнэлгээний олон улсын стандарт 230. Үл хөдлөх өмч

Үнэлгээнд дээрх стандартуудыг ашиглахаас гадна үнэлгээний өдрөөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрх зүйн актуудыг мөрдлөг болгов. Үнэлгээг олон улсын стандартад заасан арга, хандлагуудыг ашиглан гүйцэтгэлээ. Барилгын үнэлгээнд “Үнэлгээний олон улсын стандарт”-д заасны дагуу өртгийн хандлагыг ашиглаж, дахин үнэлгээний дүнг үнэлгээний өдрөөр тогтоов.

Үнэлгээнд үндсэн хөрөнгийн бүртгэл зэрэг мэдээллийн эх сурвалжуудыг баталгаажуулан авахын зэрэгцээ барилгын материалын үнийн индекс, инфляцийн түвшин зэрэг холбогдох мэдээллийн эх сурвалжийг өргөнөөр ашигласан.

2.3. АВТО ЗАМ, ГҮҮРИЙН БАЙГУУЛАМЖИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ ОНЦЛОГ, ХАРГАЛЗАХ ХҮЧИН ЗҮЙЛҮҮД

Зам гүүрийн барилга байгууламжийн үнэлгээнд замын төрөл, зорчих хэсгийн өргөн, зузаан, замын зэрэглэл, анхны өртөг, нэмэлт хөрөнгө оруулалт, засвар үйлчилгээ, үнийн өсөлт, инфляци зэрэг хүчин зүйлүүдийг дахин үнэлгээнд харгалзан үзэхээс гадна ойрмогхон ашиглалтанд орсон зам, замын байгууламжуудаас зэрэгцүүлж болохоор хэд хэдэн мэдээллийг олж, хооронд нь харьцуулан уялдаа холбоог нарийвчлан судалж, үнэ өртгөнд нөлөөлж байгаа хүчин зүйлсийн ялгааг гаргаж тохируулга хийдэг. Үнэ, цэнийн зөрүүтэй байдлыг бий болгож байгаа ялгаануудыг шинжилж тохируулга хийхэд үнэлгээчид тоон болон чанарын аргуудыг хэрэглэдэг.

Тоон аргаар шинжлэх арга: Нэгжийн дундаж үнэ, цэнэ болон Үнэ цэнийн харьцаа

Чанарын аргаар шинжлэх нь: Зам, замын байгууламжийн үнэ цэнэтэй байхад хамгийн их нөлөөтэй хүчин зүйлс бол түүний байрлал, хаанаас хаа хүртэл үргэлжлэх гэх мэт байна. Үнэ, цэнэд хамгийн их нөлөөтэй хүчин зүйлсийг зэрэгцүүлэх нэгжээр сонгох нь үнэлгээг бодитой үнэн зөв болоход чухал нөлөө үзүүлнэ.

2.4. МОНГОЛ УЛСЫН АВТО ЗАМ, ГҮҮРИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНД БАРИМТАЛСАН АРГА АРГАЧЛАЛ

Энэхүү дахин үнэлгээнд “хөрөнгийн үнэлгээний тухай” хуулийн 8.1-д заасан орлогын, өртгийн, жишиг үнийн аргуудыг хослуулан хийх үндэслэлгүй. Учир нь манай улсын нөхцөлд зам гүүрийн ашиглалт, үйлчилгээг улс хариуцаж, улсын төсвөөс санхүүжиж байгаа тул орлогын хандлагын аргаар үнэлэх боломжгүй. Цаашдаа зам ашигласны үйлчилгээний төлбөр тооцоонд шилжиж, хууль эрх зүйн орчин бүрдсэн тохиолдолд орлогын хандлагын аргыг ашиглах боломжтой. Бид зам гүүрийн байгууламжийг үнэлэхдээ анхны өртөгөөс хойшхи үнийн өсөлт, засвар үйлчилгээ, элэгдлийн хувь хэмжээ, замын зэрэглэл, зам гүүрийн барилга байгууламж барихад Монгол улсад баримталж буй норм, норматив зэрэг олон хүчин зүйлийг харгалзан ҮОУС-ын дагуу өнөөгийн үнэ цэнэд шилжүүлэх тохируулах итгэлцүүр ашиглан өнөөгийн үнэ цэнийг тодорхойлсон.

2.5. ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН АНГИЛАХ ТУХАЙ

Зам, замын байгууламжийн тооллогын дүн, ангилалын дагуу замын бүтээц хийц, засвар, ашиглалтын өнөөгийн байдалд өгсөн үнэлэлт дүгнэлтийг мэргэжлийн байгууллагаас авч үнэлгээнд ангилалын дагуу ашигласан.

2.6. АВТО ЗАМ, ГҮҮРИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭГ ОРЛУУЛАХ ӨРТГИЙН ХАНДЛАГЫН АРГААР ХИЙХДЭЭ ДАРААХ ЭРХ ЗҮЙН БАРИМТУУДЫН ЭХ СУРВАЛЖ, ТАЙЛБАР

Балансын өртөг: Зам Тээврийн Яамнаас өгсөн 2009 онд хийсэн бүртгэлийн материалыг үндэслэв.

Нэгж чадлын төсвийн жишиг үнэ. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 336 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, ДЭД БҮТЦИЙН БАЙГУУЛАМЖ, ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ НЭГЖ ХҮЧИН ЧАДЛЫН ТӨСВИЙН ЖИШИГ ҮНЭЛГЭЭ-Г тооцсон.

Дэд бүтцийн байгууламж, инженерийн шугам сүлжээний нэгж хүчин чадлын төсвийн жишиг үнэлгээ

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

№	Гүүрийнтөрөл	Гүүрийнзорчиххэсгийнөргөн	1м-ийн төсвийнжишигүнэлгээ, төгрөг
1	Төмөрбетон	7 м	13,500,000
2	Модон	7 м	3,290,000
7. Автозам			
№	Автозамынтөрөл	Авто замын зорчих хэсгийн өргөн	1 км-ийн төсвийн жишиг үнэлгээ, төгрөг
1	Асфальтанхучилттай	7 м	426,000,000
2	Хайрганхучилттай	7 м	246,000,000
3	Сайжруулсаншороонхучилттай	7 м	5,800,000

Нийт хүчин чадлын төсвийн жишиг үнэ: Нэгж чадлын төсвийн жишиг үнийг нийт тоо хэмжээгээр үржүүлсэн дүн.

Үнийн өсөлтийн индекс: Зам тээврийн газраас өгсөн материалыг үндэслэн2011-2013 оны Үнийн индекс гаргахад ашигласан объектуудын барилгын ажлын зардлын ерөнхий индексийн харьцуулалтын (index2015.12.09xlsx) хүснэгтээс авч ашиглав.

№	Объектыннэр	Хүчинч адал	Замын уур амьсгалын бүс	2011	2012	2013	2014	ler
Автозам км								
1	Мандалговь-Өндөрдов чиглэлийн авто зам	16	III A	1.14	1.51	1.65	1.51	1.36
2	Өлгий-Цагааннуур чиглэлийн авто зам	40	IV	1.10	1.30	1.36	1.47	1.25
3	Өндөрхаан-Сүмбэр чиглэлийн авто зам	50	IIV	1.12	1.39	1.39	1.48	1.27
	Хатуу хучилттай автозамын дундач			1.12	1.40	1.47	1.49	1.29
4	Тосонцэнгэл-Улиастайн чиглэлийн авто зам, 63 у/м төмөрбетонгүүр /2-р хэсэг/	54	IIA	1.09	1.28	1.30	1.36	1.21
5	Мөрөн –Хатгал чиглэлийн авто зам, 65 у/м төмөрбетон гүүр	98.85	IA	1.15	1.54	1.58	1.65	1.39
	Хатуу хучилттай авто замын дундач			1.12	1.41	1.44	1.51	1.30
Б. Гүүр у/м								
1	Хөвсгөл, Жаргалант Идэрийн голын 163.1 у/м төмөрбетон гүүр	163.1	IIA	1.20	1.37	1.30	1.37	1.25

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

№	Зардлын нэр	2010, 2014 оны үнийн индекс					2010, 2015 оны үнийн индекс				
		Нийт зардалд эзлэх хувийн жин- <i>q</i>	Төсөвт зардал		Хувийн жинд ноогдох зардлын хэмжээ		Төсөвт зардал		Хувийн жинд ноогдох зардлын хэмжээ		
			Суурь үеийн /2010он/- <i>Pc</i>	Тайлант үеийн /2014 он/- <i>Pt</i>	Тайлант үеийн /2014 он/- <i>Pt</i> * <i>q</i>	Суурь үеийн /2010 он/- <i>Pc</i> * <i>q</i>	Суурь үеийн /2010он/- <i>Pc</i>	Тайлант үеийн /2015 он/- <i>Pt</i>	Тайлант үеийн /2015 он/- <i>Pt</i> * <i>q</i>	Суурь үеийн /2010 он/- <i>Pc</i> * <i>q</i>	
1	Ажилчдын цалин	0.21	1 423.82	1 946.16	4.02	2.94	1 423.82	1 946.16	4.02	2.94	
2	Тээвэр, машин ашиглалтын цалин	2.88	19 804.00	19 804.00	569.65	569.65	19 804.00	19 804.00	569.65	569.65	
3	Ажилчдын нэмэгдэл цалин	0.47	3 205.00	3 205.00	14.92	14.92	3 205.00	3 205.00	14.92	14.92	
4	Талбайн ИТА-гийн цалин	0.31	2 110.94	2 110.94	6.47	6.47	2 110.94	2 110.94	6.47	6.47	
5	Алслалын нэмэгдэл цалин	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	
6	Нийт цалин		26 543.76	27 066.10	0.00	0.00	26 543.76	27 066.10	0.00	0.00	
7	Нийгмийн даатгалын шимтгэл	0.50	3 450.69	3 518.59	17.63	17.29	3 450.69	3 518.59	17.63	17.29	
8	Машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалт	1.59	10 965.64	15 083.44	240.23	174.65	10 965.64	12 469.00	198.59	174.65	
9	Материал	45.57	313 718.00	521 290.95	237 530.75	142 948.33	313 718.00	493 513.00	224 873.49	142 948.33	
10	Тээвэр	1.06	7 322.00	7 322.00	77.87	77.87	7 322.00	7 322.00	77.87	77.87	
11	Багаж хэрэгсэлийн элэгдэл	0.00	30.00	30.00	0.00	0.00	30.00	30.00	0.00	0.00	
12	Ажлын хувцасны элэгдэл	0.12	806.00	806.00	0.94	0.94	806.00	806.00	0.94	0.94	
13	Тур барилгын элэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	
14	Нүүлгэн шилжүүлэх зардал	30.25	208 264.00	208 264.00	62 998.27	62 998.27	208 264.00	208 264.00	62 998.27	62 998.27	
15	Шууд зардлын дүн		571 100.09	803 494.70	0.00	0.00	571 100.09	752 988.70	0.00	0.00	
16	Удирдлагын зардал 63.5%	2.45	16 855.29	17 186.98	420.76	412.64	16 855.29	17 186.98	420.76	412.64	
17	Ашиг 71.8%	2.77	19 058.42	19 433.46	537.94	527.56	19 058.42	19 433.46	537.94	527.56	
18	Ажиллагсдын даатгал	0.27	1 884.00	1 884.00	5.16	5.16	1 884.00	1 884.00	5.16	5.16	
19	Машин механизм, тоног төхөөрөмжийн даатгал	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	
20	Барилга, утгалтын ажлын даатгал	0.60	4 156.00	4 156.00	25.09	25.09	4 156.00	4 156.00	25.09	25.09	
21	Ажиллагсдын хээрийн нэмэгдэл	0.07	507.93	507.93	0.37	0.37	507.93	507.93	0.37	0.37	
22	Дүн		613 561.73	846 663.07	0.00	0.00	613 561.73	796 157.07	0.00	0.00	
23	Захиалагчийн хяналтын зардал 2%	1.73	11 930.05	16 587.94	287.43	206.72	11 930.05	15 577.82	269.93	206.72	
24	Магадлашгүй ажил	0.08	541.03	551.48	0.43	0.43	541.03	551.48	0.43	0.43	
25	НоАТ 10%	8.91	61 356.17	84 666.31	7 545.17	5 467.85	61 356.17	79 615.71	7 095.08	5 467.85	
26	Норм, нормативын сан 0.18%	0.16	1 104.41	1 523.99	2.44	1.77	1 104.41	1 433.08	2.30	1.77	
27	Дүн	100.00	688 493.40	949 992.79	310 285.57	213 458.94	688 493.40	893 335.16	297 118.93	213 458.94	
			Зардлын өөрчлөлтийн ерөнхий индекс			1.45					1.39

Зөвлөхүүдийн өгсөн зөвлөмжийн дагуу авто замын зарим гол ажил, 1 у/м гүүрийн барилгын ажлын нэр төрлөөр суурь оны болон тайлант үеийн нэгж үнийн харьцуулалтыг 2014, 2015 оноор хийж үнийн индекс тооцсон үнэлгээг 2014, 2015 оны индекс болгон ашиглаж 2011-2015 оны индексүүдийн дундаж гаргав.

Орлуулах өртгийн суурь үнэ. буюу өнөөгийн үеийн үнийн өсөлтийг гаргахдаа нийт хүчин чадлын төсвийн жишиг үнийг суурь үнийг дундаж индексээр үржүүлнэ.

ЗОХИЦУУЛАХ ИТГЭЛЦҮҮР тооцоолохдоо 2016.4.26 өдрийн 152 тушаалын дагуу “Авто зам, гүүрийн арчлалт, засварын ажлын зардлын суурь норм” ЗЗБД 84-021-2016-г үндэс болгов.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

1998 оноос хойш зам, гүүрийн засвар, арчлалтад зарцуулсан хөрөнгийн хэмжээг тооцсон үндэслэл

№	Авто зам, гүүрийн нэр, төрөл	Хэмжих нэгж	Арчлалт, засвар (мян.төг)	Улсын чанартай зам, гүүрийн хэмжээ, хучлага, материалын төрлөөр	Нэг жилд зарцуулах арчлалт, урсгал засварын ажлын нормативт хэмжээ, сая₮	
1	Авто зам	Цементбетон хучилттай	1 км	7 246,6	28,5	206,5
		Асфальтбетон хучилттай*	1 км	9 235,5		
		Хайрган хучилттай	1 км	4 891,0		
		Сайжруулсан хөрсөн	1 км	3 666,2	77,3	283,4
2	Гүүр	Төмөрбетон	1 м2	41,6	108706,5	4 522,2
		Мод	1 м2	33,4	6529,2	218,1

ДҮН

*- асфальтбетон замын дүнд, хөнгөвчилсөн хар хучлагатай замыг оруулж тооцсон

Насжилтын итгэлцүүр

Авто зам, гүүрийн нэр, төрөл		Ашиглалтын хугацаа буюу насжилт (жил), итгэлцүүр			
		I үе-0.45	II үе-0.80	III үе-1.00	IV үе-1.15
Авто зам	Цементбетон хучилттай	1...10	11...20	21...35	36-аас дээш
	Асфальтбетон хучилттай	1...3	4...6	7*...9	10-ээс дээш
	Хайрган хучилттай	1...2	3...4*	5...6	7-оос дээш
Гүүр	Төмөрбетон	1...15	16...25	26...45	46-аас дээш
	Мод	1...3	4...6	7...12	13-аас дээш

Арчлалт засварын жилд зарцуулах хөрөнгийн хэмжээ тодорхойгүй, бүртгэлд тусгагдаагүй тул Зам гүүрийн зөвлөхүүдтэй харилцан ярилцаж, 1998-2017 онд зам гүүрийн засварын ажилд зарцуулсан бүртгэлийг үндэслэн тооцлоо.

Авто замын засвар, арчлалтын хөрөнгө оруулалтын хэмжээ

Δ/Δ	Онууд	Хөрөнгө оруулалтын хэмжээ, сая₮	Олдсон өөр мэдээлэл	Инфляци тооцсон итгэлцүүр	Хөрөнгө оруулалтын хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр, сая₮
1	1998	523,0		5,45	2 850,4
2	1999	760,0		4,81	3 655,6
3	2000	2 568,7		4,29	11 019,7
4	2001	2 032,0		4,07	8 270,2
5	2002	1 683,8		3,79	6 381,6
6	2003	1 459,0	2 432,4	3,39	4 946,0

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

7	2004	5 000,0		2,99	14 950,0
8	2005	6 000,0		2,74	16 440,0
9	2006	6 841,2		2,28	15 597,9
10	2007	7 520,5		1,71	12 860,1
11	2008	9 014,5		1,21	10 907,5
12	2009	9 202,3		1,13	10 398,6
13	2010	6 279,6		1,00	6 279,6
14	2011	9 824,7		1,00	9 824,7
15	2012	11 155,3	7 744,0	1,00	11 155,3
16	2013	15 743,2	13 273,4	1,00	15 743,2
17	2014	22 021,0	17 106,3	1,00	22 021,0
18	2015	18 000,0	15 309,7	1,00	18 000,0
19	2016	19 850,0	16.020.3	1,00	19 850,0
20	2017	10 000,0		1,00	10 000,0
ДҮН		165 478,8			231 151,4

Суурь өртөг дээр арчлалт засварын хөрөнгийн нийлбэр нь хөрөнгийн үнэлгээний жинхэнэ үнэ бөгөөд үүнээс элэгдлийг хассанаар дахин үнэлгээг тооцно.

ГУРАВ. АВТО ЗАМ, ГҮҮРИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИНД ОРЛУУЛАХ ӨРТГИЙН ХАНДЛАГЫН АРГААР ХИЙСЭН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

3.1. ЗАМ, ГҮҮРИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

Монгол улсад 2017 оны 10 дүгээр сарын 2-ны байдлаар ашиглалтанд байгаа **12624,86 км урт замын** бүртгэлд тусгах дахин үнэлгээний дүнг **4,265,018,737,091 /дөрвөн их наяд хоёр зуун жаран таван тэрбум арван найман сая долоон зуун гучин долоон мянган ерөн нэгэн/ төгрөг, 15,138,84 ү/м гүүрийн бүртгэлд тусгах дахин үнэлгээний дүнг 318,811,691,330 /гурван зуун арван найман тэрбум найман зуун арван нэгэн сая хоёр зуун ерөн нэгэн мянган гурван зуун гучин/ төгрөг байх бодит үндэслэлтэй гэж үзлээ.**

Дээрх зам, гүүрийн байгууламжийг төрөлжүүлэн ангилж бүлэглэн хавсралтаар гаргасан болно.

3.2. ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНГ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ТУСГАХ ТУХАЙ

Зам, замын байгууламж зэрэг үндсэн хөрөнгөнд дахин үнэлгээ хийхдээ НББОУС 16-д заасны дагуу болон нягтлан бодох бүртгэлийн бодлогыг судлан үзэж, хөрөнгийн ашиглалтын байдал болон тухайн хөрөнгийг цаашид хэрхэн ашиглах төлөвлөгөөтэй байгаа зэргийг харьцуулан ННБОУС-ын холбогдох шаардлын дагуу ангилах, тайлагнах, бүртгэлд тусгах шаардлагатай.

Дахин үнэлгээг улсын секторын санхүүгийн тайлагналын зориулалтаар хийсэн тул нэгдсэн бүртгэлд тусгахаас өөр зориулалтаар ашиглах боломжгүй.

Үнэлгээний тайланг нэг хувь, PDF-ээр дискэнд хадгалж хүргүүлэв, Үнэлгээий тайлан нь зөвхөн тамга тэмдэг дарж, гарын үсэг зурсан эх хувь болон нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар хүчинтэй. Үнэлгээнд хавсаргасан баримт бичгүүд нь үнэлгээний тайлангийн салшгүй бүрдэл хэсэг болно.

3.3. ҮНЭЛГЭЭНИЙ БАТАЛГАА

Замын байгууламжийн үнэлгээг бие даасан, хараат бус байдалд хийж гүйцэтгэв. Гүйцэтгэгч нь захиалагчийн ирээдүйн орлоготой ямар нэг холбоогүй, хөрөнгийн өртгийн үнэлгээний дүнд үнэлгээний ажлын хөлс ороогүй. Тайланд хавсаргасан эрх хязгаарлах нөхцөл, эрх зүйн баримтууд үнэлгээний тайлангийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болно. Үнэлгээний ажлыг 2017 оны есдүгээр сарын 25-ны өдрөөр дуусгавар болгон тайланг үйлдэв.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Монгол улсын олон улсын болон улсын чанартай авто зам, гүүрийн барилга байгууламжийн дахин үнэлгээ

Үндсэн хөрөнгийн нэр	Зам, гүүрийн тооллогын явцад хэмжилтээр гарсан урт	Анхны өртөг, сая.₮ /ЗТЯ-ны өгөгдөл/	Нэгж хүчин чадлын төсвийн жишиг үнэлгээгээр тооцсон нийт өртөг, сая төг-өөр	Үнийн өсөлтийн индекс тооцсон орлуулах өртөг, сая төг	Зам, гүүрийн ашиглалтын байдлын үнэлгээг харгалзан тогтоосон үнэлгээ, сая.₮	Тухайн зам, гүүрт насжилт харгалзан зарцуулсан хөрөнгийн хэмжээ, /1998-2016 онуудад/ сая₮	Ашиглалтын байдал, тухайн замд жил тугам зарцуулсан хөрөнгийн хэмжээ харгалзсан бүртгэлд авах бодит үнэлгээ
Асфальтбетон зам	6,270.74	2,489,834.71	878,250.12	3,713,587.10	3,653,344.76	171,856.35	3,825,201.11
Цементбетон зам	35.50	1,458.06	15,123.00	20,109.76	18,843.16	1,144.69	19,987.86
Хөнгөвчилсэн хучилттай зам	205.20	1,290.21	87,415.20	114,239.06	110,014.45	10,473.45	120,487.90
Хайрган зам	923.56	2,834.10	227,195.76	289,557.49	275,425.37	19,237.29	294,662.66
Сайжруулсан хөрсөн зам	221.90	876.33	1,287.02	1,635.84	1,459.21	3,219.99	4,679.20
Ердийн хөрсөн зам	4,967.96						0.00
	12,624.86	2,496,293.41	1,209,271.10	4,139,129.24	4,059,086.96	205,931.78	4,265,018.74
Ган гүүр	284.00	287.12	3,834.00	4,976.53	4,976.53	369.88	5,346.42
Төмөрбетон гүүр	13,768.84	15,558.99	165,093.39	261,434.53	244,981.88	14,329.94	259,311.82
Модон гүүр	1,086.00	9.01	3,572.94	4,638.76	3,714.42	50,439.03	54,153.45
	15,138.84	15,855.12	172,500.33	271,049.82	253,672.84	65,138.85	318,811.69
		2,512,148.53	1,381,771.43	4,410,179.07	4,312,759.79	271,070.63	4,583,830.43

3.4.ЗӨВЛӨМЖ

1. Өнөөдрийн байдлаар энэ салбарт мөрдөж буй нэгж хүчин чадлын норматив хэтэрхий хуучирсан, бодит байдалтай нийцэхгүй байгаа тул түүнийг шинэчлэх талаар ойрын ирээүүд тодорхой санал боловсруулж холбогдох газруудаар батлуулж мөрдөх;
2. Цаашид орлуулах өртгийн аргаар хийсэн дахин үнэлгээг зах зээлийн жишиг үнэлэх боломжийг судлах;
3. Бид зам засвар, арчлалтын зардлыг дахин үнэлгээнд нэмж тусгасан. Учир нь замын ашиглалтыг сайжруулах зорилгоор мөрдөж буй норм нормативын хүрээнд улсын төсөвт суулгадаг зайлшгүй гарах зардал гэж үзсэн.
4. Зам ашиглалтын хураамжийг нэмэгдүүлэх
5. Цаашид орон нутгийн замыг дахин үнэлж нэгдсэн бүртгэлд авах шаардлагатай гэж үзлээ.

Үнэлгээний тайлан бичсэн:

МЭРГЭШСЭН, ТЭРГҮҮЛЭХ ҮНЭЛГЭЭЧИН Ц. БААТАР

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛААРХ НИЙЦЭЛТИЙН МЭДЭГДЭЛ

1.1 Мэргэшсэн үнэлгээчид бид энэхүү үнэлгээг хийхдээ ОУҮС-ийн “Дүрэм”-ийн дагуу мэргэжлийн болон ёс зүйн шаардлагуудыг мөрдсөн гэдгээ баталж байна.

- *Тайланд тусгагдсан баримт мэдээлэл нь үнэлгээчний мэдэж байгаагаар үнэн зөв;*
- *Шинжилгээ ба дүгнэлт нь тайлагнасан таамаглал, нөхцөл байдлаар хязгаарлагдсан;*
- *Үнэлгээчин нь захиалагчтай ашиг сонирхлын болон өөр ямар нэгэн холбоогүй;*
- *Үнэлгээний ажлын хөлс тайлангийн аль нэг хэсгээс хамааралгүй;*
- *Үнэлгээчин мэргэжлийн боловсролын шаардлагыг хангасан;*
- *Үнэлгээчин үнэлж буй хөрөнгийн төрөл, зүйлийн талаар туршлагатай;*
- *Тайланд тусгайлан дурьдсанаас бусад ямар ч этгээд тухайн тайланг бэлтгэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлээгүй болохыг баталж байна.*

1.2. *Үнэлгээг Олон Улсын Үнэлгээний Стандарт, Монгол улсын холбогдох хуулиуд, Засгийн газрын тогтоол, салбарын яамдын журам зэргийг удирдлага болгон үйлчлүүлэгчийн танилцуулсан албан ёсны баримт бичиг, бусад материалуудад тулгуурлан хийлээ.*

1.3. *Энэхүү тайланд тусгагдсан үнэлгээний аливаа тооцооллууд нь зөвхөн энэ үнэлгээнд хамрагдаж, түүний салшгүй хэсэг байхын зэрэгцээ тэдгээрийг тайлангийн агуулгаас гадуур ашиглаж үл болно. Энэ үнэлгээний ажил нь зөвхөн энэхүү тайлангийн зориулалтын хувьд хүчинтэй болно.*


1.4. *Тайланд үнэлгээний өдрөөрх захиалагчийн ирүүлсэн материалуудыг ашигласан бөгөөд энэ өдрөөс хойш бий болох өөрчлөлт, аливаа нөхцөл байдал нь үнэлгээний үр дүнд нөлөөлөхгүй болно.*

1.5. Эрх зүйн актуудыг өөрчлөх, хөрөнгийн талаархи мэдээллийг хуурамчаар бүрдүүлэх зэргээс үүсэх хариуцлагыг захиалагч хүлээнэ.

НЭМЭЛТ. ШОРООН ЗАМЫН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Монгол оронд 1929 онд Монголтранс байгууллага бий болж орчин үеийн тээврийн хөгжлийн үндэс суурь тавигдсан бөгөөд 1960 он хүртэл ашиглагдаж байсан тээврийн хэрэгслүүд нь анхны зам мөр гаргаж байсан бол 1960-аад оноос хойш тээврийн хэрэгслийн хурд, даац, тоо нэмэгдэж олон зэрэгцээ зам бий болгож эхэлсэн байна. Энэ үеэс ЗИЛ-130, ГАЗ-53, УАЗ-469 маркийн хурд ихтэй, туулах чадвар сайтай авто машинууд өргөн ашиглагдаж эхэлсэн. 1980-аад оноос автомашины шороон зам хөрс эвдэж, бэлчээр сүйтгэж байгаа талаар ярьж эхэлсэн ч хөрс эвдэж байгаад илүү ач холбогдол өгч байснаас, тоосны гамшгийн талаар төдийлэн авч үздэггүй байсан. Хүмүүс ч олон зэрэгцээ замд шүүмжлэлтэй хандаж, тэр ч байтугай “энэ олон замын хаагуур явах вэ?” хэмээн дууддаг болсон. Тиймээс ч олон зэрэгцээ замуудыг цэгцэлж, нэг замаар явуулах зорилгоор грейдрийн зам, сайжруулсан шороон зам, хайрган зам барьж эхэлсэн. Гэвч энэ нь замын тоос багасгахад төдийлэн нөлөөлж чадаагүй. 1960-аад онд бэлчээрийн 20 орчим хувь ямар нэг хэмжээгээр доройтсон байсан бол одоо 80 хувь болж өссөнийг судлаачид анхааруулж байна.


Монгол Улсын хөгжил дэвшилд авто замын салбар чухал үүрэг гүйцэтгэдэг. Ялангуяа уул уурхай, аялал жуулчлалын хөгжлийг авто замын сүлжээний хөгжил түргэсгэдэг.




Зураг 1. Монгол улсын авто замын сүлжээ, улсын чанартай замууд

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ. Монгол орны нийт нутаг дэвсгэрийн дунджаар сүүлийн 75 жилд газрын гадарга орчмын агаарын жилийн дундаж температур 2.1°C дулаарч, жилд орох хур тунадасны хэмжээ 7% орчим буурсан байна. Эндээс манай оронд гандах, хуурайших процесс эрчимтэйгээр явагдаж хуурайшлын индекс буурах хандлагатай байна.




Зураг 2. Монгол орны жилийн дундаж агаарын температурын өөрчлөлт, $^{\circ}\text{C}$ 1940-2014 он



Зураг 3. Монгол орны жилийн нийлбэр хур тунадасны өөрчлөлт

Эх үүсвэр. Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2013-2014 он

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



Зураг 4. Монгол орны хуурайшлын индексийн жилийн явц, мм 1940-2014 он


Дээрх өөрчлөлтийн хэмжээ газар зүйн тархалтаас хамаарч харилцан адилгүй байна. Тухайлбал агаарын температурын өөрчлөлтийн хэмжээ $1-3^{\circ}\text{C}$ хэлбэлзэж харьцангуй эрчимтэй дулааралт манай орны төв болон баруун бүс нутагт ажиглагджээ. Дулааралт уулархаг нутгаараа арай эрчимтэй, говь, тал хээрийн бүсэд бага хэмжээгээр дулаарсан байна. Сүүлийн 74 жилийн дотор хамгийн дулаан 10 жил нь 1997 оноос хойш тохиолджээ.

Жилийн нийлбэр хур тунадасны хэмжээ Алтайн цаад говь болон нутгийн зүүн өмнөд хэсгээр бага зэрэг нэмэгдсэн, бусад бүх нутгаар буурсан хандлагатай байна. Дээрх өөрчлөлт дэлхийн бусад газар нутагтай харьцуулахад харьцангуй эрчимтэй гэж үзэхээр байгаа бөгөөд энэхүү уур амьсгалын өөрчлөлтөөс манай орны байгалийн болоод, нийгэм-эдийн засгийн салбаруудад учрах нөлөөлөл, эрсдэл харьцангуй өндөр байх төлөвтэй.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ ӨНӨӨ БОЛОН ИРЭЭДҮЙН ХАНДЛАГА. УЦОСМХ-ийн гаргасан тайлангаас үзэхэд Сүүлийн 45 жилд хүйтэн өдрийн тоо дунджаар 15 хоногоор буурсан, халуун өдөр 24 хоногоор нэмэгдсэн, ургамал ургах хугацаа 19 хоногоор уртассан, сарын хамгийн их температур $2,6^{\circ}\text{C}$, хамгийн бага температур $0,3^{\circ}\text{C}$ -ээр нэмэгдэж, дараалсан хуурхай өдрүүдэд хамгийн их хоногийн тоо буюу халууны үргэлжлэх индикатор 13 хоногоор нэмэгдсэн. [1] Энэхүү өөрчлөлтийн хандлага цаашид улам эрчимжиж хүйтэн өдөр энэ зууны эцэст 40-57 хоногоор буурч, халуун өдрийн тоо 36-40 хоногоор нэмэгдэж, ургамал ургах хугацаа 34-38 хоногоор уртасч, агаарын хамгийн их температур $4,4-4,7^{\circ}\text{C}$ хамгийн бага температур $5,1-6,6^{\circ}\text{C}$ ээр тус тус нэмэгдэх, халууны үргэлжлэх хугацаа 54-130 хоногоор нэмэгдэхээр байна.


Монгол орны ирээдүйн уур амьсгалыг хүлэмжийн хийн ялгарлын 3 төсөөллөөр дэлхийн агаар мандлын цацрагийн тэнцэлд 2100 оны түвшинд цацрагийн ачааллыг 2.6, 4.5, 8.5 вт/м²-аар (харгалзан RCP2.6, RCP4.5, RCP8.5 гэх) нэмэгдүүлэх 3 үндсэн хувилбараар тооцоолов. Энэхүү үр дүнгээр өвлийн улирлын температурын хандлагын эрчим ялимгүй их байх бөгөөд жил хоорондын өөрчлөлтийн хэлбэлзэл зуны улирлынхыг бодвол арай их байна

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



Зураг а) өвөл б) зуны улирлын температурын өөрчлөлтийн хандлага

Өөрчлөлтийн тоон утгын эрчимшил энэ зууны эхний хагаст хүлэмжийн хийн ялгарлын бүх хувилбарт бараг ижил, харин түүнээс хойш он цаг өнгөрөх тутам хоорондоо эрс ялгаатай үр дүнг өгч байна. Энэ зууны эхэн 2016-2035 оны үед хүлэмжийн хийн ялгарлын хувилбар бүрд өвлийн улирлын температур дунджаар 2.3 градусаар нэмэгдэхээр байхад зууны төгсгөлд 2081-2100 оны үед RCP2.6-ийн хувьд 2.5 градус, RCP4.5-ийн хувьд 3.7 градус, RCP8.5-ийн хувьд 6.7 градусаар тус тус нэмэгдэх төлөвтэй. Хур тунадасны хувьд өвлийн улиралд нэмэгдэхээр, харин зуны улиралд бараг өөрчлөлтгүй байна.



Зураг 10. а) өвөл б) зуны улирлын хур тунадасны өөрчлөлтийн хандлага

Энэ зууны төгсгөлд өвлийн хур тунадас 2081-2100 оны үед RCP2.6-ийн хувьд 15.5%, RCP4.5 нь 28.7%, RCP8.5-ийн хувьд 50.5%-иар тус тус нэмэгдэх хандлагатай.


ХҮЛЭМЖИЙН ХИЙ МОНИТОРИНГ. 1992 оноос АНУ-ын Далай Агаар мандал судлалын үндэсний төв /NOAA/ ийн дэлхийн мониторингийн лаборатори /GMD/, Ус цаг уурын хүрээлэнтэй хамтран хүлэмжийн хийн мониторингийн хэмжилт судалгааг Дорноговь аймгийн Эрдэнэ сумын нутагт Улаан-Уул (UUM) станц (Хойд өргөргийн 44.4516°, зүүн уртрагийн 111.0956°, далайн түвшнээс дээш 1007.00м) дээр тасралтгүй хийж байна. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их нөлөө үзүүлж буй нүүрсхүчлийн хий, метаны агаар дахь агууламжийн өөрчлөлтийн хэмжээг авч үзвэл нүүрсхүчлийн хийн /CO₂/ агууламж 23 жилд (1992-2014) 356.6 ppm-ээс 399.5 ppm болж 42.8 ppm буюу 12%-иар нэмэгджээ /Зураг 11/. 2013-2014 оны өөрчлөлтийн утга нь 1.6 ppm, агаар дахь намгийн хийн агууламж 1830 ppbv-ээс 1904 ppbv болж 4%-иар нэмэгдсэн байна.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



Зураг. Агаар дахь нүүрс хүчлийн хийн агууламж, ppm

АГААР МАНДЛЫН АЮУЛТАЙ ҮЗЭГДЭЛ. Манай оронд ч мөн байгалийн гамшигт үзэгдэл, үүний дотор ус-цаг уурын аюултай үзэгдэл, гамшигт үзэгдлийн давтагдал ихсэж байгааг үзүүлэв.



Зураг 12. Монгол оронд жилд ажиглагдсан аюултай болон гамшигт үзэгдлийн давтамж

УЦУОХ, ОБЕГ-ын хамтран хийсэн сүүлийн 20 жилийн судалгаагаар жилд дунджаар ус, цаг уурын аюултай болон гамшигт үзэгдлийн давтагдал 1995-2004 онд 46 байсан бол 2005-2014 онд 71 болж нэмэгджээ. Монгол улсад ус, цаг уурын аюултай болон гамшигт үзэгдэл 2013-2014 онд 85-123 удаа ажиглагдсан нь сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 14-52-оор нэмэгдэв.

Монгол улсад тохиолдож байгаа аюултай болон гамшигт үзэгдлүүдээс хүчтэй салхи шуурга 24%, ширүүн аадар бороо 21%, уруйн үер болон аянга цахилгааны үзэгдэл 13%-г эзэлж байна.

Монгол оронд зуны хүчтэй халалтын улмаас үүсэж ажиглагдах аадар бороо, уруйн үер, нөөлөг салхи, мөндөр, аянга цахилгааны гамшигт үзэгдлийн давтагдал эрчимтэй өсөж, нийт агаар мандлын гаралтай аюултай болон гамшигт үзэгдлийн 53.3%-г эзлэдэг бөгөөд үүний 41.1%-ийг аадар бороо, уруйн үер эзэлж байна.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

2013 оны 7 дугаар сарын 4-ний орой Сэлэнгэ аймгийн Түшиг суманд аадар бороо, том мөндөр, нөөлөг салхи тохиолдсон бол, 2014 оны 7 дугаар сарын 26-нд Архангай аймгийн Хашаат сумын Номгон багийн нутагт өргөнөөрөө 300-400 метр, уртаараа 10 км орчим нутгийг хамарсан догшин хуй салхи (торнадо), ширүүн аадар бороо, 6 см орчим голчтой том мөндөр орсон /Зураг 13/. Ийм догшин хуй салхи өмнө нь 1974 оны 7 сарын 16-нд Хэнтий аймгийн Батширээт сумын Хурх бригадэд ажиглагдаж байжээ.

2014 оны 7 дугаар сард Архангай аймгийн Хашаат сумын Номгон багийн нутагт болсон хар салхины улмаас 1 хүн нас барж, 9 хүн гэмтэж, 198 мал үхэж, 5 байшин, 3 машин эвдэрсэн, нийт 413 сая 523 мянган төгрөгийн хохирол тус тус учирчээ.




Зураг 13. Архангай аймгийн Хашаат сумын Номгон багт болсон хар салхинд хийсэж шидэгдсэн мал, машин, нурсан байшин

Сүүлийн 12 жилд ус цаг уурын гаралтай гамшигт үзэгдлийн улмаас 424 хүний амь эрсдэж, 24.5 сая мал хорогдож, 564 тэрбум 191 сая 420 мянган төгрөгийн хохирол учирсан бөгөөд амь насаа алдсан хүний 41.2% нь хүчтэй салхи шуурганы улмаас, 22.4% нь ширүүн аадар бороо, уруйн үерээс болж энджээ.

ШОРООН ШУУРГА, ТООС ТООСОНЦОР. Шороон шуурганы давтагдал 1960 оноос хойших ерөнхий хандлагаараа 2014 оны байдлаар бараг 3 дахин ихэсжээ. Харин 2013-2014 онд шороон шуурганы давтагдал бага зэрэг буурсан нь зундаа хур бороо ахиу орж, ургамал сайн ургаж зуншлага сайн болж газрын хөрс ургамлаар сайтар хучигдсан, өвөл нь цас ахиу орсноос хавартаа хөрс харьцангуй чийгтэй байсан, түүнчлэн хүчтэй салхи үүсэх агаар мандлын хүчин зүйлийн нөлөө харьцангуй бага байсантай холбоотой юм /Зураг 14/.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



Зураг 14. Монгол оронд ажиглагдсан шороон шуургатай өдрийн тоо

Хэдийгээр шороон шуурганы давтагдал 2013-2014 онд буурсан ч 2013 оны 3 дугаар сарын 8, 2014 оны 3 дугаар сарын 15-16, 4 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд манай орны говийн бүс нутагт хүчтэй шороон шуурга шуурч, малчид болон аж ахуйн салбаруудын үйл ажиллагаанд саад бэрхшээл учруулсан. Тухайлбал, тоосны багажийн хэмжилтээр 2013 оны 3 дугаар сарын 8-ны өдөр нэг шоо метр агаар дахь тоосны агууламж Өмнөговийн Даланзадгад орчимд 1530 микрограмм, Номгон сум орчимд 3633 микрограмм, Дорноговийн Эрдэнэ сумын орчимд 1912 микрограмм, Замын-Үүд орчимд 507 микрограмм хүрсэн нь ердийн үеийнхээс 10-70 дахин ихэссэн төдийгүй Дорноговийн Замын-Үүдэд байрлуулсан лидарын хэмжилтээр тоос газрын гадаргаас дээш 2.5 км өндөрт тархаж, агаарын урсгалаар зүүн, зүүн өмнө зүгт шилжин зүүн хойд Азийн бүс нутгийг хамарсан байна

УСНЫ ҮЕР, ХОХИРОЛ. Монгол орны эрс тэс уур амьсгалын нөхцөлд татруу устай жилийн давтагдал уур амьсгалын өөрчлөлт тод илэрч буй сүүлийн жилд нэлээд их байна. 2013 онд хур борооны үер олонтоо тохиолдож, нийгэм, эдийн засагт ихээхэн хохирол учирчээ.

Усны үер 2013 онд 18 аймгийн 51 сум, нийслэлийн 4 дүүрэгт нийт 104 удаа тохиолдож, 120 хүн эрсдэжээ. Мөс цөмрөх аюул 8 удаа тохиолдож, 4 хүний амь эрсдэж, усны аюулаас нийтдээ улс, нийгэмд 14.7 сая төгрөгийн хохирол учирсан байна. Энэхүү хохирлын хэмжээ өмнөх жилийнхээс (9.2 тэрбум төг) хэдэн арав дахин багассан байна. Харин Усны үер 2014 онд 18 аймгийн 52 сум, нийслэлийн 4 дүүрэгт нийт 89 удаа тохиолдож, 100 хүн (хүүхэд-14, насанд хүрэгсэд-86) эрсдэжээ. Мөс цөмөрсний улмаас 4-38 насны 3 иргэн амь насаа алдсан байна. Усны ослын дуудлагаар 1129 хүн, 239 техник хэрэгсэл ажиллаж 11 сая 74 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэхүү хохирлын хэмжээ өмнөх жилийнхээс 3,626,000 төгрөгөөр багассан нь элбэгдүү устай энэ жилд усны аюулаас урьдчилан сэргийлэх мэдээг олон нийтэд хүргэсний ач холбогдол оршиж байгааг харуулж байна. Шар усны үер жижиг голуудад 4 дүгээр сарын сүүлээр дуусаж, томоохон голуудад сул хүчтэй ажиглагдав. Энэ нь эрт аажим дулаарч, хаврын улирал удаан үргэлжилсэнтэй холбоотой юм. Хаврын шар усны үер эрч хүч багатай ажиглагдах нөхцөл бүрдэж байна.

ЦӨЛЖИЛТ, ГАЗРЫН ДОРОЙТЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛ. 2010 оны цөлжилтийн нэгдсэн зургаас харвал Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 77.8 хувь нь их, бага хэмжээгээр цөлжилт, газрын доройтлын үйл явцад өртсөн бөгөөд үүнээс 35.3 хувь нь сул, 25.9 хувь нь дунд, 6.7 хувь нь хүчтэй, 9.9 хувь нь

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

нэн хүчтэй зэрэглэлд хамрагдаж байна. Эдгээрээс нэн хүчтэй цөлжилтийн зэрэглэлд багтах газарт Ховд аймгийн Мянгад, Дөргөн, Увс аймгийн Өмнөговь, Завхан аймгийн Сантмаргац, Говь-Алтай аймгийн Халиун, Баянхонгор аймгийн Галуут, Эрдэнэцогт, Төв аймгийн Баяндэлгэр, Хэнтий аймгийн Дархан, Баянхутаг, Дорнод аймгийн Матад, Чулуунхороот, Гурванзагал, Халхгол, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Сүхбаатар, Түвшинширээ, Дорноговь аймгийн Хатанбулаг, Замын Үүд, Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций, Манлай, Дундговь аймгийн Говь-Угтаал, Баянжаргалан, Гурвансайхан, Өндөршил, Говь-Сүмбэр аймгийн Сүмбэр сумдын ихэнх нутаг хамрагдаж байна.

Цөлжилтийн нэн хүчтэй зэрэглэл бүхий газруудын ойр орчим нутгууд болон Өмнөговь аймгийн Номгон, Мандал-Овоо, Цогт-Овоо, Өвөрхангай аймгийн Баруун-Баян-Улаан, Бүрд, Баянхонгор аймгийн Баян-Овоо, Бөмбөгөр, Богд, Говь-Алтай аймгийн Төгрөг сумдын нутаг цөлжилтийн хүчтэй зэрэглэлд багтана. Харин цөлжилтийн сул, дунд зэрэглэлтэй нутгуудад цөлжилтийн нэн хүчтэй, хүчтэй зэрэглэл бүхий газруудын ойр орчим нутгууд багтаж байна.


2010 оны цөлжилтийн нэгдсэн зургийг өмнөх 2006 оны зурагтай харьцуулж үзвэл цөлжилтийн нэн хүчтэй, хүчтэй зэрэглэл бүхий газруудын тархац нутаг нэлээд өөрчлөгдсөн буюу ялангуяа нэн хүчтэй зэрэглэл бүхий газрууд шинээр голомтлон үүссэн нь элбэг байна. Тухайлбал, Баянхонгор аймгийн хойд хэсэг, Орхон голын сав дагуу болон Дорнодын тал нутагт энэ байдал тод ажиглагдана. Харин Их Нууруудын хотгорын төв хэсэг, Өвөрхангай, Дундговь аймгийн хил залгаа нутагт өмнөх цөлжилтийн нэн хүчтэй зэрэглэл буурч тархац нутаг нь багассан байна.

ЦӨЛЖИЛТ, ГАЗРЫН ДОРОЙТОЛД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛ. Цөлжилтийн үйл явц нь орон зай, цаг хугацааны туршид хувьсан өөрчлөгдөх янз бүрийн хүчин зүйлээр тодорхойлогддог. Энд хүн амын өсөлт, нийгэм-эдийн засгийн, улс төрийн, олон улсын худалдааны зэрэг дам хүчин зүйлс болон газар ашиглалтын хэлбэр, уур амьсгалын өөрчлөлт зэрэг шууд хүчин зүйлс багтана. Орчин үед цөлжилтийн асуудал нь байгалийн хязгаарлагдмал нөөцийг зохисгүй ашиглахаас үүдэлтэй гэж хэлж болно. Харин үүссэн нөхцөл байдал уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр улам даамжирах хандлагатай болдог.

Цөлжилтийн нэгдсэн зурагт тооцсон үзүүлэлтүүдээс уг үйл явцад давамгайлсан нөлөөлөх хүчин зүйлийн зургийг зохиож үнэлэхэд, газар нутгийн хэмжээнд цөлжилт илрээгүй буюу хүчин зүйлийн нөлөөгүй 10.4 %, хүний хүчин зүйл давамгайлсан 1.9 %, байгалийн бүлэг хүчин зүйл нөлөөлсөн 16.0 % уур амьсгалын нөлөө 13.8 %, салхины элэгдэл давамгайлсан 20.8 %, усны элэгдэл эвдрэл давамгайлсан 0.1 %, хүний нөлөө ба уур амьсгал хавсарсан 13.1 %, салхи ба хүний нөлөө хавсарсан 23.9 хувийг эзэлж байна. Үүнийг нэгтгэж харвал цөлжилт илрээгүй буюу хүчин зүйлийн нөлөөгүй 10.4 %, хүний хүчин зүйл давамгайлсан буюу хавсарсан 39 %, байгалийн хүчин зүйл давамгайлсан буюу хавсарсан 50.6 % болж байна. Энэ нь цөлжилт хүчтэй, нэн хүчтэй илэрсэн тухайн газар нутагт байгалийн хүчин зүйл 56 %, хүний үйл ажиллагааны нөлөө 44 хувийг эзэлж байна гэсэн үг юм.

Нутаг дэвсгэрийн хувьд говийн бүс нутагт байгалийн хүчин зүйлс, зүүн бүсэд хүний нөлөө болон байгалийн хүчин зүйлс хавсарсан, хангайн бүсэд хүний нөлөө давамгайлсан, Монгол Алтай, Их нууруудын хотгорт уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө илүү нөлөөтэй байна.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



АВТОЗАМААС ҮҮСЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ АРГА ЗАМ

АГААРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ. Орон нутгийн замуудын нэлээд хэсэг нь хөрсөн зам байдаг бөгөөд ялангуяа стратегийн онцгой бүс болсон говийн аймгуудад алсын барааны хардац муутай, чийгшил багатай эмзэг хөрстэй зонхилох олон салаа замаар зорчих хүнд даачын машинаас агаар дахь тоосонцорын хэмжээ жилээс жилд ихсэж хүний амь нас, эд материалын ихээхэн хохирол амссаар байна. Өмнөговь аймгийн Цогтцэцийгээс Хятад руу зөөж байгаа нүүрсний замын тоосыг Эрдэнэс таван толгой компанийн 2017 оны 4 сарын байдлаар ачаа эргэлтээс үүсэх тоосонцрын хэмжээг судалж үзлээ.

Дэлхийн агаарын бохирдлын форум (GAF) ын аргачлалаар уурхайгаас өдөрт 6000 хүнд даачын машин 250 км–т тээвэр хийдэг үзээд тооцоо хийлээ. Говийн бүс нь чийгшил маш бага байдаг учраас цаг агаар хуурай байх нөхцөлд зөвхөн 1 өдрийн тээвэрлэлтийн үед 250 км замын 10 км нь (4 хувь) шороон зам байгаа тохиолдолд машины түлшний шаталтаас 3.4 тонн, шороон замаас 103 тонн PM₁₀ буюу тоосонцор агаарт дэгдэх боломжтой байна. Хэрэв энэ 250 км зам 100 хувь шороон зам байсан бол өдөрт замаас 2,592 тонн тоос агаарт дэгдэх боломжтой байна.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Хүснэгт

Уурхайн хүнд даацын машинууд 250 кмт тээвэр хийхэд агаарт ялгарах тоосонцор

Машины тоо	(км/өдөр)	Нийт машины явсан зам км /өдөрт	Түлшний зарцуулалт /100км/литр	Түлшний нийт зарцуулалт (тонн)	Шороон замын эзлэх хувь	Түлшний шаталтаас ялгарах PM ₁₀ (тонн)	Шороон замаас дэгдэх PM ₁₀ (тонн)
6000	250	1,500,000	40	3,075	4	3.375	103.68
6000	250	1,500,000	40	3,075	100	3.4	2,592

УРГАМАЛЖИЛТАД ҮЗҮҮЛЭХ АВТО ЗАМЫН НӨЛӨӨ. Оросууд 1970-аад оны сүүлчээс эхлэн замын тоосны гамшгийн талаар ярьж, судалж, дүгнэлт гарган арга хэмжээ авч эхэлсэн. Ялангуяа хар шороон хөрст бүс нутагт замын тоосноос шалтгаалан ургацын хэмжээ 35%-иар буурдгийг эрдэмтэд нь судалж тогтоосон байна. Иймээс ургацын талбай эргэдэг агрономуудыг борооны дараа юм уу, эсвэл замаа усалсны дараа явуулдаг хэвшил бий болж эхэлсэн байна.

Замын тоос таримал ургамалд нөлөөлөөд зогсохгүй, байгалийн унаган ургамлыг сүйтгэдэг. Сүүлийн жилүүдэд Монголын эрдэмтэд жинхэнэ монгол өвс устаж алга болж байгаа талаар ихээхэн бичиж байна. Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай аймгийн төв, сум суурин газруудад бий болсон маш нарийн ширхэгт хөх тоос ургамлыг сүйтгээд зогсохгүй, хүмүүсийн гутлыг түлдэг. Энэ нутгийн иргэд гутлаа тоосонд идэгдүүлэхгүйн тулд байнга амьтны гаралтай буюу бусад тос хэрэглэдэг. Эндээс боссон иймэрхүү хортой тоос салхины дагууд хичнээн ургамал сөнөөж байгааг хэлэхэд хэцүү. Сүүлийн хэдэн жил энэ бүс нутагт байнгын ган болж “хамар хатгах өвсгүй” болж байгаагийн нэг шалтгаан, төв рүү чиглэсэн их нүүдлийн нэг шалтаг нь энэхүү тоос юм.



Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Замын тоос үр ашигтай ургамлыг устгаж, хогийн ургамлыг тэтгэдэг. Ингэж хогийн ургамал ихэссэнээр бэлчээр хомсдож, түүний талхлалт улам нэмэгддэг.

Бөхөг, Түргэний гол, Айцын даваа, Авдар толгой, Яармагийн морь уралддаг бүсэд бараг өчүүхэн ч жинхэнэ монгол өвс байхгүй. Дандаа шарилж хамар цоргино, уяачид адууны идэх зүйл хомсдлоо гэж өгүүлцгээнэ. Харин 1993 оноос морь Хүй долоон худагт уралддаг болсноор дээрх нутаг түр амсхийсэн. Харин Хүй долоон худгийн морь барианы газар өнгөрсөн жил очиход мөн л шарилжинд идэгдсэн байсан юм. Энэ бол адууны, адуу дагасан машинуудын тоосноос үүдэлтэй гамшиг юм шүү дээ. Ихэнх ургамал тоос хүртэх замаар үржиж ургадаг юм байна. Энэ нь тоосонд дарагдахаас өөр ойлголт юм. Тоосонд дарагдсан ургамал ямар байдалтай байдгийг монгол хүн бүр мэднэ. “Ургамал тоосонд дарагдснаар фотосинтезийн процесс бараг зогч, ургамал устаж эхэлдэг. Тоос ургамлын нөмрөг, бүрхэцэд нөлөө үзүүлж, төрөл зүйлийг бууруулна” гэж ургамлын генетик судлаач эрдэмтэн ярьж байна.



Бүлэг 5

НИЙСЛЭЛИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ЧАНАРТАЙ АВТО ЗАМ, ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АВТО ЗАМЫН БҮРТГЭЛ

Авто замын тухай хуулийн 4.1.22.-т “Монгол Улсын үндэсний авто замын сүлжээ” гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дэх олон улс, улс, нийслэл, орон нутгийн чанартай болон тусгай зориулалтын авто замын сүлжээг;хэлнэ гэсэн байгаа.

Мөн хуулийн Төрөөс үндэсний авто замын сүлжээг хөгжүүлэхэд баримтлахад дараах зарчмыг баримтална гээд 5.1.1.үндэсний авто замын сүлжээг хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулан хөгжүүлэх; гэсэн байгаа.

Энэ ажлын хүрээнд Монгол улсын үндэсний авто замын сүлжээний суурь судалгаа хийгдсэн бөгөөд олон улс, улсын чанартай замын тооллого, бүртгэлийн ажлын иж бүрэн судалгаа хийгдсэн гэж Зөвлөхүүд дүгнэж байна.

Авто замын тухай хуулийн 12.1.1.-т үндэсний авто замын сүлжээг хөгжүүлэх төрийн бодлоготой уялдуулан нийслэл, орон нутгийн чанартай авто замын сүлжээг хөгжүүлэх бодлого, ерөнхий төлөвлөгөөг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах;гэсэн учраас нийслэлийн авто зам болон орон нутгийн чанартай замын бүртгэлийг даалгаврын дагуу энэ ажлын тайланд орууллаа.

Хэдийгээр хуулиар нийслэл болон орон нутгийн чанартай авто зам нь ЗТХЯ-нд хамааралгүй мэт боловч Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хувьд дээрх үзэл баримтлалд тулгуурлан үндэсний авто замын сүлжээний тоон бүртгэлийг тогтмол хөтөлж байх нь зөв гэж үзэж байна.

Монгол улсын хэмжээнд урьд нь хийгдсэн 2 удаагийн тооллогын дүнгээр Монгол улсын Авто замын сүлжээний уртыг 49250 км, үүнээс орон нутгийн чанартай замын уртыг /нийслэлийг оролцуулаад/ 37000 гаруй км гэж гарсан байгаа. Бид энэхүү 37000 гаруй км замын жагсаалтыг олж чадсангүй, орон нутгийн чанартай хөдөөгийн замын талаар судалгаа хийж эрдмийн зэрэг хамгаалсан хүнээс материал авах гэсэн боловч “миний оюуны өмч” гээд үзүүлсэнгүй.

Иймээс бид нийслэлийн болоод орон нутгийн чанартай замын жагсаалтыг шинээр хийж гаргалаа. Мөн тусгай зориулалтын авто замын бүртгэлийг гаргав.

Нийслэлийн авто замын хувьд Зөвлөхүүд нь 2015 онд НАЗГ-ын захиалгаар төсөл хэрэгжүүлсэн учраас, тэр мэдээлэлд тулгуурлан шинэчлэлт хийлээ.

Орон нутгийн чанартай замын хувьд үнэн зөв мэдээлэл олж авахад ихээхэн бэрхшээлтэй тулгарсан. Нэг засгийн газрын хугацаа дуусч, шинэ засгийн газар ээлжээ авч байсан учраас урд нь ажиллаж байсан олон хүмүүс өөрчлөгдөж Зам, тээврийн сайдын албан ёсоор гаргасан хүсэлтэд хариу бараг өгсөнгүй. Тэгээд ч аймгуудад орон нутгийн чанартай нарийвчилсан бүртгэл байдаггүй юм байна гэсэн дүгнэлтэд хүрсэн.

Зөвлөхүүд танил тал, найз нөхөд, шавь нараар дамжуулан олж авсан материалаас олж хараад л ийм дүгнэлтэд хүрсэн юм.

Энэ талаар тооллого бүртгэлийн ажилд орон нутгийн байгууллага оролцсон байдлын тухай бичсэн 2.2.3 дахь зүйлээс уншиж болно.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Орон нутгийн чанартай авто зам, гүүрийн тооллого, бүртгэлийг дараах байдлаар хийсэн.
Үүнд:

1. Аймгуудын замын сүлжээг гаргахдаа, орон нутгийн байгууллагуудаас ирүүлсэн материал, мэдээлэлд суурилах, ирүүлээгүй бол өөрт байгаа материалыг ашиглан шинээр хийж, холбогдох хүмүүсээс санал авах
2. Зам, тээврийн хөгжлийн яамнаас ирүүлсэн материалыг судалж, өгөгдлүүдийг шинэчлэх, мөн хувь хүмүүст байгаа материалыг судалж ашиглах
3. 2016 оны зуны хэмжилтэд хамрагдсан сумуудын материалыг ашиглах, бусад орон нутгийн чанартай замыг сүлжээний уртыг А. GARMIN-ийн санд байгаа чиглэл, зураглалыг ашиглах, Б. Google.maps-г ашиглах, В. Монголд түгээмэл хэрэглэж байгаа JPS-ийн зураглалыг харьцуулах хэлбэрээр ашиглах
4. Дээрх газрын зургуудын боломжит хамгийн бага масштабээр замын хэмжилт хийсэн. Хэмжилт хийсэн замын координатуудыг тодорхойлж тусгай файл болгон хадгалах, хэмжилт хийсэн замуудын трассын зургийг газрын зурагт оруулж зурахад бэлэн болгох
5. Газар, уул усны нэр болон суурин газрын нэрийг Монгол улсад ашиглаж байгаа 1:500 000, 1:100 000-ын болон бусад газрын зургуудаас авах
6. Орон нутгийн АЗЗА-нуудаас ирүүлсэн материалыг ашиглах, шаардлагатай үедтодруулга авах, тухайн аймгийн замыг сайн мэдэх хүмүүсийн жагсаалт гарган тэдгээр хүмүүстэй уулзаж тодруулга авсан
7. Орон нутгийн чанартай замын сүлжээнд орсон суурингуудын хоорондох зайн хэмжээг аймаг, сум бүрээр “гурвалжин” хүснэгтээр харуулах
8. Хэмжилт хийж байгаа зам, аймаг дамжиж байгаа бол, хилийн заагт хамааруулж уртыг хувааж тавих, ингэснээр тухайн аймгийн Авто замын сүлжээний урт гарах юм.

Дээрх зарчим, аргачлалаар Орон нутгийн чанартай замын уртыг гаргалаа.

2017 оны 8-р сарын 01-ний байдлаар Үндэсний авто замын сүлжээн дэх Нийслэлийн авто замын сүлжээ нь 727.3 км авто замтай, 3956,6 у/м, 67ш гүүртэй байна, орон нутгийн чанартай замын урт 95,370.0 км, 265 ш, 14,244,5 у/м гүүр байна. Орон нутгийн чанартай замын урт урдах тооллогын дүнгээс бараг 3 дахин нэмэгдлээ.

Орон нутгийн чанартай замд бид аймгаас сум орох зам, сумаас баг, бригад орох замууд, тухайн аймаг сумын дэвсгэр нутагт байгаа суурингууд, амралт сувилалын газрууд, уурхайнууд, эдгээр суурингуудын хоорондох замуудыг оруулав.

Гэхдээ эдгээр суурингууд өөрчлөгдөж байдаг учраас орхигдсон, шаардлагагүй цэгүүд байхыг үгүйсгэхгүй.

Орон нутгийн замын уртыг бүрэн оруулсан, дутуу оруулсан, буруу оруулсан гэхэд ихээхэн хэцүү, яагаад гэвэл тухайн 2 цэгийн хооронд албан ёсоор баталгаажсан зам, засмал зам байхгүй учраас ямар ч замаар явах болох боломжтой. Бид голыг нь барьс хийгээд хэмжилт хийсэн. Орон нутгийн чанартай авто замын дэлгэрэнгүй бүртгэлийг боть 4-өөс үзнэ үү.

Авто замын тухай хуулийн заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор аймгуудын орон нутгийн чанартай авто замын тооллого, бүртгэлийг нэн яаралтай хийж, албан ёсны нэгдсэн дүнг гаргах шаардлагатай байна.

Аймгуудын нутаг дэвсгэр байгаадээрх орон нутгийн чанартай зам, гүүрүүд чухам хэний өмчлөлд байгаа, ямар үнэ өртөгтэйгээр аймгийн хөрөнгийн бүртгэлд тусгагдсан талаар тодорхой мэдээлэл байхгүй байна. Энэ чиглэлийн бүртгэл байгаа эсэх нь ч эргэлзээтэй

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

байна. Сүүлийн жилүүдэд хувийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн чанартай замд, зам гүүр барих хандлага ихэсч байна.

Хувь хүмүүс, байгууллага өмчөө хэзээ ч алдахгүй, харин төрийн нийтийн өмч болсон улс, нийслэл, орон нутгийн чанартай зам, гүүрүүд ямар үнээр хэний бүртгэлд байгааг тодорхой болгохгүй бол өмч эзэнгүйдэж, хариуцах эзэнгүй болж, устаж үгүй болох аюул тулгарч байгааг зориуд анхааруулж байна.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН


Нийслэлийн чанартай авто замын сүлжээний бүтэц, бүрэлдэхүүн, товчоо

№	Үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт	Тоо хэмжээ	Улаанбаатар хотын замын ангилал, зэрэглэл					Улаанбаатар хотын авто замын нягтаршлын бүс									
			Гол зам I	Гол зам II	Туслах зам -I	Туслах зам -II	Дүн	А			В			С			
								тоо	урт, км	талбай (мян. м2)	тоо	урт, км	талбай (мян. м2)	тоо	урт, км	талбай (мян. м2)	
1	Насжилт	1-2 жилийн насжилттай /25 зам/ км	108.9	18.2	24.5	38.5	27.7	108.9	8	4.4	52.4	7	23.3	291.9	10	81.2	866.1
		3-5 жилийн насжилттай /82 зам/ км	196.4	37.6	20.7	64.0	74.1	196.4	19	14.4	185.65	47	98.3	1241.25	16	83.7	717.91
		6-8 жилийн насжилттай /45 зам/ км	66.4	16.6	8.7	10.7	30.4	66.4	15	16.5	261.8	19	27.1	326.5	11	22.8	194.9
		8-аас дээш жилийн насжилттай /70/ км	137.5	26.1	18.6	26.8	66.0	137.5	17	14.7	154.7	34	58.7	657.65	19	64.1	479.7
		Дүн /км/	509.2	98.5	72.5	140.0	198.2	509.2	59	50	654.6	107	207.4	2517.3	56	251.8	2258.6
2	Хучилт	Асфальтбетон /км/	480.4	80.3	67.0	140.0	193.1	480.4	49	49.1	632.35	88	196.5	2376.1	55	234.8	2122.6
		Цементбетон /км/	28.5	18.2	5.5	0	4.8	28.5	2	0.6	6.6	4	10.9	141.2	1	17	136
		Өрмөл чулуун /км/	0.3	0	0	0	0.3	0.3	1	0.3	15.6	0	0	0	0	0	0
		Дүн /км/	509.2	98.5	72.5	140.0	198.2	509.2	52	50.0	654.6	92	207.4	2517.3	56	251.8	2258.6
3	Гэрэл дохио	Замын гэрэлтүүлэг /ш/	4657	1686	1209	884	878	4657	1704			2669			284		
		Гэрлэн дохио /объектоор/	114	57	28	20	9	114	45			67			2		
4	Хашлага	Замын чулуун хашлагатай /км/	39.3	27.7		11.6	-	39.3		19.7			19.6			0	
		Бетонон хашлагатай /км/	889.35	155.10	135.40	250.67	348.17	889.35		79.726			381.142			408.88	
5		Явган замтай (мян. м2)	129.12	375.57	258.15	31.84	3.39	668.95			203.3			550.2			537.9
6		Хайрган хөвөөтэй (мян. м2)	0.8	0.17	0.10	0.2	0.3	0.8						0.226			0.593
7	Борооны усны шугам	Лоткитой /км/	60.77	28.24	13.23	12.47	6.83	60.77		30.621			30.15			0	
		Ил шуудуугаар /км/	25.64	21.40	-	2.39	1.85	25.64					25.594			0.05	
8	Тэмдэг, тэмдэглэгээ	ХАБ-ын тэмдэг, дохионы шон /ш/	6571	1773	918	821	3059	6571	1186			1935			3450		
		Хэвтээ тэмдэглэгээ (мян. м2)	88.9	25.1	18.9	38.6	6.2	88.9			11.4			26.311			51.117

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Орон нутгийн чанартай замын бүртгэлийн товчоо

No	АЙМГУУДЫН НЭР	ОРОН НУТГИЙН ЧАНАРТАЙ ЗАМЫН УРТ, км	Үүнээс							ГҮҮР	
			Хучлагатай				Хучлагагүй			тоо	у/м
			Асфальт бетон	Цемент бетон	Хайрган	БҮГД	С.хөрсөн	Е.хөрсөн	БҮГД		
1	Архангай	3543.3	15.2			15.2		3528.1	3528.1	21	2312.2
2	Баян-Өлгий	3583.7	25.0	0.6	9.0	34.6	38.0	3511.1	3549.1	45	1784.7
3	Баянхонгор	4888.6	14.0			14.0		4874.6	4874.6	18	437.7
4	Булган	4242.6	29.8		32	61.8		4180.8	4180.8	18	1109.4
5	Говь-Алтай	6993.3	27.0			27		6971.3	6971.3	1	10.0
6	Говьсүмбэр	364.5	8.0			8		356.5	356.5	0	0.0
7	Дархан-Уул	247.6	35.2			35.2		212.4	212.4	3	192.0
8	Дорноговь	8858.8	15.7			15.7		8843.1	8843.1	0	0.0
9	Дорнод	3367.6	32.1			32.1		3335.5	3335.5	13	830.8
10	Дундговь	4944.4	12.5			12.5		4931.9	4931.9	0	0.0
11	Завхан	3908.3	8.3			8.3		3900.0	3900.0	28	946.9
12	Орхон аймаг	140.1	91.12	2.36	13.43	106.9	27.50	8.00	35.5	3	96.0
13	Өвөрхангай	5228.2	26.97			26.97		5201.2	5201.2	9	323.0
14	Өмнөговь	5236.0	46.0			46		5190.0	5190.0	0	0.0
15	Сүхбаатар	4015.3	45.0		1.4	46.4		3968.9	3968.9	1	15.0
16	Сэлэнгэ	2998.5	39.4		207.4	246.8		2616	2616.0	21	1430.5
17	Төв	8500.4	102.3		21.1	123.4	200.0	8738.1	8938.1	29	1072.0
18	Увс	9086.2	32.787			32.79	50.2	9003.2	9053.4	14	1024.0
19	Ховд	6892.1	52.4			52.4		6839.7	6839.7	9	339.0
20	Хөвсгөл	3659.6	27.0			27.0		3264.0	3264.0	27	2039.0
21	Хэнтий	4671.0	14.5			14.5		4169.5	4169.5	20	1503.5
	Нийт дүн	95,370.0	700.3	3.0	284.3	987.6	315.7	93,643.9	93,959.6	280	15,465.7



Тусгай зориулалтын авто замын бүртгэл

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Д/д	Тусгай зориулалтын зам байгаа аймаг	Замын нэр	Урт /км/	Тусгай зориулалтын авто замын			
				Хучилтын төрөл	Ашиглалтад орсон он	6.0м-с дээш урттай гүүрийн нэр, байршил	Гүүрийн урт,
1	ХОВД	Хөшөөтийн уурхай-Ярантын боомт	305	асфальт	2010	Дэтийн гүүр	48
						Баянголын гүүр	27.04
						Их бэлчир гүүр	61.6
						Барлагийн хавцлын гүүр	63.64
						Барлагийн хавцлын гүүр	63.44
						Барлагийн хавцлын гүүр	45.84
						Барлагийн хавцлын гүүр	45.84
						Барлагийн хавцлын гүүр	64.24
						Барлагийн хавцлын гүүр	45.84
						Барлагийн хавцлын гүүр	29.64
						Барлагийн хавцлын гүүр	29.64
						Барлагийн хавцлын гүүр	29.64
						Барлагийн бригадын гүүр	17.44
						Бодончийн гүүр	93.6
Бамбагарын гүүр	17.44						
Үенчийн гүүр	54.8						
		Булган голын гүүр	46.04				
		ДҮН	305				
2	ГОВЬ-АЛТАЙ	Таяннуур-Бургастай боомт	101	хайрган			
		ДҮН	101				
3	ДУНДГОВЬ	Эрдэнэдалай-Говьсүмбэр	270	Хөрсөн зам			
		Даланжаргалан-Говьсүмбэр 45-р зэрлөг	60	Хөрсөн зам			
		ДҮН	330				
4	ӨМНӨГОВЬ	Нарийнсүхайд-Шивээхүрэн боомт	44.6	Асфальт			
		Дүн	44.6				
5	БАЯН-ӨЛГИЙ	Ногооннуур-Асгант	55	Хөрсөн зам	8 км хайрган, хөрсөн зам	Асгантын	60.0
						Асгантын	18.0
						Асгантын	72.9
		ДҮН	55				
6	ДОРНОД	Тосон уулын ордоос- Баянхошуу боомт	222	хөрсөн зам			
		ДҮН	222				
		ДҮН	1057.6				
БҮРТГЭЛИЙН ТОВЧОО							
Тусгай зориулалтын авто замын урт, км	1057.6	Зам, км	Хатуу	349.6	Гүүр	төмөр бетон	модон
			хайрган	101			
			С.хөрс				
			Ердийн хөрс	607.0			

БҮЛЭГ 6

ХЭЛЭЛЦҮҮЛЭГҮҮД

Тайлангийн хугацаанд нийт 3 удаа олныг хамарсан хэлэлцүүлэг, ярилцлага, уулзалт зохион байгуулсан.

Анхны хэлэлцүүлгийг 2016 оны 11-р сарын 10-нд яам, төвийн удирдлага, салбарын ТББ, зөвлөх инженерүүдийн хэмжээнд зохион байгуулсан. Энэ хэлэлцүүлгээр тооллого, бүртгэлийн ажлыг газар дээр нь явуулсан дүнг танилцуулж, энэ ажлын тухай ойлголтыг салбарынхандаа өгсөн. Хэлэлцүүлэгээр ажлын явцыг сайн байна. Богино хугацаанд давагдашгүй их ажил хийж байгаа юм байна гэсэн дүгнэлт өгсөн. Хэлэлцүүлэгийн материалыг хавсаргав.

2 дахь хэлэлцүүлэгийг 2017 оны 5-р сарын 18-ны өдөр ЗТХЯ-н дээр хийсэн. Энэ хэлэлцүүлэгт авто замын бүртгэл, мэдээллийн чиглэлээр ажиллаж байсан үе үеийн инженерүүд, ЗТХЯ, ЗТХТ-ийн холбогдох мэргэжилтнүүд, дарга нар, Зөвлөхийн багийнхан оролцсон. Хэлэлцүүлэгээр маш олон талаас нь ярилцаж байгаад Улсын чанартай замуудын шинээр нэмэгдэх чиглэлүүдийг тогтоосон. Хэлэлцүүлэгийн тэмдэглэл болон материалыг хавсаргав.

3 дахь хэлэлцүүлэгийг ЗТХЯ-ны холбогдох газар, хэлтсүүдийг хамруулан хэмжээнд нилээд өргөн бүрэлдэхүүнтэй хийсэн. Энэ хэлэлцүүлгээр ажлын явц, Зам, гүүрийн шинэчилсэн үнэлгээний тухай дэлгэрэнгүй танилцуулга хийсэн. Энэ танилцуулга хэлэлцүүлэгийн үеэр ЗТХЯ-ны хэмжээнд хийгдэж байгаа бусад төслүүдтэй ажлаа уялдуулах талын яриа өрнөж хаана хаанаа тодорхой ойлголттой болсон. Хэлэлцүүлэгийн тэмдэглэлийг хавсаргав.

Эдгээр хэлэлцүүлэгээс гадна хэд хэдэн уулзалтууд зохион байгуулсан. Тухайлбал, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Доржханд, албаны дарга Б.Минжбадам нартай 2017 оны 3-р сарын 28-ны өдөр Зөвлөхүүд уулзаж 2 асуудал танилцуулж чиглэл авсан, мөн Зөвлөх инженер Н.Адилбиш 2017 оны 9-р сарын 12-ны өдөр ЗТХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын, хөрөнгө оруулалт үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Ч.Ренчиндамба, ахлах мэргэжилтэн Г.Алтангэрэл нартай уулзаж, зам, гүүрийн бүртгэлд авах өртгийн асуудлаар ярилцаж, дахин үнэлгээ хийсэн аргачлалаа танилцуулав. Үүнээс гадна ЗТХЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын Стандарт нормативийн хэлтсийн дарга Ж.Сэрээтэр, ахлах мэргэжилтэн Д.Гэрэлням, АЗБХЗГ-ын албаны дарга Б.Минжбадам, хэлтсийн дарга Х.Оргил-Эрдэнэ, ахлах мэргэжилтэн Н.Сугаржав, мэргэжилтэн Ц.Хосгэрэл нартай хэд хэдэн удаа уулзаж ажил хэргийн ярилцлага хийж байсан.

6.1 Бусад хэрэгжиж байгаа төслүүдтэй хэрхэн уялдсан талаар

ЗТХЯ-ны хэмжээнд Авто замын бүртгэл мэдээллийн сантай ямар нэгэн байдлаар холбоо бүхий өөр 2 төсөл хэрэгжээд дуусч байгаа юм билээ.

Бид энэ ажлынхаа талаар ярихаар бусад 2 төсөлтэйгээ хэрхэн уялдаж байгаа тухай яриа гардаг. Бидний хийж байгаа ажил цаг хугацааны хувьд сүүлчийнх нь болж таарч байгаа юм. Тийм учраас уялдааны тухай яриа гардаг байх.

“Авто замын сүлжээний орон зайн мэдээллийн сан бий болгож, Авто замын сүлжээний карт гаргах”, “Авто замын сүлжээний орон зайн мэдээллийн санд суурилсан вэб аппликейшн бий

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

болгох, хөгжүүлэх” гэсэн 2 төсөл хэрэгжиж байгаа. ЗТХЯ-ны зүгээс ийм ажил хийж байгаа нь сайшаалтай боловч, дэс дарааллын хувьд бидний хийж байгаа энэ ажил түрүүнд нь хийгдэх байсан юм.

Авто замын сүлжээнд тооллого, бүртгэл хийж үндсэн өгөгдлийн суурь бий болгож, сүлжээний талаар үнэн зөв мэдээллийн сантай болсны дараа дээрх 2 ажил хийгдсэн бол илүү үр дүнтэй болох байсан.

Авто замын сүлжээний талаарх яаманд байсан мэдээлэл нь нэгдсэн тооллого, бүртгэлийн ажлыг олон жил хийгээгүйгээс шалтгаалан нилээд хуучирсан, учир дутагдалтай байсан, тийм мэдээлэлд үндэслэж Орон зайн мэдээллийн сан үүсгэж, энэ санг үндэслэн вэб аппликейшнбий болгож байгааг бид ойлгохгүй байгаа юм.

Вэб аппликейшн нилээд зөв арга барилаар хийгдэж байналээ. Харин түүнд энэ ажлын өгөгдлүүдийг оруулах хэрэгтэй. Ингэж байж вэб аппликейшн үнэн зөв мэдээлэл өгөх болно.

Уялдаа холбоо гэвэл ерөнхийдээ энэ.

6.1 2016 оны 11-р сарын 10-ны Уулзалт танилцуулга

“АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ТООЛЛОГО, БҮРТГЭЛ ХИЙЖ, ПАСПОРТ, КАРТ ХӨТЛӨН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛД АВАХ СУДАЛГАА, БОЛОВСРУУЛАЛТ”-ЫН АЖЛЫН ТАНИЛЦУУЛГЫН ТЭМДЭГЛЭЛ

Танилцуулга 2016 оны 11-р дүгээр сарын 10-ны өдөр (Пүрэв гараг)-ийн 10:00 цагт Рокмон төвийн хурлын танхимд эхлэв.

Танилцуулгад Зам, тээврийн хөгжлийн яамнаас-10 хүн, Зам, тээврийн хөгжлийн төвийн-6 хүн, зөвлөх компаниудын төлөөлөл-20, нийт 36 хүн оролцлоо.

Танилцуулгыг Зөвлөх инженер Д.Баасанхүү, Зөвлөх инженер Н.Адилбиш, Зөвлөх инженер Р. Балжир нар хийлээ.

Энэ ажлын зорилго, хүрэх үр дүн:

Монгол улсын иргэн бүрийн нийтийн зориулалттай өмч болох Улс, орон нутгийн чанартай Авто зам, замын байгууламжийн тооллого хийж, одоо байгаа бүртгэлийг шинэчлэх, Монгол улс ямар хэмжээний өртөг бүхий зам, замын байгууламжтай байгааг тогтоох, энэ хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулах боломж бий болгох

А. Дээрх ажлыг гүйцэтгэсэн эрх зүйн актууд –Зөвлөх инженер Н.Адилбиш

1. 2016 оны 3-р сарын 18-ны өдөр ЗТХЯ-тай байгуулсан гэрээ 2016 оны 3-р сарын 18-ны өдөр ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын баталсан Ажлын даалгавар
2. ЗТХЯ-ны Авто замын бодлогыг зохицуулах газрын даргын баталсан Ажил гүйцэтгэх удирдамж
3. “Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт”-ын ажлыг гүйцэтгэх хөтөлбөр, нарийвчилсан аргачлал

Б. Боловсруулалтын ажлыг гүйцэтгэхэд үндэслэл болгосон, ЗТХЯ-наас авсан тушаал, шийдвэр, паспорт карт, урьд өмнө нь хийгдэж судалгааны материал, хувь хүмүүсийн болон архивын баримт бичгүүд – Зөвлөх инженер Н.Адилбиш

1. ЗТХЯ-д одоо байгаа Авто замуудын паспорт, гүүр, хоолойн картууд
2. Олон улс, улсын чанартай Авто замын урт, чиглэлийн баталсан шийдвэр
3. 2009 онд хийсэн “Авто зам, гүүрийн дахин үнэлгээ”-ний товчоо 2008-2016 онуудад шинээр ашиглалтад орсон болон шинэчлэлт хийгдсэн зам, гүүрийн төсөвт өртгийн жагсаалт
4. 2008-2015 онуудад ашиглалтад орсон гүүрүүдийн үнэ ОХУ-ын “Авто замын өмчлөлийн эрхийн улсын бүртгэл”-ийн журам
5. Б.Лувсан гуайгаас авсан Монгол улсын нийт гүүрүүдийн бүртгэл

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

6. Авто зам баригдаж байгаа объектуудын Зөвлөх компаний багийн инженерүүдээс авсан мэдээлэл
7. Орон нутгийн Авто замын засвар, арчлалтын байгууллагуудын зарим инженерүүдээс авсан мэдээлэл
8. 2016 онд батлагдан гарсан Авто замын засвар, арчлалтын чиглэлийн үндсэн гол 3 техникийн баримт бичгийн материалууд
9. Зарим аймгуудаас ирсэн шаардлага хангаж байгаа мэдээллүүд

В. Дунд шатны тайлангийн шатанд хийсэн ажлын болон одоо боловсруулж байгаа баримт бичгүүдийн жагсаалт - Зөвлөх инженер Р.Балжир /1, 2, 3, 6, 7/, Н.Адилбиш /4,5, 8/

1. Нийт зам, гүүрийн тооллого бүртгэлийг газар дээр нь гүйцэтгэх багуудын хуваарь, гэрээ, техник тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, ажиллах бүрэлдэхүүн, автомашины хангалт
2. Зам, гүүрийн тооллого, бүртгэлийн ажлыг газар дээр нь гүйцэтгэх сургалт, туршилт, багаж хэрэгсэлүүдийн зүгшрүүлэлт
3. 3 багийн баруун, төв, зүүн бүсүүдэд нийт зам, гүүрийн тооллого, бүртгэл, иж бүрэн бичлэгийг газар дээр нь 2016 оны 7-р сарын 06-наас 8-р сарын 20-ны өдрүүдийн хооронд хийсэн иж бүрэн материал /бичлэг, фото, зам, гүүрт өгсөн үнэлгээ, зам, замын байгууламжийн байршлын солбицол, аймаг сумдын төвийн замын сүлжээний эхлэлийн 0+00 цэгийн байршлын тодорхойлолт, хөрсөн замуудын чиглэлийн сонголт г.м/
4. Зам, гүүрийн бичлэг, байршлын солбицолыг тодорхойлох Garmin JPS төхөөрөмж, оруулсан өгөгдлийн боловсруулалт хийдэг программ хангамжууд /Base Camp, Garmin Express, MapSource г.м/ -дад өгөгдөл оруулах үйл ажиллагаа Тухайлбал:
5. Газар дээр нь явж цуглуулсан өгөгдлүүдийг ашиглан, нийт замын трассыг Монгол орны газрын зурагт оруулах, кадастарт оруулах зурвасыг тодорхойлох, гүүр хоолойг оруулах
6. Авто зам, замын байгууламжийн тооллогын бүртгэлийг гаргах
7. Авто зам, замын байгууламжийн үнэлгээний суурь өгөгдөл гаргах
8. Авто зам, замын байгууламжийг, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээгээр үнэлсэн аргачлал, урьдчилсан баримжаа тооцоо

Г. Гэрээ, ажлын даалгаварын дагуу Олон улс, улсын чанартай замуудын тооллого, бүртгэл хийж, паспортжуулан, үнэлгээ хийх зэрэг ажлыг А24 замын жишээнд гаргаж харуулсан танилцуулга

1. А24 –Налайх-Тэрэлж чиглэлийн улсын чанартай замын одоогийн байгаа бүртгэл, паспортжуулалт- /Зөвлөх инженер Д.Баасанхүү, инженер Түвшин/
2. Монгол оны газрын зурагт А24 замын байршил /Бүх замууд ийм маягаар орно/- Балжмаа /GIS-ийн инженер/

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

3. Google Earth зурагт А24 замыг оруулж, кадастрт орох замын зурвасыг тэмдэглэсэн байдал, нийт гүүр, хоолойг оруулсан байдал – Балжмаа /GIS-ийн инженер/
4. А24 замын паспорт, гүүр, хоолойн карт- /Зөвлөх инженер Д.Баасанхүү, инженер Түвшин/
5. А24 замын бичлэг, фото зураг - /Зөвлөх инженер Д.Баасанхүү, инженер Түвшин/
6. А24 замын тооллогын бүртгэл - /Зөвлөх инженер Д.Баасанхүү, инженер Түвшин/
7. А24 замын өнөөгийн байдлын талаархи мэдээлэл өгөх үнэлгээг хүснэгтээр харуулах, өртөгийн шинэчилсэн үнэлгээ- /Зөвлөх инженер Д.Баасанхүү, инженер Түвшин/, Ц.Баатар /Тэргүүлэх үнэлгээчин, доктор/
8. Цаашид Авто замын бүртгэл мэдээллийн санг иж бүрэн цахимжуулж, IndorRoad гм программд оруулах боломжийн талаар А24 замын жишээн дээр харуулах –/Зөвлөх инженер Д.Баасанхүү, инженер .../

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Улсын чанартай замын паспортжуулалтын эхлэл, төгсгөлийн цэгийг Замын паспорт, гүүр, хоолойн картыг хөтлөхдөө тухайн замын эхлэлийн цэгийг 0.0 цэг гэж авах
2. Зам, гүүрийн өнөөгийн үнэ цэнийг тооцоход элэгдэл байгуулах уу, ер нь зам, гүүрийн элэгдэл гэж чухам юуг хэлэх вэ?
3. Дунд шатны тайлангийн дараах санхүүжилтийг 12-р сарын 15-ны яаралтай хийж, ажлын хэсгүүдээс замуудын өвлийн байдалтай танилцаж үнэлэлт, дүгнэлт гаргах нөхцөл бүрдүүлэх.
4. Авто замын бүртгэл мэдээллийн санг иж бүрэн цахимжуулж, IndorRoad гм программд оруулах саналыг дэмжиж шийдвэр гаргаж өгөх

САНАЛ:

1-р асуудал Эхпэгийн 00 цэг

Доржханд: Адилбиш танилцуулга дууссан тийм ээ?

Адилбиш: Дууссан дууссан.

Доржханд: Хийсэн ажлаа танилцууллаа. Ерөнхийдөө ойлголоо. Юу хийсэн, юу өгөх гэж байгааг бүгдээрээ ойлголоо. Энэ шийдэх ёстой асуудал дээрээ 3-н зэрэг явж байгаа төслийг нэг уялдуулах нэг асуудал байна. Орон зайн мэдээллийн сан, Батсайхан захирлын гүйцэтгэж байгаа вэб апплейкешн энэ 3 ажил юугаараа ялгаатай, юугаараа нийлэх юм, яаж уялдах юм энийг оруулмаар байна.

Адилбиш: Хэн оруулах уу?

Доржханд: Орон зайн мэдээллийн сан, Батсайхан захирлын гүйцэтгэж байгаа вэб апплейкешн, энэ ажил яам гээд дөрвөлсөн ажлын хэсэг байгуулаад уялдуулах ажлыг зохион байгуулна. Одоо 2 асуудал шийдвэрлэхээр ярья. Үнэлгээний асуудлыг дараа

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

тусдаа ярья. Мэргэшсэн төсөвчдийн хүрээнд дахин нэг танилцуулга хийх шаардлагатай байна.

Баатар: Би нэг санал хэлье.

Доржханд: За

Баатар: Энэ төсөв гэдэг чинь нэг өөр. Бид одоо саяхан яамнаас батлагдсан тэр төсвийг харгалзаж үзсэн. Үнэлгээ гэдэг чинь бас өөр

Доржханд: Үгүй ээ. Төсөвтэй үнэлгээ уялдах ёстой.

Баатар: Мэдээж бид нар тэр баримтлах ёстой. Төсөв гэдэг үнэлгээ биш л гэж хэлэх гэж байна.

Балжир: Энэ чинь 2 өөрөө.

Баатар: Үүнийг тэр заавал төсөвчинтэй холбох шаардлага байхгүй. Төсөвчин бол энэ зам ямар өртөгөөр баригдаж байгааг тооцож гаргаж байгаа юм. Үнэлгээчин бол үүнээс шал өөр ойлголт шүү. Үүнийг бас та харгалзаж үзээрэй гэж хэлье.

Энхтүяа: Энэ бол зүгээр та км замын өртгийг индексийн хувиар үржүүлээд дараа энэ зохицуулах итгэлцүүрүүдээр үржүүлээд гаргачихсан өртөг байна. Энд бол нэг их тийм айхтар хүнд харагдахгүй байна. Яаж үнэ цэнийг, өшөө юу тооцдогийг нь мэдэхгүй учраас, энэ цаасыг харахад тэгэж харагдаад байна л даа.

Балжир: Энэ ийм байхгүй. Өнөөдөр бид нар энэ монгол улсад байгаа 54 чиглэлийн чинь зам төсөвдөө ямар үнэтэй байгаан гаргаж өгөх гэж байгаан шүү дээ. Тэрнээс биш маргаашийн замын үнэ цэнийг яриагүй ш дээ

Доржханд: Бид нар маргаашийн замын үнийг гаргуулах гээгүй байна. Би таньд яагаад хэлж байна гэхээр, танины юмыг өөрчлөх гээд ч байгаа юм биш. Яагаад гэхээр төсвөөс шалтгаалаад үнэ гарч байгаа юм чинь үнэ мэддэг хүмүүсийн дунд хэлэлцүүлгээ хийчихээд тэгээд наад ажлаа эцэслээд ороод ирээч ээ гэж байгаан.

Баатар: За баярлалаа. Хүлээж авъя.

Балжир: Мөнгө мэддэг хүмүүс гэж хэн байгаан?

Доржханд: Төсөвчин нар чинь үнэ мэддэг юм байгаа биз дээ.

Балжир: За больж үз.

Лувсан: Үндсэн хөрөнгийн үнэлгээгээ тусад нь яривал яасан юм бэ.

Буд: За та минь ээ. Ингэвэл яасан юм бэ. Эцэслээд дуусгаад явчихвал яасан юм.

Доржханд: Одоо эхний 00 цэгийн аасуудал.

1.Эхлэлийн цэгийн асуудал

Зам гүүрийн эхлэлийг тухайн эхлэлийн цэгээс бичих үү? Сүлжээний эхлэлийн цэгээс бичих үү?

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Доржханд: Одоо явж байгаа нь бол УБ хотоос 00 цэгээс эхлэж байгаа. Хэрвээ эхлэж байгаа замаасаа явбал одоо энэ бүх тэмдэгжилт өөр болно гэсэн үг биз дээ? Энийг яагаад ингэж оруулж ирсэн юм.

Балжир: Би тайлбарлах уу?

Доржханд: За

Балжир: Улаанбаатар-Арвайхээр /А0301/ чиглэлийн зам УБ хотын 19км-с эхлэнэ гээд өгчихсөн байгаа. Бас Улаанбаатар-Дархан /А0401/ чиглэлийн зам УБ хотын 19км-с эхлэнэ. Гэтэл км нь Улаанбаатар-Арвайхээр /А0301/-431км, Улаанбаатар-Дархан /А0401/ -232км гээд энэ 19 км-г энэ 2 зам хоёуланд оруулаад өгчихсөн байна. Бас Улаанбаатар-Өндөрхаан /А0501/ чиглэлийг Налайхын баруун хойд дэнжээс эхлэнэ гээд өгчихөж, гэтэл Баасанхүү дарга бол энэ зам 00 цэгээсээ эхлэх ёстой гээд байгаа. Энэ замуудын чинь сүлжээний урт нэг өөр, замын тарифийн урт нь өөр байгаад байна. Улсын замын сүлжээний уртыг бүрдүүлж байгаа хотын зам чинь энэ сүлжээндээ орох юм уу? Үгүй юм уу? Гэсэн олон маргаантай асуудлууд үүсээд байгаа учраас аль зам нь 00 цэгээсээ эхлэх, аль зам нь хаанаасаа эхлэхээ тодорхой болгож өгөх хэрэгтэй байна.

Буд: За би энэ дээр нэг санал хэлье. Энэ их зарчмын асуудал. Би энэ хооронд интернет үзээд сууж байлаа. Унгар, гадаадын зарим орнуудад 2 тэмдэглэгээ байна. Баруун талд нь бол нийслэлээс буюу 00 цэгээс явж байгаа км, зүүн талд нь бол орон нутаг хоорондын тэмдэг байна. Жишээлбэл: Ховдын хүнд бол Ховд хүртэлх км хэрэгтэй.

2. Энд яригдаад байгаа Өвөрхангай, Дархан 2-ын зам дээр 2-нд нь 19 км-ээ оруулах уу? Үгүй юу? Тэгэхээр энд мөн яам нь юм уу? Засгийн газар нь бодлого гаргачих ёстой юм. Дархан хот хотын зэрэглэлтэй юу? Тэгвэл Дарханы замыг 1-р зам гэж аваад түүнээс салж байгааг нь салаанаас тооц гэсэн зарчим байгаа байхгүй юу? Чингис хаан хот монгол улсын төв хотыг дайран гарч байгаа тэрнээс салж байгаа хэсгээс эхлээд тооцно гээд зарчимаа тохирох. Тэмдгээ бол олон улсын жишгийн дагуу 2 талд нь байна. Нэг нь бол 00 цэгээсээ төв суурин газраа хүрсэн нөгөөх нь бол төв суурин газраа холбосон тэмдэг байна. Энийг бол яам бодлого барьж байгаа улсууд та нар хагалаад өгчих.

Баасанхүү: Гэрээ гээд бүх юм чинь 00 цэгээсээ яваад байгаа ш дээ. Одоо өөрчилнэ гэвэл ямар ч утгагүй зүйл.

Доржханд: 00 цэгээ өөрчилнэ гэвэл хэцүү шүү дээ.

Балжир: Бид өөрчил гэж хэлээгүй байна. Чиглэл л өгчих

Батсайхан: Сая батлагдсан төлөвлөлтийн нормоор 3 ангилж байгаа.

1. Төв зам
2. Collector /хуримтлуулагч/

3. Local

Энэхүү зарчимдаа үндэслээд дугаарлалтаа хийгээд явчихбал цаашдаа амар болно, зав болно, хоорондоо уялдаатай болно. Манайд өнөөдөр замын сүлжээ хэрэглэгчдийн түвшинд ойлгомжтой болоогүй болохоор зарим нь ойлгохгүй байх. УБ-Замын-Үүдээ гол чиглэл гээд түүнээс салаалж байгаа зүүн чиглэлийн зам маань Collector болно. 5 үндсэн чиглэлээ үндэс болгоод цааш нь дугаарлаад салаалаад явах нь зүйтэй.

Балжир: Батсайхан наадахыг чинь албажуулаад албан ёсны болгоод тэрийн үндэслээд бид нар цааш нь юмаа хиймээр байна.

Батсайхан: Харин тийм ээ. Тэгэхээр ойлгомжгүй энэ зүйлийг батлагдсан төлөвлөлтийн нормтойгоо уячихвал цаашид ойлгомжтой болно.

Балжир: Энд хугацааны асуудал байна шүү дээ Бид цааш нь яаж үргэлжлүүлэх вэ гэдэг?

Адилбиш: Батсайханы ярьж байгаатай холбоотойгоор манай ажлын даалгаварт байгаа Авто замын код эхлэх, төгсгөлийн цэгийн нэр батлах тухай Дэд Бүтцийн Сайдын 1994 оны 165-р дугаарыг шинэчлэн боловсруулах гэсний хүрээнд шийдвэрлэж байгаа юм шүү.

Хүрэлсүх: Тэгвэл энд нэг санал байна. Тухайн аймгийн орон нутагтай зөвшөлцөөд, тухайн орон нутгийн эхлэлийн цэгийг бий болгох

Лувсан: Би энд нэг түүхэн шийдвэртэй холбоотой юм ярья. Сайд нарын Зөвлөлийн 1971 оны 95-р тогтоолоор анх улсын чанартай эхлэлийн цэгийг УБ хотын координацийн төвөөс тоолно. Аймгаас аймгийн хоорондох замыг аймгийн төвийг дайран өнгөрч байгаа улсын чанартай замын аймгийн гүйцэтгэх захиргаанд хамгийн ойр байгаа уулзвараас авна гээд тогтоол дээрээ байгаа.

Адилбиш: Лувсан гуай Балжир түрүүн хэлсэн байгаа бид СнЗ-ын 95-р тогтоолын дагуу тооллого бүртгэлээ явуулсан. Ганцхан дээр дурьдсан 5 чиглэл дээр маргаантай байгаа.

Пүрэвжав: Батсайхан, Балжир нарын санал зөв л дөө. Би Лувсан гуайн саналыг үгүйсгэж байгаа юм бус. Нэгэнт Замын-Үүдийн чиглэлээс эхлээд нар зөв 5 гээд дугаарлчихсан юм чинь энүүгээрээ байг. Бусад замуудын эхлэж байгаа цэгээс нь нормондоо нийцүүлээд давхцалыг арилгачих.

Адилбиш: Пүрэвжав доктороо нэг тодруулга асууя болох уу? Замын эхлэл төгсгөлийн нэршлэлийг Балжир инженерийн шинэ нэршил гэдгээр өөрчлөх санал байгаа юм байна тийм ээ?

Пүрэвжав: Би та нарын дэвшүүлж байгаа санлын чинь дэмжиж байна. Давхцахгүй болгочихвол

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Доржханд:Тээврийн тарифт өөрчлөлт орох гээд байна. Энэ талаар ажлын хэсэг байгуулж нэн даруй шийдвэрлэж өгнө. Яам шийднэ.

Балжир:Хэзээ шийдэж өгөх үү? Ажил зогсох гээд байна. 19км-с эхлэх үү? 00 цэгээс эхлэх үү?

Доржханд:Дараачийн 7 хоногт шийдвэрлэж өгье.

За дараачийн асуудалдаа орьё.

Зам, гүүрийн өнөөгийн үнэ цэнийг тооцоход элэгдэл байгуулах уу, ер нь зам, гүүрийн элэгдэл

Доржханд: Элэгдэл байх ёстой.

Буд: 90-ээд оны дунд үед би энэ асуудлыг анх гаргаж тавьж энэ талаар судлах үүрэг Энхтөрд өгч байсан. Бусад газрууд техник, материал бүх зүйл дээр элэгдэл тооцож байна. Ер нь энэ зам гүүрт элэгдэл байж болдоггүй юм уу? Олон улсад байдаг үгүйг би өнөөдрийг хүртэл олж үзээгүй байна.Элэгдэл тооцоход засвар хоорондын хугацаагаар тооцох уу? Эсвэл бодит элэгдэлээр тооцох уу?

Баасанхүү: Насжилттай л холбоотой ш дээ.

Буд: Манай элэгдэл бас их өөр ш дээ. Энэ эрс тэс уур амьсгал байгалийн нөлөөлөл гэж их зүйл байна шүү дээ. Тэрнээс биш тээврийн хөдөлгөөнөөс элэгдэнэ гэдэг бол хаьцангуй ойлголт байх. Тэнхлэгийн даацаас хэтэрсэн ачаалал эвдэнэ гэхээс биш бусдаар бол өөр юу байх вэ.

Лувсан: Та бүхэнд нэг зүйл хэлэх үү. 1960-аад оноос замын газрын балансид манай зам гүүрийн үнэ үндсэн хөрөнгийн бүртгэл байсан юм. За тэгээд хэдэн сая төгрөгний замтай, хөрөнгөтэй гээд байсан юм. Одоо тэгээд өмчлөгч нь төр болчихоод өмчийн эзэн олдохгүй болоод, өмчөө үнэлэхээ байсан. Хэдэн төгрөгийн өртөгтэй хөрөнгөтэй гэдгээ гаргаж ирэхэд элэгдлээ тооцох хэрэгтэй. Засвар арчлалтын мөнгийг гаргаж ирэхийн тулд элэгдлийг бодох зүйтэй.

Буд: Энэ хүмүүсийн хийж байгаа засвар хийсэн өртгийг нэмээд лэгдэл хорогдлол, инфляцийн өөрчлөлт гээд 35 хувийн өсөлт гээд тэр биз дээ. Элэгдлийг яаж тооцох юм энэ бараг бие даасан сэдэвт байж магадгүй энэ талаар Доржханд дарга эд нар анхаарах юм байгаа биз.

Балжир: Зам дээр элэгдэл тооцоод хасах юм уу? Хассаар байгаад байхгүй болно шүү дээ

Буд: Тэгэхээр нөгөө засвар хоорондын хугацааг ярьж эхлэх ёстой байхгүй юу.

Доржханд: Ашиглаж байгаа юм чинь элэгдэл байх ёстой.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Дунд шатны тайлангийн дараах санхүүжилтийг 12-р сарын 15-ны яаралтай хийж, ажлын хэсгүүдээс замуудын өвлийн байдалтай танилцаж үнэлэлт, дүгнэлт гаргах нөхцөл бүрдүүлэх.

Доржханд: Энэ бол зүгээр хүсэлт юм байна тийм ээ? Шийдвэр биш

11/10/2016

“Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, замын паспорт, гүүрүүдийн карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт” ажлын танилцуулга

№	Хаанаас	Нэр	Албан тушаал	Гарын үсэг
1	Зам тээврийн хөгжлийн яам	Д.Доржханд	ЗТХЯ-ны захирлын дарга	Д.Доржханд
2		Мэргэн		
3		Ринчендамба		
4		Сэрээтэр		
5		Минжбадам	ЗТХЯ-ны захирлын дарга	
6		Гэрэлням		
7		Одгэрэл		
8		Угтахбаяр		
9		Эрдэнэсайхан		
10		Загдраднаа	ЗТХЯ-ны захирлын дарга	
11		Ж.Хуандаг		
12		Д.Энхтуяа	ЗТХЯ-ны АЗБХЗТ-ийн захирлын дарга	
13		Х.Оргил-Эрдэнэ	ЗТХЯ-ны захирлын дарга	
14		Н.Сугаржав		
15		А.Гантулга		
16		С.Мөнхбат	ЗТХЯ-ны АЗБХЗТ-ийн захирлын дарга	
17		Ц.Хосгэрэл	ЗТХЯ-ны АЗБХЗТ-ийн захирлын дарга	
18		Б.Дархандарьяа		
19		Д.Оюунбилэг	ЗТХЯ-ны АЗБХЗТ-ийн захирлын дарга	
20		А.Ханбаяр		
21		Алтангэрэл		
22	Зам тээврийн хөгжлийн төв	Р.Буд		
23		Х.Хүрэлсүх	Замын хэрэгсэлтэй хөтөлгөөний дарга	
24		Сарандулам	СМС-ийн хөтөлгөөний дарга	
25		О.Оюунбилэг	Замын паспорт ногдоон бүртгэл	
26		В.Батсайхан	Замын барилгын хөтөлгөөний дарга	
27		Ж.Батсайхан	Замын барилгын хөтөлгөөний дарга	
28	Зөвлөх инженерүүд	Б.Лувсан	АХМ-ийн хөтөлгөөний дарга	
29		С.Очирбат		
30		У.Пүрэвжав	“АВЗ-ийн зам” ХУК-ийн захирал	
31		Ж.Батсайхан	МРК	
32		О.Бямбажав		
33		Т.Батжаргал		

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

№	Хаанаас	Нэр	Албан тушаал	Гарын үсэг
34	Зөвлөх инженерүүд	Я.Цэндсүрэн		
35		Т.Бямбаа	МАЗХ	
36		Ч.Намшир		
37		Я.Баярхүү		
38		Н.Сэмжид	“Каг сурвас” ХХК.	
39		Ж.Даваасүрэн		
40		Баттогтох		
41		Хүрэлбаатар		
42		Зөвлөх-Төвийн багийнхан	Д.Баасанхүү	
43	Р. Балжир			
44	Н.Адилбиш			
45	Х.Гантөмөр			
46	Ц.Баатар			
47	Ариунаа			
48	Золжаргал			
49	Балжмаа			
50	Отгонбаатар			
51	Эрдэнэжаргал			
52	Түвшин			
53	Ардах			
54	МРСГ	Д. Дамжид	БИС	МРХ Дамжид
55	М.Аж	Э.Мөнх-Агуй	Програмайт	МРХ М.Аж

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



6.2 2017 оны 5-р сарын 18-ны өдрийн 2 дахь хэлэлцүүлэг

УУЛЗАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

Монгол улсын Авто замын үндэсний сүлжээг өргөжүүлэх, цахим бүртгэл мэдээллийн сантай болох асуудлаар Зөвлөх инженерүүдээс гаргасан саналын талаар 2017 оны 05-р дүгээр сарын 18-ны өдөр (Пүрэв гариг)-ийн 10:00-12.30 цагт ЗТХЯ-ны 301 тоот хурлын танхимд Зөвлөхүүд, ЗТХЯ-ны холбогдох мэргэжилтэнүүдтэй уулзалт хийв.

Уулзалтад, **Зам, тээврийн хөгжлийн яамнаас:** Замын ашиглалт, засварын хэлтсийн дарга Х.Оргил-Эрдэнэ, Замын ашиглалт, засварын хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Загдраднаа, Замын ашиглалт, засварын хэлтсийн ахлах мэргэжилтэн Н.Сугаржав, Замын ашиглалт, засварын хэлтсийн мэргэжилтэн С.Мөнхбат, Замын ашиглалт, засварын хэлтсийн мэргэжилтэн Ц.Хосгэрэл, **Зам, тээврийн хөгжлийн төвөөс:** Замын засвар, арчлалтын хяналтын хэлтсийн дарга Я.Гантулга нар, **Зөвлөх компанийн төлөөлөл:** Зөвлөх инженер Д.Баасанхүү, Н.Адилбиш, Р.Балжир, Х.Гантөмөр, инженер А. Золжаргал, Эрдэнэжаргал нар оролцлоо.

Уулзалтын эхэнд Зөвлөх инженер Н.Адилбиш “Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт”-ын ажлын явцын талаар товч танилцуулж, энэ ажлын хүрээнд дараах 2 нэмэлт ажлыг хийх асуудлыг шийдвэрлэвэл, дээрх төслийн иж бүрдэл бүрэн хангагдаж, төгс болно гэж үзэж байгаагаа хэлээд программ хангамжийн талаар товч, Улсын чанартай замын сүлжээний шинэ чиглэлийг тогтоох асуудлаар нилээд дэлгэрэнгүй танилцуулав. Үүнд:

1. Авто замын сүлжээний бүртгэл мэдээллийн иж бүрэн цахим программ.

2016 оны 11-р сарын 10-нд хийсэн явцын тайлангийн өргөн хүрээтэй хэлэлцүүлэгийн үеэр ажлын хэсгээс ОХУ-д ашиглаж байгаа Авто замын сүлжээний бүртгэл мэдээллийн буюу “INDOR ROAD” программын талаар тодорхой танилцуулсан билээ. Энэхүү программыг сонгож байгаа гол үндэслэл нь:

- а) Манай Авто замын салбарын ихэнх техникийн баримт бичиг, норм стандарт нь хуучны ЗХУ-ын норм, дүрэмд ямар нэгэн хэмжээгээр суурилсан байдаг, мөн Авто замын төсөллөлтөд INDOR-ын бусад программуудыг ашиглаж байгаа учраас бидэнд нилээд ойр.
- б) INDOR-ын программууд нь цахим чиглэлээр Монгол улстай бараг ижил гараанаас эхэлсэн, зүүн хэсэг нь Монголтой ижил төстэй уур амьсгал бүхий орон болох Оросын программ учраас нилээд ойлгомжтой, цаашид өөрчлөлт шинэчлэлт хялбархан хийгээд явах боломжтой.
- в) INDOR-ыг боловсруулсан ОХУ-ын мэргэжилтнүүд нь бидний үсэг ижилхэн учраас энэ программыг Монгол болгоход хялбар гэж үзэж байгаа.
- г) INDOR-ыг ашигласнаар авто замын сүлжээний бүх ангиллын замын бүртгэл ба паспортжуулалтыг иж бүрэн гүйцэтгэх, замын арчлалт, засвар болон ашиглалтын үйл ажиллагааг удирдах, нэгдсэн дүн шинжилгээ хийх, дурын элементийн паспорт болон картыг харах, замын дурын хэсэгт видео бичлэг үзэх, оношлогооны мэдээллийг газрын зураг дээр хүснэгт болон жагсаалт хэлбэрээр үзүүлэх, зорчих хэсгийн гадаргууд үүссэн ямарваа нэгэн эвдрэл, хагарлыг болон далангийн өндөр, дагуу ба хөндлөн хэвгийнүүдийг олох, харах, их засвар, шинэчлэлтийн хялбарчилсан зураг төслийг боловсруулах, замын паспорт болон бусад стандарт ба хэрэглээний тайлангуудыг үүсгэх, цомог хэлбэрээр танилцуулга материалыг бэлтгэн гаргах, эцэст нь авто замын салбарын удирдлагын бүх шатны байгууллагад (яам, нийслэл, орон нутаг, түүнчлэн барилга, засварын бүх гүйцэтгэгчид ашиглах боломжтой юм.

Энэ программын Монгол хувилбарыг бий болгож, Авто замын сүлжээний бүртгэл мэдээллийн санд ашиглахад гарах бодит зардал:

- Программыг худалдаж авах /5 компьютерт: Яам-2, ЗТХТ-1, ТББ-2/ - 15.0 сая.₮
- Программын Монгол хувилбар бий болгох чиглэлээр Томск-д судлах, ажиллах зардал- 5хүн* 20 хоног* 400.0мян.₮= 40.0 сая.₮ /ОХУ-ын талаас ажиллах 2 мэргэжилтний зардлыг оруулж тооцсон/

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

- Унааны зардал- 5хүн*1200.0мян.₮ (2 талдаа)=6.0сая.₮
- Программын бүх өгөгдөл, техникийн баримт бичгүүдийг оросоос монгол хэл рүү хөрвүүлж, программд оруулах зардал – 3 хүн * 60 хоног *80.0 мян.₮ = 14.4 сая.₮
- Программын Монгол хувилбарыг бий болгох, сургалт зохион байгуулах зардал- 8.0 сая.₮
- Программд жил бүр өөрчлөлт, шинэчлэлт хийж байх зардал 5 суудал* 2400.0 мян.₮= 12.0 сая.₮

Бүгд - 95.4 сая.₮

2. Улсын чанартай Авто замын сүлжээний шинэ чиглэлүүдийг тогтоох.

“Авто замын тухай” хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан. “Авто зам төсөллөлт”-ийн шинэ норм ба дүрэм гараад ашиглагдаж эхэлж байна. Эдгээр эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах, Улсын чанартай замын чиглэлийг тогтвортой байлгах зорилгоор дараах шинэ чиглэлийн замуудыг нэмж, улсын чанартай Авто замын бүртгэлд оруулан, тооллогод хамруулж, хэмжилт, үзлэг хийж Засгийн газрын шийдвэр гаргуулах шаардлагатай байна. Үүнд:

- A34 ЦогтОвоо-Даланзадгад-Шивээхүрэн	- 426,2 км
A3401 Цогт-Овоо-Даланзадгад	- 124,0 км
A3402 Даланзадгад-Шивээхүрэн	- 302,2 км
- A35 Сайншианд-Мандалговь-Арвайхээр	- 630,9 км
A3501 Сайншианд-Мандалговь	- 339,4 км
A3502 Мандалговь-Арвайхээр	- 291,5 км
- A36 Сайншианд-Баруун-Урт	- 338,0 км
- A37 Чойр-Өндөрхаан	- 233,6 км
- A38 Алтай-Даланзадгад	- 843,0 км
- A39 Улаангом-Зүүнговь-Баянтэс-Цэцэрлэг-А1102 –Мөрөн	- 511,6 км
- A40 Өгийнуур-Өлзийт-Хайрхан-Рашиант-Сацын булан-А0902 зам	- 232,8 км
- A41 Мөрөн-Шинэ-Идэр-Жаргалант-Тэрхийн цагаан нуур-Цэцэрлэг /А0603 зам/	- 224,5 км
- A42 Чойр-Мандалговь	- 185,3 км
- A43 Даланзадгад- Арвайхээр	- 364,0 км
- A44 Сайншианд-Хөвсгөл-Ханги-Улсын хил	- 300,9 км
- A45 Сайншианд-Даланзадгад	- 515,0 км
- A46 Баянхонгор-Цэцэрлэг /Эрдэнэцогт сумаар/	- 195,1 км
Нэмэгдэх нийт замын урт	5 000,9 км

Эдгээр замуудыг газар дээр нь явж үзэж, бичлэг, хэмжилт хийх, хувилбаруудыг харьцуулах, кадастрын зурагт оруулах, паспортжуулах ажилд гарах нэмэлт зардал:

$5\ 000,9\text{км} * 16\ 700₮ = 83,5\ \text{сая}₮$

/Зардлыг одооны гэрээний 1 км ногдох хээрийн хэмжилтийн зардлыг үндэслэн тооцов./

Хэлэлцсэн нь:

1. Авто замын сүлжээний бүртгэл мэдээллийн иж бүрэн цахим программ.

Н.Адилбиш: Энэ асуудлаар ЗТХЯ-ны Газрын дарга Д.Доржханд, албаны дарга Б.Минжбадам нарт танилцуулж, дэмжлэг авсан бөгөөд одоо хөрөнгийн асуудлыг шийдэхийг хүлээж байгаа юм.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Д.Баасанхүү: Өнгөрсөн 7 хоногт болсон ЗТХЯ-ны шинжлэх ухаан техник, технологийн зөвлөлийн хурлаар Эм Си Пи Си компанийн гүйцэтгэж байгаа вэб аппликейшн ажил танилцуулагдаж батлагдаж байна лээ. Хэрвээ бидний цуглуулсан мэдээллийг оруулахгүй бол хэрэггүй ш дээ. Зүгээр JPS шүү дээ гэж хэлсэн шоолж байна лээ. Батсайхан тэр мэдээллийг оруулахад амархан гэсэн. Яамныхан та нар түүн дээр анхаараарай. Адилбиш чи редакцийн хэсгийн ахлагч байсан гэнэлээ шүү дээ. Юу хийснийг мэдэж байгаа биз дээ.

Н.Адилбиш: Тийм. Загдраднаа, Хосгэрэл бид нар редакцийн хэсэгт байсан. Бид, дунд шатны тайланд редакци хийж саналаа өгсөн. Уг нь 3 түвшинд хэрэглэдэг байхаар чиглэл өгч, ийм аппликейшнтэй болох нь зүйтэй гэж үзсэн. Та бүхэн эцсийн шатных гэж үзээд мөнгө төгрөгийг нь өгөхийг шийдсэн бол бид яах вэ дээ. Вэб аппликейшн, программ хоёр 2 өөр зүйл шүү дээ. Бид одоо программын тухай ярьж байна. Яам зөвшөөрвөл бид Улсын чанартай замын иж бүрэн мэдээллийг хэнд ч өгөхөд бэлэн байна.

Р.Балжир: Тэр вэб аппликейшн гэгчид бид бүхний өнгөрсөн зуны газар дээр хэмжсэн мэдээллийг оруулахгүй бол хэрэггүй шүү дээ. Харин бидний та бүхэнд танилцуулж байгаа зүйл вэб аппликейшн биш шүү, энэ бол программ. Бид цуглуулсан бүх мэдээллээ программд оруулахад бэлэн. Тэрнээс биш энэ өрөө дүүрэхээр цаас бид бүхэнд хэрэггүй шүү дээ. Энэ программтай болсноор паспортжуулалтыг иж бүрэн гүйцэтгэх, замын арчлалт, засвар болон ашиглалтын үйл ажиллагааг удирдах, төсөвлөх, их засвар, шинэчлэлтийн зураг төслийг боловсруулах, замын дурын хэсэгт видео бичлэг үзэх, салбарын удирдлагын болон бүх шатны байгууллагад ашиглах боломжтой юм.

Д.Загдраднаа: Бид программтай байх нь зүйтэй гэж үздэг. Харин заавал Монгол хэлээр байх албагүй, англиар байсан ч болно. Германы программыг судалж харилцан санал солилцож байгаа. Тэгэхдээ тэдний программ арай л өндөр төвшнийх бололтой юм билээ.

Н.Адилбиш: Бидний энэ ажлын эцсийн нэг үр дүн нь Авто замын бүртгэл мэдээллийн цахим Монгол программтай болох гэж үзэж байгаа. Жил болгон шинэчлэлт хийгдэж байдаг, манайтай ижил төвшингийн орных байвал зүгээр болов уу гээд, Оросынхыг сонгосон. Та бүхэн дэмжиж өгөөрэй.

2. Улсын чанартай Авто замын сүлжээний шинэ чиглэлүүдийг тогтоох.

Н.Адилбиш: Бид та бүхэнд өгсөн танилцуулгаар шинээр 13 чиглэл буюу улсын чанартай замын уртыг 5000 км замаар нэмэгдүүлэх санал оруулж байна. Энэ асуудлыг 2 хувилбараар шийдэх боломжтой гэж үзэж байна. **1.** Одоо хийж байгаа улсын чанартай замын тооллого бүртгэл шиг газар дээр нь явж чиглэл тогтоон хэмжилт, үзлэг хийж паспортжуулах. **2.** Газар зүйл мэдээллийн систем ашиглан хэмжилт хийж бүртгэлд авах. Аль ч хувилбарыг сонгосон хуулийн дагуу ЗТХ-ийн сайдын тушаал гарна. Бид та бүхний саналыг тусгаад тушаалын төсөл гаргахад бэлэн байна.

Д.Загдраднаа: Бид бүхэн үзээд, танилцаж, ярилцсан байгаа. Би нөхдийгөө төлөөлөөд ярьчих уу.

-А0202 чиглэлийн замын хувьд, Мандалговь-Даланзадгад-Шивээхүрэн гээд хилийн боомтоо холбосон зам болгоё.

-Харин Даланзадгад-Гашуунсухайт-Улсын хил чиглэлийн шинэ чиглэл гаргаад,

А33 чиглэлийн Даланзадгад-Цогтцэций-Гашуунсухайт боомт гэсэн замтай болох нь зүйтэй байх.

Бүгд: Тэгье зөвшөөрч байна.

Д.Загдраднаа: Сайншанд-Мандалговь-Арвайхээр А35 замыг Арвайхээрээсээ эхлүүлбэл яаж байна?

Н.Адилбиш: Бид нар уг нь олон улсын чанартай АНЗ замаас байвал зүйтэй байх гээд Сайншандаас эхлүүлсэн.

Д.Загдраднаа: Арвайхээрээс эхэлсэн зөв байх, Монгол улсын төвөөсөө гэж бодож байна.

Бүгд: Тэгье зөвшөөрч байна.

Д.Загдраднаа: Сайншанд-Баруун-Урт энэ чиглэлийг Халзан сумаар биш харин Дэлгэрэх сумаар дайруулж явуулья.

Бүгд: Тэгье зөвшөөрч байна.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Д.Загдраднаа: Чойр-Өндөрхаан, Сайншанд-Даланзадгад, Сайншанд-Хөвсгөл-Ханги-Улсын хил, Чойр-Мандалговь эдгээр чиглэлд ямар нэгэн санал алга. Та бүхний саналыг дэмжиж байна.

Харин бид нар ярилцаад хэд хэдэн чиглэл яг одоохондоо нэмэх шаардлагагүй гэж үзэж байна. Тухайлбал, Алтай-Даланзадгадыг, Улаангом-Зүүнговь-Баянтэс-Цэцэрлэг-А1102 –Мөрөн чиглэлийн замыг ч мөн шаардлагагүй гэж үзэж байна. Мөрөн-Улаангомьн зорчигчид А18 чиглэлийн замаар явчихна. Удахгүй энэ зам хатуу хучилттай болчих учраас нэг чиглэлд 2 зам давхцаад байна. Мөн Хөл саяын даваагаар явдаг Баянхонгор-Цэцэрлэгийн зам нь одоохондоо улирлын чанартай учраас түр хойшлуулья, орон нутгийн хэдхэн машин явдаг Арвайхээр-Даланзадгадыг оруулбал, дэндүү явцуу болчих байх, одоохондоо хэрэггүй. Мөн Өгийнуураас-Сацын булан орох зам нь босоо тэнхлэгийн олон замтай зэрэгцэж байгаа учраас одоохондоо хэрэггүй.

Х.Гантөмөр: Одоо ихэнх машин Өгийнуур-Сацаар явж байгаа шүү. Удахгүй хатуу хучилттай зам ч баригдах байх.

Р.Балжир: Улаангом-Зүүнговь-Баянтэс-Цэцэрлэг-А1102 –Мөрөн чиглэлийн зам, урьд нь Улсын чанартай байсан, 2 аймгийн төвийг холбосон ихээхэн шулуун зам шүү дээ.

Х.Оргил-Эрдэнэ: Мөрөн-Шинэ-Идэр-Жаргалант-Тэрхийн цагаан нуур- Цэцэрлэг /А0603 зам/ гэсэн чиглэл оруулж ирсэн нь аялал жуулчлал хөгжүүлэхэд тун чухал гэж үзээд дэмжиж байна.

Н.Адилбиш: А33 зам хуультай зөрчилдөж байгаа. Мөн А26 Баянхонгор-Шаргалжуут, А28 Хархорин-Хөшөөцайд-Өгийнуур, А30 Хатгал-Тойлогт, А32 Шаамар-Зүүнбүрэн-Зэлтэр гэсэн замууд ч Авто замын тухай хуулиар Улсын чанартай замын ангилалд хамааруулахад ойлгомжгүй байна. Бидний санал болгож байгаа замуудыг хасч байгаа болохоор нэг зарчим баримтлах нь зүйтэй байх. Үүнийг яах вэ.

Харилцан ярилцаад, А33 замыг хасахаар төсөлд оруулж ирэхээр тогтлоо.

Я.Гантулга: Би оруулж ирсэн замын бүх чиглэлүүдийг дэмжээд улсын чанартай замаа өргөтгөх нь зүйтэй гэсэн саналтай байна. Харин чиглэлүүдийг сонгохдоо тухайн орон нутгийн ард иргэдээс хуулийн дагуу санал авах нь зүйтэй.

Н.Сугаржав: Зарим замын үндсэн чиглэлд бага зэргийн өөрчлөлт оруулаад тушаалын төслөө оруулж ирээрэй. А0604-ыг Нөмрөг-Тэс-Арцсуурь-Улсын хил гэж, А32-ыг Шаамар-Зүүнбүрэн-Зэлтэр-Улсын хил гэж. Мөн А1701, А18-р замуудын эхлэл төгсгөлийг тодорхой болгоорой.

Уулзалт, дээрх 2 асуудлаар нилээд нухацтай харилцан ярилцаж ойлголцсон, асуудлыг олон талаас нь хэлэлцэж шийдвэрлэсэн, ажил хэрэгч байдалтай болж өнгөрлөө. 6-р сарын эхний хагаст багтаан сайдын тушаалын төсөл оруулж ирэхээр тогтлоо.

Уулзалтын тэмдэглэл хөтөлсөн, Зөвлөх инженер

Н.Адилбиш

Тэмдэглэлтэй танилцсан. Замын ашиглалт, засварын хэлтсийн дарга

Х.Оргил-Эрдэнэ

Ахлах мэргэжилтэн

Д.Загдраднаа

Ахлах мэргэжилтэн

Н.Сугаржав

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



6.3 2017 оны 07-р сарын 04-ны 3 дахь хэлэлцүүлэг

Танилцуулга, хэлэлцүүлэгийн тэмдэглэл

“Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт”-ын ажлын Зөвлөх “Ар Ди Эй Си” ХХК-иас ЗТХЯ-ны дэмжлэгтэйгээр зохион байгуулсан танилцуулга, хэлэлцүүлэгийг 2017 оны 07-р дүгээр сарын 04-ны өдөр (Мягмар гариг)-ийн 10.30-12.30 цагт ЗТХЯ-ны 301 тоот хурлын танхимд хийв.

Хэлэлцүүлэгт, Зам, тээврийн хөгжлийн яамнаас: ЗТХЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын Стандарт нормативийн хэлтсийн дарга Ж.Сэрээтэр, Стандарт нормативийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Гэрэлням, Стандарт нормативийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ө.Одгэрэл, Бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн М.Угтахбаяр, Бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Д.Бодьсайхан, Хөрөнгө оруулалт үйлдвэрлэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Алтангэрэл, Хөрөнгө оруулалт үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн О.Очгэрэл, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Д.Энхтуяа, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Н.Сугаржав, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Ч.Сугармаа, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Ц.Хосгэрэл, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн А.Ханбаяр,

Зөвлөх компаний төлөөлөл Зөвлөх инженер Н.Адилбиш, Р.Балжир, Х.Гантөмөр, инженер А. Золжаргал, Эрдэнэжаргал, Түвшин нар оролцлоо.

Уулзалтын эхэнд Зөвлөх инженер Н.Адилбиш “Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт”-ын ажлын явцын талаархи энэхүү танилцуулга хэлэлцүүлэг нь Захиалагчид ажлын явцаа товч тайлагнаж, дахин үнэлгээ, бүртгэлтэй холбоотой асуудлаар Яамны зүгээс холбогдох чиглэл, шийдвэр авах зорилготойг дурдаад, дараах 2 хэсгээс бүрдэхийг онцоллоо. Үүнд:

Нэг. “Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт”-ын ажлын явцын тухай товч танилцуулга

Хоёр. Олон улс, улсын чанартай зам, замын байгууламжийн үнэлгээ, бүртгэлд авах хувилбаруудын талаар. Үндэслэл: Авто замын тухай хуулийн: *10.1.10.олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах, бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, үндсэн хөрөнгийн бүртгэлд оруулах, элэгдэл хорогдлыг тооцох, бүртгэлээс хасах ажлыг зохион байгуулах;*

Нэг.

1. Гэрээт ажлын явц бидний тооцож байгаагаар 85 орчим хувийн биелэлттэй байна. Нарийвчилсан графикийн дагуу ажлаа явуулж байгаа.
2. Зөвлөх инженерүүдээр ахлуулсан 3 зөвлөх баг улсын чанартай 12 мянга гаруй км зам, 300 гаруй гүүрт, орон нутгийн чанартай 1100 гаруй км замд газар дээр нь явж үзлэг тооллого хийж, видео бичлэг, фото зургийг нь замын паспортод цахимаар хавсаргаж байна.
3. Олон улс, улс, орон нутгийн чанартай замуудын бүртгэл, тооллогын ажил үндсэндээ дууссан. Одоо тодруулга, хяналтын ажил хийгдэж байна. Бид бүртгэл, тооллогын ажлыг 8 багц хүснэгт, 460 гаруй үзүүлэлтээр гаргасан.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

4. Авто замын паспорт, гүүрийн карт хөтлөх, маш их механик ажиллагаатай цаг хугацаа зардаг ажлын замын паспорт хөтлөх ажил 30 орчим хувьтай байна. Гүүрийн карт хөтлөх ажил 98%-тай байна. Тодруулга, зураг байршуулах ажил хийгдэж байна.
5. Олон улс, улсын чанартай замын координатуудыг тодорхой болгож, газрын зурагт оруулсан. Авто замын тухай хуулийн дагуу замын зурвас газрын өргөнийг оруулж байна. Бүх гүүрүүдийн байршлын координатуудыг оруулсан.
6. Олон улсын болон улсын чанартай авто замуудын чиглэлийн нэр, мөн тэдгээрийн доторх нийт замын нэр, уртыг шинэчлэн тогтоох жагсаалт, улсын чанартай авто замуудын эхлэл ба төгсгөлийн цэгийн тодорхойлолт батлах Авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалын төслийг Авто замын тухай хуулийн шинэчлэн найруулсан хуультай уялдуулан боловсруулж ЗТХЯ-нд хүргүүлсэн.
7. Орон нутгийн чанартай зам, гүүрүүдийн жагсаалтыг аймаг, сум бүрээр гаргаад, холбогдох аймгийн замыг сайн мэдэх хүмүүстэй хамтран нягталж байна.
8. Монгол улсын Авто замын сүлжээний талаархи томсгосон тоон мэдээллийг гаргаад одоо нягталж байна.

Хоёр.

1. Олон улсын болон улсын чанартай авто зам, гүүрүүдэд орлуулалтын аргаар дахин үнэлгээ хийсэн.
2. ЗТХЯ-нд цахимаар байгаа бүртгэлийн дүнгийн хүснэгтийг авч нарийвчилсан судалгаа хийгээд, замын хэсгүүдийн байршил, хуваалт ойлгомжгүй, зарим зам гүүрүүдийн өртөг үнэ үндэслэл муутай байсан учраас бид дахин шинэчилсэн үнэлгээ хийх нь зөв юм байна гэсэн дүгнэлтэд хүрсэн юм.
3. Шинэчилсэн үнэлгээг хийхдээ Зам, гүүрийн уртын жишиг үнийг баталсан Засгийн газрын 2010 оны 336-р тогтоолыг үндэслэл болгов. Үүнээс өөр, яам, Засгийн газрын төвшингийн шийдвэр гараагүй юм билээ.
4. Үндсэн хөрөнгийн бүртгэлд авах үнэлгээг гаргахдаа ЗТХ-ийн сайдын тушаалаар батлагдсан 2010 оноос хойшхи үнийн индекс, тухайн зам, гүүрийн насжилт, ашиглалтын өнөөгийн байдал, 1998 оны оноос хойш жил бүр тухайн зам, гүүрт зарцуулсан засвар, арчлалтын хөрөнгийн хэмжээг харгалзан тооцов.
5. Мөн зам, гүүрийн бүрэн сэргээн засах элэгдлийг тооцон гаргав. Үүнийг 2009 онд мөрдөж байсан аргачлалаар бодсон болно. Зам, гүүрийн өртгийг анхны балансын үнээс элэгдэл байгуулж өнөөгийн бодит өртгийг гаргах нь ихээхэн учир дутагдалтай болох нь харагдлаа. Яагаад гэвэл одоо ашиглагдаж байгаа өртөг, зардлаа аль хэдийн нөхчихсэн зарим зам, гүүрүүд хэвийн ашиглагдаж үүргээ гүйцэтгэж байна. Тухайлбал: Бүдүүний гүүр, Сайханы гүүр, Өвөрхангай чиглэлийн зам, Дархан чиглэлийн зам г.м. Зарим зам, гүүрүүд өртгөө нөхөж дуусаагүй хэрнээ эвдэрч, ашиглалтын шаардлага хангахгүй болсон байна. Тухайлбал: Ээвийн гүүр, Тэрхийн гүүр, Өндөрхаан чиглэлийн зам г.м
6. Зөвлөхүүд, 2016 оны жилийн эцсийн байдлаар Олон улс, улсын чанартай авто замын /6.0 м-с доош урттай гүүр болон бусад бүх замын байгууламжууд орсон/ нийт үнэ 3,478,597,2 сая төгрөг, 6.0м-с дээш урттай гүүрүүдийн нийт үнэ 269,191.1 сая төгрөг, бүгд 3,747,718.2 төгрөгийн зам, гүүрийг төрийн нийтийн өмч болгон ЗТХЯ-ны үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд авах нь зүйтэй байна гэсэн урьдчилсан тооцоо гаргаад байна.

Яамнаас дэмжлэг, чиглэл авах, шийдвэрлүүлэх асуудлууд:

1. Зөвлөхүүдийн санал болгож байгаа Ашиглалтын байдлыг харгалзан бүртгэлд авах бодит үнэлгээг гаргасан аргачлалыг дэмжих

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

2. Цахим мэдээллийн сан зайлшгүй хэрэгтэй байна. Бидний хийж байгаа энэ ажил нүсэр, цаашид үргэлжлүүлэн жил бүр шинэчлэхэд тодорхой мэдлэг дадлага, мэргэшсэн байдал шаардана. Өөрөөр хэлбэл хүмүүсийг мэргэшүүлж, тогтмол, өөрчлөлтгүйгээр ажиллуулах шаардлагатай болно. Харин бүртгэл, мэдээллийн сангийн программтай болвол энэ ажил ихээхэн хөнгөрч, авто замын сүлжээний хөгжлийн менежмент шинэ шатанд гарна. Зөвлөхүүд манайтай ижил төстэй гараатай, нөхцөлтэй ОХУ-ын “ИндорРоуд” программыг санал болгож Замын бодлогын газарт танилцуулаад байгаа. Тийм учраас энэ талаар бидэнд наадмаас өмнө тодорхой чиглэл өгөх хэрэгтэй байна.
3. Олон улсын болон улсын чанартай авто замуудын чиглэлийн нэр, мөн тэдгээрийн доторх нийт замын нэр, урт, эхлэл төгсгөлийн цэгийг шинэчлэн тогтоох жагсаалт батлах ЗТХ-ийн сайдын тушаалыг яаравчлан гаргах
4. “Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах журам”-ийн төслийг 2016 оны 5-р сард яаманд хүргүүлсэн байгаа. Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотойгоор энэ журмыг гаргах талаар тодорхой чиглэл, шийдвэр өгөх

Хэлэлцсэн асуудал:

Танилцуулгын дараа холбогдох хүмүүс Зөвлөхүүдээс асуулт асууж хариулт авлаа.

Д.Гэрэлням: Энэ нөгөө МСРС-гийн хийж байгаа ажилтай уялдаж хийгдэж байгаа юу?

Р.Балжир: Тэрэнтэй ямар ч хамаа байхгүй.

Н.Адилбиш: Тэндээс ширхэг ч зүйл аваагүй. Харин бидний өгөгдлүүд тэр ажлын суурь болох учиртай.

Ж.Сэрээтэр: Би үүн дээр нэг ийм ойлголттой байгаа ш дээ, Адилбиш гуай. Би ажил аваад бүх ажил хийж байгаа зөвлөхүүдтэй уулзсан. Тэгэхэд МСРС та 2 бол хамт байсан.

Н.Адилбиш: Тэгсэн.

Ж.Сэрээтэр: Тэгэхэд бидний ажил бол уялдаа холбоотой гэдгийг 2-уулаа нэг амаар хэлж байсан. Тэгэхээр би ойлгохдоо бол Орон зайн мэдээллийн вэб апплейкшн бий болгох хөгжүүлэх гэдэг ажлыг саяхан Яамны шинжлэх ухаан техникийн зөвлөлөөр хэлэлцээд энэ дэмжигдсэн. Тэгэхэд энэ ажил болвол таны санал болгоод байгаа энэ “ИндорРоуд” программ бий болгоно гэдэг биш вэб апплейкшн дээр таны энэ үзүүлэлтүүд тэнд очиж зоогдоод тэр вэб апплейкшн цаашдаа хөгжигдөөд тэгээд энд бол мэдээллийн сан үүсээд ингээд явна гэж ойлгож байгаа ш дээ. Анхнаасаа бол би тийм ойлголт авч асуусан. Та 2-г надтай уулзсан уулзалтаас тийм ойлголттой байсан. Би одоо ч тийм хүлээлтэй байгаа. Тийм учраас ажил хүлээж авахдаа тийм л шаардлага тавина.

Н.Адилбиш: Энэ дээр би нэг тайлбар хэлье. Вэб апплейкшнын хувьд яамны зөвшөөрлөөр биднээс гаргаж байгаа мэдээллийг оруулж байж тэр вэб апплейкшн чинь өнөөдөр ажил болно. Вэб апплейкшн программ 2 чинь тэс өөр юм шүү дээ.

Ж.Сэрээтэр: Программ гэж яадаг юм?

Р.Балжир: Бидний санал болгож байгаа программ нь 1-рт бидний хийж байгаа бүх юмыг дараа нь яаманд хүлээлгээд өгөхөөр яамны хүмүүс сервер дээрээ суулгачихаад бүх замынхаа мэдээллийг тогтмол өөрчлөлт шинэчлэлт хийж оруулаад, заримыг хасаад ингээд хийж байдаг тийм программ. 2-рт энэ программыг ашигласнаар дараа нь бүх замынхаа өнөөгийн техникийн байдлыг хянаж чаддаг. Тэгээд дээрээс нь энэ программыг ашиглан

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

засвар арчлалтынхаа зургуудыг хийчихдэг ийм программ юм. Энэ цэвэр бүртгэл мэдээлийн программ.

Ж.Сэрээтэр: Би анх энийг ярихдаа хэлсэн ш дээ. Орон зайн мэдээллийн вэб апплейкшн бий болгох хөгжүүлэх гэдэг ажлыг МСРС компани хийж байсан. Хүлээж авахад энэ ажил яригдаж байсан. Орон зайн мэдээллийн шинжлэх ухааны академич Амарсанаа гэдэг хүн ирээд, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Минжбадам, зэрэг замын мэргэжлийн 2 ч хүн байсан цаашдаа бол энэ паспорт, карт гараад ирэхээр мэдээллүүдийг нэмж оруулаад хөгжүүлэлт нь байнга хийгдэж байх юмаа гэдэг, ийм байдлаар тэр хурал даар яригдаад хурлын шийдвэр тийм байдлаар гарчихсан байгаа юм. Тэгэхээр хүлээлт бол юу байна гэхээр энэ ингээд баталгаажуулах гараад ирэхээр нөгөө орон зайн мэдээллийн сан бий болгох хөгжүүлэх энэ ажил дээр энэ ажил зайлшгүй уялдаж холбогдож байгаа юм. Өнгөрсөн жилийн оны сүүлээр энэ 3 ажлыг уялдуулах ажлын хэсэг Доржханд даргаар ахлуулаад байгуулагдаад энэ чинь бас яригдсан ш дээ. За ингээд нилээд ярих гэхээр учраа олддоггүй тэгээд сүүлд нь тус тусд нь яриад ямар ч байсан уялдах юм байна аа гэдэг ойлголт яам хүлээлттэй байгаа.

Н.Адилбиш: Вэб апплейкшний редакцын ажлын хэсгийн ахлагч нь би өөрөө. Одоо МСРС-ийн хийж байгаа. Вэб апплейкшн гэдэг нь одоо бидний энэ мэдээллийг оруулаад иж бүрэн болно. Бидэнд байгаа мэдээлэл бараг эцсийн байдлаар болсон. Тэнд бол ерөөсөө асуудал байхгүй. Вэб апплейкшн 3 түвшинд хэрэглэгдэнэ. 1-рт хэрэглэгчийн та бидний түвшинд, 2-т нь зам хариуцагчийн, 3-нь яамны түвшинд. Тэр бол зүгээр гар утсан дээр суулгаад юмнуудаа харж байх зорилготой л жирийн аппликейшн.

Р.Балжир: Энд нэг ийм нарийн юм байгаа байхгүй юу. Таны яриад байгаа Вэб апплейкшн бол хуучин тоон мэдээлэл дээр хийгдчихсэн гэсэн үг. Бидний хийсэн зүйл газар дээр яваад нарийн хэмжилтээр гаргаад ирсэн учраас бидний юм бол яг таг бодит үнэн зүйл. Тэгэхээр энэ дээр суурилж байж тэр вэб апплейкшн чинь зөв апплейкшн, хэрэгцээтэй апплейкшн болох ёстой. Тэрнээс одоо МСРС-н хийж байгаа аппликейшн энэтэй уялдахгүй байгаа. Манай ажлыг дууссаны дараа оруулах юм бол вэб апплейкшн болно.

Н.Адилбиш: Сэрээтэр даргаа нэг юм хэлье. Вэб апплейкшний редакцын ажлын хэсгийн дарга би гишүүд нь Загдраднаа, Хосгэрэл нар. Бид 3 дунд шатныхан нь тайланг үзээд энэ вэб апплейкшн хийж байгаа зарчим бол зөв юм байна гэсэн дүгнэлт гаргаж өгсөн. Тэгээд сонссон чинь бүр Яамны шинжлэх ухаан техникийн зөвлөлөөр ороод дэмжигдээд эцсийн шийдвэр гарчихсан бололтой юм. Би эцсийн шатны тайлан гэсэн юм хараагүй шүү. Бид нар, дунд шатны тайланд редакци хийсэн. Сэрээтэр даргаа дашрамд хэлэхэд, Редакцийн дүгнэлтэд одоо энэ хийж байгаа тооллого, бүртгэлийн ажлын мэдээллийг оруулах нь зүйтэй гэж зөвлөсөн байгаа. За нөгөө орон зайн мэдээллийн сангийн юм ярьж байна. Орон зайн мэдээллийн сангийн юмыг бол би бүр эхнээс нь дэмжээгүй. Монгол улс авто замаа тооллоод бүртгээд бүртгэл гараагүй байж байхад, орон зайн мэдээллийн сан гэж хаанаас, ямар тоо авч хийх гээд байгааг ойлгоогүй. Сэрээтэр даргаа энэ бол танаас өмнө хийгдсэн асуудал, тань дээр баахан юм яригдсан болохоос биш. Би тэнд байгаа координатуудын ихэнхи нь худлаа гэж мөрий тавиад ч алдахгүй. Яагаад гэвэл бид нар шиг тэр нөхдүүд газар дээр gps барьж явж хэмжээгүй.

Ж.Сэрээтэр: Тэрэн дээр бол ийм юм ярьдаг юм байна лээ ш дээ. 3-уулаа саланги бол ийм л юм ярицгаадаг. Яг нүүр нүүрээ харахаар бол аваа биз дээ өгөө биз дээ гэхээр үгүйсгэж чаддаггүй биз дээ.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Н.Адилбиш: Тэр Эрдэнэчимэг доктортой зэрэгцэж сууж байгаад, чиний наад юм чинь худлаа шүү гэхэд, чи Доржханд даргатай хуйвалдаж ийм ажил хийж байгаа ш дээ гэсэн маргаан болоод дууссаныг хуралд оролцсон бүх хүмүүс сонссон доо.

М.Угтахбаяр: Адилаа даргаа, таны энэ мэдээллүүд МСРС-н вэб апплейкшнд ороход ямарваа нэг формат энэ тэр нь зөрөхгүй байвал асуудал байхгүй ш дээ. За тэгээд “ИндорРоуд” программ зайлшгүй шаардлагатай гээд байгаа бол ярих ёстой асуудал. Замын бүртгэлийн программ биз дээ.

Н.Адилбиш: Яамны зүгээс энэ бүх мэдээллээ МСРС-д өг гэдэг шийдвэр өгөө бол бид нар ав л гэж хэлнэ. Бидний мэдээллийг ямар форматад оруулах нь бидний мэдэх зүйл биш. Манай ажлын даалгаварт Вэб апплейкшнд мэдээллээ оруулах зүйл байхгүй.

Р.Балжир: Батсайхан биднээс өгөгдлүүдийг авч, тэр бүх мэдээллээ эцсийн болгох ёстой байхгүй юу.

Ж.Сэрээтэр: Би ойлгохдоо та нар бол уялдаатай мэдээллээ өгч авнаа гэсэн ойлголттой байгаа ш дээ.

Н.Адилбиш: Тиймээ, Харин манай гэрээн дээр, яамны шийдвэргүйгээр ямар ч мэдээллийг гадагшаа өгөхгүй заалт бий. Яамнаас шийдвэр гарлаа бол өгөхөд бэлэн байна.

Ж.Сэрээтэр: Яамнаас дэмжлэг авч шийдвэрлүүлэх асуудлын 1-рт: Зөвлөхүүдийн санал болгож байгаа Ашиглалтын байдлыг харгалзан бүртгэлд авах бодит үнэлгээг гаргасан аргачлалыг дэмжих гэсэн байна. Яг энэ аргачлалаар явах нь зөв ч юм уу буруу ч юм уу. Зам, гүүрт элэгдэл байгуулахаар хасах дүн гарчихаад байна гээд байна ш дээ.

Н.Адилбиш: Энд 3 хувилбар яриад байна. 1. Оруулалтын аргаар үнэлсэн дахин үнэлгээг авах уу?, 2. Үнийн индекс тооцсон, засвар арчлалтанд зарсан хөрөнгөө дээр нь нэмсэн бодит үнэлгээг авах уу? 3. Эсвэл ерөөсөө элэгдэл байгуулсан дүнгээ авах уу гэсэн ийм л асуудал байгаа.

Ж.Сэрээтэр: Үүнийг бодитоор сайн ярилцаж цаасан дээр буулгаж, судлаж үзэхгүй бол, шууд хийсвэр байдлаар тэгнэ, ингэнэ гэх боломжгүй юм байна.

М.Угтахбаяр: Наадах тэр төрийн өмчийн хороо, өмч хөрөнгө бүртгэдэг газрууд мэдэх байх.

Н.Адилбиш: Яамаараа дамжуулж харилцахгүй бол болохгүй байхаа.

Ж.Сэрээтэр: Энэ нь өмч хөрөнгийн үнэлгээтэй холбоотой асуудал учраас хөрөнгө оруулалт үйлдвэрлэлийн хэлтсээс бичиг явуулаад холбогдох газраас санал авмаар байна. Тэгээд тэр гарсан саналыг үзээд эд нарын боловсруулсан юмыг үзээд тэгээд ийм юм байна гэдэг, энэ аргачлалыг авах зүйтэй юм аа гэдэг, үгүй бол холимог байдлаар хэрэглэх нь зүйтэй гэдэг саналаа гаргаад тийшээ явуулаад, санал авч байж хэлэлцүүлэхгүй бол энэ их маргаантай юм байна шүү.

Ө.Одгэрэл: Төрийн өмчийн газарт, нарийн бүртгэл байдаггүй ч байж магадгүй. Өнөөдрийн хурлаас тэмдэглэл гаргаад, ийм байна, ингэж хэлэлцлээ гэж танилцуулаад аль үнэлгээ, аргачлалаар үндсэн хөрөнгийн бүртгэлд авах талаар чиглэл авах нь зүйтэй байх.

Ж.Сэрээтэр: Тиймээ, яагаад тэгэж байна вэ гэхээр чиг үүргийнхээ хүрээнд Сангийн яамны харьяанд төрийн өмчийн Бодлого зохицуулалтын газар байгаа.

Г.Алтангэрэл: Гол нь элэгдэл байгуулаад гарсан дүн нь манай яамны хөрөнгө оруулалтын балансын дүнтэй нилээн ойр очиж байна. Харин 3.4 их наяд төгрөг гэдэг нь арай өөр зүйл,

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

үүнийг дагаад Засгийн газрын шийдвэр гарах учраас яалтчгүй төрийн өмчийн хороогоор оруулж танилцуулагдах ёстой байх.

Р.Балжир: Тийм л дээ. Гэхдээ элэгдэл байгуулаад үнэгүй болчихсон мөртлөө ашиглаж байгаа замыг та нар яах юм? Хаячих юм уу?

Г.Алтангэрэл: Үгүй яахав, дахиж үнэлээд байгаа ш дээ. Тэрнээс чинь гадна дуусаагүй барилга байгаа, бүүр дээр үеийн юмнууд ч байгаа.

Н.Адилбиш: 2016 оны жилийн эцсийн байдлаархи бүх зүйлийг оруулсан дүн. Тооллого аливаа оны жилийн эцсээр хийдэг шүү дээ.

Х.Гантөмөр: Баригдаж байгаа барилгууд байгааг бид on going гээд л хаясан.

Г.Алтангэрэл: Зарим объектуудыг үзсэн нь дээр байхаа. Жишээлбэл Энгельсийн гүүр манай дээр яваад байдаг юм, нийслэлийг ав гээд ерөөсөө авдаггүй.

Н.Адилбиш: Бидний мэдэхгүй, мэдэх боломжгүй олон зүйл байгаа, одоо яаманд байгаа бүртгэл тун ойлгомжгүй, үндэслэл муутай байгаа шүү дээ. Бид зам, гүүрийн хөдөлгөөний шийдвэрийг төсөл гаргаж өгнө.

Р.Балжир: Тэгвэл та нар эхлээд наад далбагар цаасыг сайн хянаж өгөх ёстой юм байна ш дээ бид нарт

М.Угтахбаяр: Та түүрэн 88 мянган км орон нутгийн зам байна гэсэн ш дээ. Аймаг доторхи хатуу хучилттай замууд орсон уу?

Н.Адилбиш: Орсон. Тухайлбал, Төв аймаг, аймгийн төвийн доторхи битгий хэл сумын төвийн доторхи 100, 200 метр замууд орсон.

М.Угтахбаяр: Тусгай зориулалттай замын хувьд бол журам боловсруулж Засгийн газраар батлуулсны дараа гараад ирнэ.

Н.Адилбиш: Тусгай зориулалтын замыг яг үнэндээ бид ойлгохгүй байгаа.

Р.Балжир: Ийм замыг тусгай зориулалтын гэдэг гэсэн шийд өгөх хэрэгтэй байна.

М.Угтахбаяр: Тэр журам энэ тэр гарч байж болох байхаа.

Р.Балжир: Одоо бид нар журам энэ тэр гараагүй байхад тайландаа бид нар оруулахгүй явчих уу?

Ө.Одгэрэл: Хөшөөтийн уурхайн зам чинь орон нутгийн замд орж байгаа юм уу?

Н.Адилбиш: Ороогүй.

Ө.Одгэрэл: Одоохондоо орон нутгийн замдаа оруулж бүртгээд дараа нь журам гарахаар шилжүүлчихнэ биз дээ. Тэр чинь хучилттай зам биз дээ. Хучилттай замын км нэмэгдэж байвал сайн биз дээ.

Р.Балжир: Тэр зөв.

Н.Адилбиш: Одгэрэлийн ярьж байгаа зөв шүү. Тэр чинь 305 км хучилттай зам шүү дээ.

Р.Балжир: Бид нарт өгөх чиглэлдээ заагаад өгчих. Бид нар тэрүүгээр чинь хийчихье.

Ж.Сэрээтэр: Сайдын тушаалын төсөл Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар дээр явж байгаа юм байна ш дээ.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Р.Балжир: Тийм. Хавсралттайгаа цуг.

Ж.Сэрээтэр: Ер нь бол ажил хүлээлгэж өгөхдөө яригдаад байгаа эдгээр журамуудыг бас боловсруулж өгөөч ээ гэж хүсэх гээд байна.

Н.Адилбиш: Тэр чинь ч бидний хийдэг ажил биш л дээ, Сэрээтэр даргаа. Ажлын даалгаварт ч байхгүй. Харин би гэхэд Авто замын шинэчилсэн хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар 8 журмын төслийн ажлын хэсэгт байгаа.

Ө.Одгэрэл: Эхлэл төгсгөлийн цэгтэй холбоотой юм бол гарч байгаа тийм ээ.

Р.Балжир: Тийм. Гарч байгаа

Ө.Одгэрэл: Энэ нь дээр замын дугаарлалтын асуудлууд хуучнаараа явах уу? Шинээр зам нэмэгдвэл тэр нэмэгдээд л г.м.

Н.Адилбиш: Тийм. Одоо хүчин төгөлдөр байгаа 33 замын 2 замд өөрчлөлт орж байгаа нэг нь Дундговь-Өмнөговийн зам, нөгөөх нь Зуунмод- Өндөрдовны зам гэж байсныг цааш нь явуулаад Налайх-Чойрын замтай холбож байгаа 28,2 км А25 гэх зам. Ийм л 2 өөрчлөлт байгаа.

М.Угтахбаяр: Код бол өөрчлөгдөхгүй болж таарлаа.

Р.Балжир: Тийм. Код бол хэвээрээ.

Н.Адилбиш: Зөвлөхүүд Яам, төвийн холбогдох ажилтнуудтай ярилцаж байгаад шинээр 9 чиглэл нэмэх сайдын тушаалын төслийг оруулсан байгаа.

Ц.Хосгэрэл: Сайдын тушаалыг яаралтай гаргая гэж байгаа ш дээ. Эхлэл, төгсгөлийн цэгийг батлаж өгөхөөс гадна координатыг бас яг батлаж өгөх шаардлагатай болоод байгаа. Тэр тушаалыг шууд гаргачих гэхээр шинээр нэмэгдэж байгаа 9 чиглэлийн маань координат байхгүй байгаа ш дээ. Тэгэхээр одоо энэ тушаалыг гаргаж болохгүй болоод байна.

Р.Балжир: Хэрвээ энэ 9 чиглэлийг бүрэн байдлаар нэмж оруулах юм бол тодорхой хэмжээний зардал мөнгө гаргана. Энэ асуудлыг шийдээд өгвөл бид хийхэд бэлэн.

Ц.Хосгэрэл: Одоо ингээд, жишээлбэл сайдын тушаалын төсөл бид нарт ирчихсэн байгаа тэгэхээр 32 замынхаа нэршлийг нь, координат нь баталгаажуулсан тушаал гаргаж болж байна. Харин 9 замын координат байхгүй байгаа дахин тушаал гаргах болоод байгаа юм.

Р.Балжир: Үүнийг ийм байдлаар шийдэх ньзүйтэй. Чиглэлээ 41-ээрээ батлаад өгчихгүй юу. Харин эхлэл, төгсгөлөө, одоо байгаа 32 замаараа батлаад өгчих, харин үлдсэн 9 чиглэлийн өгөгдлүүдийг бид нар газар дээр нь дахиад шинээр хийж ирсний дараа дахиад оруулчихаж болно.

Н.Сугаржав: Балжир инженерийн хэлж байгаар 32-оороо батлаад яваад ирэхээр нэмэлт гээд оруулчихаж болно. Асуудал байхгүй.

Г.Алтангэрэл: 2009 оны дахин үнэлгээний аргачлал чинь Засгийн газраар орж Их хурлаар батлагдсан юм. Би өөрөө аргачлалыг боловсруулсан юм. 2000 онынхоос өсгөөгүй 1,0 итгэлцүүрээр авсан, харин та бүхнийх урьд онуудыг нилээн өндөр тавиад өсгөсөн байна шүү дээ.

Н.Адилбиш: 2009 онд хийсэн дахин үнэлгээг ярьж байна уу тийм ээ. Бид нар яг тэр аргачлалыг дагуу дахин үнэлгээ хийсэн. Батлагдаагүй ч гэсэн та бүхний хийж байсан үнэлгээ бидэнд байгаа.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Г.Алтангэрэл: Ерөнхийдээ болвол 2009 хүртэлхийг 1,0 коэф авсан.

Н.Адилбиш: 2009 он хүртэл бол зөв л байх. 2010-2015 он хүртэл үндсэндээ бол валютын ханш бараг 2 дахин өссөн. Бүх барилгын материалын үнэ огцом өссөн. Тийм учраас үнийн өсөлтийн индекс тооцох нь зүйтэй гэж үзсэн. Үнийн индекс бодох аргачлал сайдын тушаалаар батлагдсан.

Г.Алтангэрэл: Одоо бид нар чинь ингээд төрийн өмчийн хороон дээр очоод танилцуулахаар ямар үндэслэлээр өсгөсөн гэнэ л дээ.

Н.Адилбиш: Алтангэрэлээ энд бол эрх зүйн үндэслэлгүй, санаанаасаа тавьсан, аргачлалгүй, томъёогүй тоо ганц ч байхгүй шүү.

Д.Бодьсайхан: Орон зайн мэдээллийн систем, паспортжуулалт, мэдээллийн сан үүсгэх талаар нэг ажлын хэсэг яваад 2, 3 жил болж байгаа юм байна лээ л дээ. Мэдээллийн программ хангамжийг бол МСРС хийсэн юм байна. Танайх бол паспортжуулалтын ажлыг бол хийж байгаа юм байна. Түүрүүн паспорт 30% гэж яриад байсан гэтэл одоо мэдээлэл 100%-тай гэж ярилаа л даа тэрийг би эсвэл буруу ойлгочихсон уу?

Н.Адилбиш: Авто замын паспортжуулалт гэдэг нь бол саяны яригдсан, яригдаагүй энэ бүх мэдээллийг батлагдсан маяганд оруулж байгаа ажил юм. Энэ ёстой маш хэцүү, механик ажиллагаа ихтэй зүйл л дээ. Үүнийг автоматжуулахын тэр программ гэдгийг чинь яриад байгаа байхгүй юу.

Д.Бодьсайхан: Тэр оросын программын тест хувилбар нь байгаа юу?

Н.Адилбиш: Байгаа. Бид нар нэг замыг /Тэрэлжийн/ бүтэн оруулаад өнгөрсөн оны 11 сард танилцуулга хийсэн байгаа.

Д.Бодьсайхан: Хамгийн сүүлд нэг л асуулт байна л даа. Navigation, мар янз бүрийн гар утасны апплейкешнүүд байна л даа. Энэ координатууд үнэхээр тэр программ руу оруулах боломжтой юу? Манайд байгаанууд ерөнхийдөө их алдаатай байдаг ш дээ. Яг зам руу орлоо гэхэд зам ч юм шиг биш ч юм шиг өөр тийшээ яваад байдаг даа. Тэгэхээр энэ координатуудыг Navigation компаниудад өгөх эрх зүйн байдаг юм уу?

Н.Адилбиш: Та их зөв зүйл хөндөж ярилаа. Надад гэхэд л хэд хэдэн программ байгаа, энэ програмууд бүгд зөрүүтэй. Жишээ нь Дөргөнөөс Сархайрханы гүүр чиглэлд тэр программ ашиглаад явахад бол төөрнө эсвэл шаварт сууна. ЗТХЯ-ны зөвшөөрөлгүйгээр элдэв бусын gps-г хийлгэхгүй байх ёстой. Зогсоох ёстой. Энэ бол цэвэр арилжааны юм болчихоод байгаа. Түүрүүн Сэрээтэр дарга хэллээ ш дээ координатыг өг гэвэл өглөө. Тэгээд тэр вэб апплейкешн оруулаад тэр бүх gps-нүүдийг цохих ёстой болж байна. ЗТХЯ-ны вэб апплейкешн биш хуурамч зүйл суулгаж яваад төөрвөл хохь нь л болно.

Д.Энхтуяа: Зөвлөхүүд та бүхний энэ хийсэн зүйл бол Авто замын салбарт хамгийн үнэн зөв гаргаж ирж байгаа мэдээлэл, маш чухал зүйл болж байна. Надад нэг асуулт байна. Та замын зурвасын хажуугийн координатуудыг бүгдийг нь гарлаа гэсэн, бид нар юу хийдэг бэ гэхээр замын шинэчлэлтийн ажил хийдэг. Бид хамгийн эхний тооцоо хийхэд бид нар замын зурвас газарт байгаа газар чөлөөлөлтийн асуудлыг ярьдаг. Тэгэхээр энэ зурвас газарт газар чөлөөлөхөөр гарсан тийм юм байна уу?

Н.Адилбиш: Зурвас газрыг бичлэгээс харж болно. Тэндээс л зөвшөөрөлтэй зөвшөөрөлгүй объектуудыг харж болох байх. Бичлэг бол 100-150м зурвас газрын мэдээллийг 135 градусын өнцөгөөр бичсэн байгаа. Тэндээс харна уу л гэхээс биш тийм юм байхгүй.

Р.Балжир: Ажлын даалгаварт газар чөлөөлөхтэй холбоотой асуудал байхгүй.

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

Д.Энхтуяа: Би сая координат гараад ирэхээр баярласан байхгүй юу. Бид нар чинь тэр замын зурвас газарт ийм зүйлийг зайлуулах, ийм газрыг чөлөөлүүлэх ажил гарах юм байна гээд, эсвэл энэ хууль зөрчөөд газар өгчихсөн юм байна гэдэг мэдэх л байна.

Р.Балжир: Энэ бичлэг чинь бол ноднин жилийн 8-р сарын 20-доор хийгдсэн байгаа одоо нөгөө программтай болж байж энэ нөхдүүд чинь сар болгон бичлэгээ оруулж мэдээлэл шинэчлэгдэх ёстой байхгүй юу. Жилийн дараа барилга баригдсан уу эсвэл нэг юм алга болчихсон уу? Энд бүгд тэндээс харагдаж байж тэрийг та нар тэгэж ашиглах ёстой.

Д.Энхтуяа: “ИндорРоуд” программын ач холбогдолыг сая ойлгохдоо засвар арчлалтанд жил болгон бид нар хөрөнгө тавидаг гэтэл чинь яг бид нар программаа хараад л ерөөсөө нэгдүгээрт засвар арчлалтын зургийн хөрөнгө гэж ч гаргах шаардлагагүй болох юм байна. Дээрээс нь зардлын тооцоо үнэн зөв гарч ирэх юм байна. Одоо бид нар Хархоринд 300сая төгрөг тавчихья, Хэнтийд нэг 500-г тавьчина гэдэг биш программаар гараад ирэхээр бодит харагдаад байгаа байхгүй юу. Программыг авах нь бол өндөр ач холбогдолтой, ашиглах нь зүйтэй. Дээрээс нь хэлж байгаа зүйл бол бүртгэл мэдээллийн алба байх ёстой. Бид нарын гаргасан алдаа бол 2007 онд төсвийн норм үнэлгээг боловсруулаад хаясан ажлын хэсэгтэй байа гэсэн санал зөвлөмжийг авалгүйгээр хаясан учраас бид 2007 оныхоо юмыг дөнгөж 2016 онд шинэчлэж хэвлэж байгаа байхгүй юу. 2007-н оны юм бол бид нар анхны юм хийсэн. Энэ бүхнийг цааш нь авч үзээд Сэрээтэр даргаа, ялангуяа танай хэлтсийнхэн энийг бас зөвлөмжиндөө оруулж гаргах ёстой юм байна шүү гэдгийг сая харлаа.

Х.Гантөмөр: Зурвас газартай байгаад ашиглаж чадахгүй юм байна лээ дээ. Жишээлбэл замын зурвас газар гээд төчнөөн м гэсэн мөртлөө Зам тээврийн яам нь биш сум орон нутаг нь мэддэг юм шүү дээ.

Н.Адилбиш: Та бүхнээс нэг асуугаадахья. Санал гэх үү дээ. Бүртгэл авах үнэлгээнд зураг төслийн үнэ ороогүй, хяналтын үнэлгээ ороогүй шүү. Нэгэнт одоо монгол улсын карманаас мөнгө гарчихсан. Үүнийг замууддаа яаж хуваахад маш төвөгтэй байна. Зураг төсвийн үнийн судалгаа Энхтуяад судалгаа байхыг үгүйсгэхгүй.

Д.Энхтуяа: Байхгүй.

Р.Балжир: Уг эдгээр зардал зам, гүүрийн үнэд нь шингэж байх ёстой л доо.

Д.Энхтуяа: Гарч байгаа мөнгө болгон орсон байх ёстой.

Н.Адилбиш: Замын өртөгтөө байх ёстой. Сэрээтэр даргаа тийм нэг зовлон байна.

Ж.Сэрээтэр: “ИндорРоуд” программыг их түлхүү яриад байна. Би бол үүнийг энэ ажлаас шал өөр асуудал байх гэж бодож байна.

Р.Балжир: Бид нар та нарт юм тулгаагүй. Бид нарын хийсэн юмыг та нар, яам цаашдаа олон арван жил хэрэглэхэд хэрэгтэй шүү гэж л хэлж байгаа. Үүнийг та нар захиалж аваад хийлгэнэ үү? Одоо бид нараас аваад тэр вэб апплейкешндээ оуулна уу тэр бол цэвэр та нарын асуудал. Тэрнээс бид нарын зүгээс ямар ч тулгалт байхгүй. Хийлгэчихвэл энд бүгд төгс төгөлдөр болох юмаа гэж хэлээд байгаа юм даа.

Ж.Сэрээтэр: Нилээд олон эргэлзээтэй, тодруулмаар асуудлууд их байна. Эцсийн тайлан хүртэл хугацаа байна. Эдгээрийг тайлах юм хийгээрэй. Судалгааны ажлууд бол их маргаантай үр дүн муутай, хөрөнгө оруулалт үйлдвэрлэлийн хэлтэс надад ийм үр дүн муутай судалгаа ажил хийх шаардлагатай гэдэг асуудлууд надад тавигддаг шүү. Тийм учраас надад энэ ажлын нилээн өгөөж үр дүнтэй болгох чиглэлд нь анхаарч ажиллаарай гэдэг хүсэлт байна. За тэр хөрөнгийн үнэлгээ аргачлалын гэсэн excel sheet гаргаж байна. За тэр

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

тайландаа аргачлал энэ тэрээ тусгаж өгөөрэй. Бодьсайхан бид 2 шиг шинэ хүмүүс хэдэн оны ямар гаргачлалаар хийгээд байгааг чинь мэдэхгүй ажлыг чинь бүрхэгдүүлэх, үгүйсгэх тийм байдал гаргаад байж магадгүй. Тийм учраас анхааралтай хандаж ийм юмнуудаа нилээн сайн хийгээрэй. Та бүхний хийж байгаа энэ ажил бол хэрэгтэй ажил, их үр дүнтэй ажил болж байгаа гэдгийн бол анх уулзаад л ойлгосон. Миний нэг өчүүхөн төдий шүүмжлэлтэй байр суурийн асуудал ярьж байгаа болвол энэ ажлыг үр дүнтэй болгох, судалгааны ажлыг үр өгөөжтэй болгочих юмсан гэсэндээ л тэр. Норм нормативийн сангийн чамгүй хөрөнгөөр хийж байгаа ажил, их шүүмжлэлтэй байдаг юм, би одоо нэг норм нормативийн сангийн хөрөнгийг ганцаараа захиран зарцуулаад байдаг юм шиг байгаа ч, тэр нэг 9 замын асуудал ярьж, хөрөнгө ярьж байна. Уучлаарай би бол чадахгүй шүү. Үүнийг Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдах зөвлөлийн гишүүд зөвшөлцөж баталдаг юм шүү. Тийм учраас зөв ойлгоорой. Энэ ажлын үр өгөөжийг нааштайгаар хүлээж байна. Яригдаж байгаа энэ маргаантай асуудлуудыг хурлынхаа тэмдэглэлд сайн тусгаарай. Замын чиглэлийн талаар тушаалын төсөл явж байгаа юм байна. Сайн үзэж харж байхгүй болвол хэзээ хойно нь Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлээд сайд шийдчихсэн байхад болохгүй байна гэдэг юмнууд зам дээр бол хэд хэдэн удаа гарч байгаа шүү.

Д.Энхтүяа: Тийм учраас та манай газартай холбоотой ажилмаар байгаа байхгүй юу.

Ж.Сэрээтэр: Өнөөдөр харин ёстой Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын олон хүмүүсийг хамруулсан уулзалт боллоо. Хөрөнгө оруулалт үйлдвэрлэлийн хэлтэсийнхэн өмчийн бүртгэлийн асуудал яриад байна ш дээ болж байна, болохгүй байна гээд. Одоо л цэгцлэж авахгүй бол болохгүй шүү Алтангэрэлээ. Тийм учраас энэ хурлын тэмдэглэл дээр би албан ёсоор хэлчихье одоо байгаа хөрөнгийн бүртгэлээ энэтэй уялдуулж аваад цаашаа явахгүй болвол түрүүн яриад байна ш дээ өмч хөрөнгө чинь шамшигдаж, алга болоод эзэнгүйдээд байх байдал үүсчих гээд байна шүү. Эцсийн тайлан дээр илүү их үр өгөөжтэй энэ маргаантай асуудлуудыг шийдсэн зөвлөмжүүд саналууд гарна байх гэж найдаж байна. Баярлалаа

Н.Адилбиш: Сэрээтэр даргаа энд маргаантай асуудал огт байхгүй. Маргаантай юм бол тэр 2 төсөлтэй уялдуулах гэдэг зүйл л байгаа байх. Бусад нь бол та бүгдээс гаргасан чиглэл, зөвлөмж, шийдвэрийг бид нар бол шууд хэрэгжүүлэх л үүрэгтэй. Гэхдээ өөрийнхөө санал бодлоо бол хэлнэ. Бид нар ажлаа танилцуулахаар тэр 2 төслийг ярьдаг юм. Үүнийг одоо болихыг хүсч байна. Тэр бидэнд хамаагүй юм ш дээ. Тэр яамны асуудал. Бидний ажил бол тооллого, бүртгэлийн ажил, Авто замын бүртгэл мэдээлийн сангийн үндсэн өгөгдөл бүрдүүлэх ажил. Үүнгүйгээр Монгол Үндэсний Авто замын сүлжээний ямар ч судалгаа, шинжилгээний ажил явахгүй нь ойлгомжтой. Та бүхэнд баярлалаа.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн. Зөвлөх инженер

Н.Адилбиш

Тэмдэглэлтэй танилцсан.

Ж.Сэрээтэр

Ө.Одгэрэл

Ж.Алтангэрэл

Н.Сугаржав

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

7/4/2017

“Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, замын паспорт, гүүрүүдийн карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт” ажлын танилцуулга

№	Хаанаас	Нэр	Албан тушаал	Гарын үсэг
1	Зам тээврийн хөгжлийн яам	Д.Эрэнбат	БТГ-ийн СХХ-ийн ахлах мэргэжилтэн	
2		М.Сүхбат	БТГ-ийн СХХ-ийн дарга	
3		О.Оюун	БТГ/СНХ ахлах мэргэжилтэн	
4		Э.Буюусайхан	БТГ-ийн мэргэжилтэн	
5		Н.Сүхбат	БТГ-ийн АЗБХЗГ ахлах мэргэжилтэн	
6		М.Хангал	БТГ-ийн ахлах мэргэжилтэн	
7		Т.Хангал	БТГ-ийн ахлах мэргэжилтэн	
8		Ц.Хангал	АЗБХЗГ мэргэжилтэн	
9		О.Оюун	БТГ-ийн мэргэжилтэн	
10		А.Хангал	АЗБХЗГ мэргэжилтэн	
11		Ч.Сүхбат	АЗБХЗГ мэргэжилтэн	
12		Э.Оюун	АЗБХЗГ-ийн ахлах мэргэжилтэн	
13				
14				
15				
16	Зөвлөхийн багийнхан	Р.Балжир		
17		Н.Адилбиш		
18		Х.Гантөмөр		
19		Золжаргал		
20		Эрдэнэжаргал		
21		Түвшин		

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



БҮЛЭГ 7

ЭЦСИЙН ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ

Эцсийн тайлангийн дүгнэлт, цаашид авах арга, хэмжээний санал

“Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлыг Авто замын нэгдсэн бүртгэл, мэдээлийн сангийн суурь судалгааны чиглэлээр гүйцэтгээд дараах дүгнэлт хийж, санал гаргаж байна. Үүнд:

1. Энэхүү тооллого, бүртгэлийн ажлын хүрээнд хийгдсэн бүх ажлууд, бий болгосон тоо баримтууд, бүртгэл, паспорт, картууд нь олон улсын болон улсын чанартай замын бүрэн мэдээлэл, үндэсний авто замын сүлжээний бусад замуудын үндсэн бүртгэл болсон тул, Авто замын хууль хэрэгжүүлэхтэй холбогдон гарч байгаа журмын дагуу, Авто замын салбарын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бий болгох
2. Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэлийн ажлыг хэтэрхий олон жилийн дараа хийж байгаагаас Авто замын бүртгэл, мэдээллийн санг баяжуулж чадахгүйд хүрсэн байна. Иймд Авто замын тооллогыг хууль тогтоомжид заасны дагуу 4 жил тутам, Монгол улсын үндэсний авто замын сүлжээг хамруулан хийж байх, жил бүр бүртгэлийг шинэчлэн хөдөлгөөн хийж, холбогдох байгууллагууд, зам хэрэглэгчдэд мэдээлж байх
3. Олон улс, улсын чанартай замуудын ашиглалтын байдал харилцан адилгүй байна. Энэ нь зам, гүүрийн барилгын чанар, авто замын засвар, арчлалтын хөрөнгийн хүрэлцээ, зам хариуцагчдын үйл ажиллагаатай шууд холбоотой юм. Нийт замын 78,6% нь ашиглалтын байдлын дунд ба дундаас доош үнэлгээтэй байна. Иймд авто замын барилга, засвар арчлалтын ажлын чанарыг сайжруулах, арчлалт засварын ажлыг тогтмолжуулах, нийт зам, гүүрийг мэргэшсэн байгууллага, хувийн компани, хувь хүмүүст хариуцуулан эзэнтэй болгож, зам хариуцагчдын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх
4. Авто замын салбарт одоо мөрдөгдөж байгаа журам, дүрмээр авто замын паспорт, гүүр хоолойн карт хөтлөх нь механик ажиллагаа ихтэй, ашиглахад ойлгомжгүй, ач холбогдол муутай, цаг үеэсээ хоцорсон байна. Иймд Авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүхэлд нь цахим программд оруулах хэрэгтэй, Зөвлөхүүд Монгол оронтой ижил, төстэй нөхцөлтэй, хөгжлийн гараа адилхан ОХУ-д хэрэглэдэг “Индорроуд” программыг санал болгож байна.
5. Авто замын салбарт бүртгэл мэдээллийн нэгдсэн сан, үнэн хэрэгтээ байхгүй байна. Энэ нь мэдээллийн санг тодорхой хугацаа зарж бий болгодог, бий болгосон сандаа тогтмол баяжуулалт, шинэчлэлт хийж байдаг мэргэшсэн баг, инженерийг тогтмол ажиллуулаагүйтэй холбоотой гэж үзэж байна. Авто замын тухай хууль анх гарсан 1998 оноос хойш 18 жилд, энэ ажлыг нийтдээ 8 инженер хариуцан ажиллажээ. Тэдний хамгийн урт хугацаагаар ажилласан нь 2-3 жил байжээ. Ийм хугацаанд мэдээллийн нэгдсэн санг бий болгож, зохих түвшинд хүргэн, тогтолцоо бий болгох боломжгүй. Бид “Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийх үндсэн хөрөнгийн бүртгэлд

авах” журмын төсөлд “Бүртгэл, мэдээлэл хариуцсан байгууллага-БМХБ” гэсэн институци оруулж өгсөн. Цаашид ямар ч Засгийн газрын үед тогтвортой ажиллах, энэ байгууллага /хэлтэс, баг/-ыг бий болгож, ажиллагсадыг нь мэргэшүүлж, бүх насаар нь ажиллуулах тогтолцоо бий болгох нь зүйтэй.

6. Авто замын тэмдэгжүүлэлт, ялангуяа км-ын заалтууд шаардлага хангахгүй байна. Улсын чанартай замын ХАБ-ын тэмдэгийн хэмжээг 900 мм хэмжээтэй болгох шаардлагатай болжээ. 700 мм-ийн хэмжээтэй тэмдэг хэт жижигдэж, манай уур амьсгалын нөхцөлд зураглал нь дорхноо бүдгэрч, тэр бүр арчаад, шинэчлээд байж чадахгүй учраас алсаас муу харагдаж байна. Алсаас тэмдэг, самбарууд сайн харагдахгүй байснаа, (орчин үеийн машин хурд ихтэйгээс) тэмдэг, заалтууд гэнэт өнгөрч үндсэн зорилгоо биелүүлж чадахгүйд хүрч байна. Авто замд мэдээллийн самбар бараг байхгүй байна. Байгаа км-ын тэмдэгүүдийн хоорондын зай зөрүүтэй, аль цэгээс тавигдсан нь ойлгомжгүй, баруун зүүн гар талд хольж тавьсан, тэмдэгийн өндөр, самбарын хэмжээ харилцан адилгүй, стандартын бус шрифтээр бичигдсэн г.м ноцтой зөрчил байгаа учраас Авто зам тэмдэгжүүлэх, иж бүрэн заавар боловсруулж мөрдөх.

1. Тайлангийн үр дүнд гарах шийдвэрийн тухай

Тайлан, ЗТХЯ-наас томилсон редакцийн ажлын хэсгээрхянагдсаны дараа Авто замын салбарын Шинжлэх, ухаан техникийн зөвлөлийн хурлаар орж хэлэлцэгдэнэ, дараа нь ЗТХЯ-ы шинжлэх ухаан техник, технологийн зөвлөлийн хурлаар орж дэмжигдсний дараа Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаал гарна.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН ТУШААЛ

Авто замын тооллого бүртгэл, мэдээллийн тухай.

Авто замын тухай хуулийн 27-р зүйл, “Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн гэрээт ажлын тайланг хэлэлцсэн ЗТХЯ-ны Шинжлэх ухаан техник, технологийн зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлыг гэрээний дагуу бүрэн хийж дуусгасан тул холбогдох тооцоог хийж, санхүүжүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга /Б.БАТ-ЭРДЭНЭ/-д даалгасугай.
2. Авто замын тухай хуулийн 10.1.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15.1,2 заалт, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.8.3 заалтыг үндэслэн тооцож гаргасан бодит өртөг бүхий, дээрх тайланд тусгагдсан зам, гүүрийг үндсэн хөрөнгийн бүртгэлд авахыг Бодлого, төлөвлөлтийн газар /.../-т даалгасугай.
3. Авто замын бодлогын хэрэгжүүлэлтийг зохицуулах газар /Д.Доржханд/-т даалгах нь:
 - 3.1 Олон улсын болон улсын чанартай, тусгай зориулалтын авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бий болгох, энэ санг тогтмол эрхлэн ажиллах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах, үүнтэй холбогдон гарах зардлыг 2018 оноос эхлэн Зам, тээврийн хөгжлийн сайдын багцын жил бүрийн төлөвлөгөөнд тусгах
 - 3.2 Авто замын тухай хуулийн 27.2 заалтын дагуу Олон улс, улсын болон тусгай зориулалтын авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн холбогдох мэдээллийг жил бүрийн тогтоосон хугацаанд авто зам эзэмшигчид хүргүүлж байх
 - 3.3 Монгол улсын авто замын сүлжээг нийтэд нь шинээр тэмдэгжүүлэх ажлыг улсын чанартай авто замуудын эхлэл, төгсгөлийн цэгийн шинэчлэн тогтоосон байршилтай нягт уялдуулан 2018 оны 3-р улирлаас эхлэн үе шаттайгаар гүйцэтгүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавьж, үр дүнг хагас жил тутамд танилцуулж байх
 - 3.4 Цаашид авто замын ТЭЗҮ болон нарийвчилсан зураг төслийг шинээр боловсруулахдаа тухайн замын эхлэлийн цэгийг улсын чанартай замын тодорхой цэг (...км+...)-с авахаар ажлын даалгаварт нь тусгаж байх

САЙД

БҮЛЭГ 8

**ТАЙЛАНТАЙ ХОЛБОО, БҮХИЙ АЛБАН БИЧИГ, ФОТО ЗУРАГ, БУСАД БАРИМТУУД
ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТУУД**

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт"-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: 6226 3168, Факс: (976-11) 312 315,
E-mail: info@mrt.gov.mn, http://www.mrt.gov.mn

2016. 05. 05 № 02/1920
танай _____-ны № _____-т

ЗАМЫН ЦАГДААГИЙН ГАЗАРТ

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол, Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Авто замын салбарын норматив баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр 2015-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор "Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт"-ын ажил хийгдэж байна.

Иймд дээрх ажлыг гүйцэтгэхээр Зам, тээврийн яамтай гэрээ байгуулан ажиллаж байгаа "Ар Ди Эй Си" ХХК-ийн ажилтан Зөвлөх инженерүүдэд улсын, орон нутгийн чанартай замуудын тооллого, бүртгэл, паспортжуулалттай холбоотой ажил үүргээ гүйцэтгэх, батлагдсан удирдамжийг хэрэгжүүлэхэд нь бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлж хамтран ажиллахыг хүсье.

Хувийг: "Ар Ди Эй Си" ХХК-д ✓

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
БӨГӨӨД ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГА, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Н.ГАНИБАЛ

082724

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт"-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: 6226 3168, Факс: (976-11) 312 315,
E-mail: info@mrt.gov.mn, http://www.mrt.gov.mn

2016.05.05 № 02/1921

танай _____-ны № _____-г

“ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВ” ТӨҮГ, УЛСЫН ЧАНАРТАЙ
АВТО ЗАМЫН ЗАСВАР АРЧЛАЛТ
ХАРИУЦАГЧ БАЙГУУЛЛАГУУДАД

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол, Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Авто замын салбарын норматив баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр 2015-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор “Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт”-ын ажил хийгдэж байна.

Иймд дээрх ажлыг гүйцэтгэхээр Зам, тээврийн яамтай гэрээ байгуулан ажиллаж байгаа “Ар Ди Эй Си” ХХК-ийн ажилтан Зөвлөх инженерүүдэд улсын, орон нутгийн чанартай замуудын тооллого, бүртгэл, паспортжуулалттай холбоотой Ажлын даалгаварт тусгагдсан мэдээллүүдийг саадгүй шуурхай гарган өгч, батлагдсан удирдамжийг хэрэгжүүлэхэд нь бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэхийг үүгээр мэдэгдэж байна.

Хувийг: “Ар Ди Эй Си” ХХК-д ✓

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
БӨГӨӨД ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГА, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Н.ГАНИБАЛ



082689

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт"-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



АР ДИ ЭЙ СИ ХХК

УЛААНБААТАР ХОТ ХУД, 17042
2-Р ХОРОО ЧИНГИСИЙН ӨРГӨН ЧӨЛӨӨ
ГУТАЛ ОФФИС 3 ДАВХАРТ 302 ТООТ
Утас, факс: 99110615, 99074526
email: rdac8888@gmail.com
2017-06-05 № 17

танай _____-ны № _____-г

[ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ-Д]

[Тушаалын төсөл хүргүүлэх тухай]

“Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт”-ын ажлыг гүйцэтгүүлэхээр Зам, тээврийн яамнаас зарласан сонгон шалгаруулалтад “Ар Ди Эй Си” ХХК шалгаран 2016 оны 3-р сарын 18-ны өдөр 85 тоот Зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх гэрээ, 2016 оны 5-р сарын 30-ны өдөр 133 тоот нэмэлт гэрээ байгуулсан юм.

Дээрх гэрээ болон ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 7-р сарын 28-ны 011 тоот Ажлын даалгаврын дагуу боловсруулалтын ажил хийгдэж байгаа бөгөөд 2017 оны 9-р сард Эцсийн тайланг хүлээлгэн өгөх юм.

Ажлын даалгаварт тусгасны дагуу Олон улсын болон улсын чанартай авто замуудын чиглэлийн нэр, мөн тэдгээрийн доторх нийт замын нэр, уртыг шинэчлэн тогтоох тухай ЗТХ-ийн сайдын тушаалын төслийг “Авто замын тухай” хуулийн шинэчилсэн найруулгатай нийцүүлэн боловсруулан, тус яамны болон ЗТХөгжлийн төвийн холбогдох ажилтнуудын саналыг тусган хүргүүлж байна.

Гэрээт ажлын эцсийн тайлан гаргах хугацаа ойртож байгааг харгалзан, асуудлыг шуурхай шийдвэрлэж өгнө үү.

Тоотын хавсралт: 20 хуудас

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



А.ЗОЛЖАРГАЛ

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



“АР ДИ ЭЙ СИ” ХХК -Д

**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: 6226 3168, Факс: (976-11) 312 315,
E-mail: info@mrt.gov.mn, http://www.mrt.gov.mn

2016.03.14 № 02/985

танай _____-ны № _____-т

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Зам, тээврийн яамнаас зарласан “Авто замын салбарт олон улсын стандарт нутагшуулах, үндэсний стандарт боловсруулах, эрдэм шинжилгээ судалгааны зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах” тендерийн “Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт” 12-р багц ажлыг 334 776 700 /гурван зуун гучин дөрвөн сая долоон зуун далан зургаан мянга долоон зуун/ төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн танай компанийн тендерийг “Хамгийн сайн үнэлэгдсэн” тендерээр шалгаруулж гэрээ байгуулах эрх олгох тухай үнэлгээний хорооны дүгнэлт гарсан байна.

Иймд тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна уу.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ



081378

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт"-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



АР ДИ ЭЙ СИ ХХК-Д

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: 6226 3168, Факс: (976-11) 312 315,
E-mail: info@mrt.gov.mn, http://www.mrt.gov.mn

2016.04.22 № 02/1669
танай 2016.04.12-ны № 03-16/15-Т

Урьдчилгаа төлбөрийн баталгаа
ирүүлэх тухай

Танай байгууллагаас ирүүлсэн албан бичигтэй танилцлаа. Хэдийгээр гэрээнд тусгайлан заагаагүй ч Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа үйлчилгээ худалдан авах хуулийн 44 дүгээр зүйлийн 2 дугаар заалтын дагуу урьдчилгаа төлбөрийн баталгааг заавал ирүүлэх шаардлагатай.

Харин гүйцэтгэлийн баталгаа ирүүлсэн тохиолдолд дээрх хуулийн 44 дүгээр зүйлийн 3 дугаар заалтын дагуу урьдчилгаа төлбөрийн баталгааны дүнд гүйцэтгэлийн баталгааг оруулан тооцож болно.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



Ж.БАТ-ЭРДЭНЭ

082354

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт"-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ЗАМЫН ЦАГДААГИЙН ГАЗАР

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Олимпын гудамж, Утас: 70112711, Факс: 70112711,
Web: www.trafficpolice.gov.mn,
E-mail: trafficpolice@police.gov.mn

2016.05.19 № 12/670
танай 2016.05.05-ны № 02/1920 -т

ЗАМ ТЭЭВРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
БӨГӨӨД ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГА, ХУУЛЬ ЭРХ
ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Н.ГАНИБАЛ ТАНАА

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалтын ажилд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан эрх, үүргийн хүрээнд хамтран ажиллахад татгалзах зүйлгүй.

Шаардлагатай мэдээлэл солилцох, хамтран ажиллах чиглэлийн талаар Замын хөдөлгөөний аюулгүй байдалын хэлтэс /д.х Б.Эрдэнэбат/-тэй урьдчилан зөвшилцөнө үү.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА


Ү.ЗОРИГТБААТАР



УХГ0102

05.19.16

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт"-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



АР ДИ ЭЙ СИ ХХК

17012 ХУД, УЛААНБААТАР ХОТ

Утас, факс: 70001242, 99074526

email: rdgc8888@gmail.com

2016.04.12 № 03-16/15

танай _____-ны № _____-т

ЗАМ ТЭЭВРИЙН ЯАМ

[Санхүүжилт хүсэх тухай.]

Манай “Ар Ди Эй Си” ХХК нь ЗТЯ-наас зарласан тендерт оролцон шалгарч 2016 оны 03-р сарын 18-ны өдөр “Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт хэрэгжүүлэлт хэрэгжүүлэлт” ажил гүйцэтгэхээр зөвлөх үйчилгээний гэрээ байгуулан ажилдаа ороод байна.

Гэрээний тусгай нөхцөлийн 6.4-н а-д заасан төлбөрийн хуваарийн дагуу санхүүжилт хүссэн албан тоот (2016 оны 3-р сарын 28-нд 03-16/14) болон нэхэмжлэх №5 Стратегийн бодлого, төлөвлөлт, хамтын ажиллагааны газрын Техник, технологи нормативын хэлтэс-т хүргүүлсэн. Иймд урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийг гэрээний заалтын дагуу яаралтай шийдвэрлэж, хээрийн хэмжилт болон тооллогын ажлаа эхлүүлэхэд тусална уу.


Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



А.ЗОЛЖАРГАЛ

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт"-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



АР ДИ ЭЙ СИ ХХК

17012 ХУД, УЛААНБААТАР ХОТ

Утас, факс: 70001242, 99074526

email: rdac8888@gmail.com

2016.04.20 № 05-16/20

ЗАМ ТЭЭВРИЙН ЯАМ-Д

танай _____-ны № _____-т

[Баримт бичгүүдийн төсөл хүргүүлэх тухай.]

“Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлыг гүйцэтгэхээр 2016 оны 3-р сарын 18 –ний өдөр ЗТЯ-тай байгуулсан №85 тоот гэрээний дагуу манай компани үйл ажиллагаагаа эхлээд эдүгээ 1 сар өнгөрч байна.

Бид дээрх ажлыг гүйцэтгэх бэлтгэл ажлын хүрээнд боловсруулсан дараах баримт бичгүүдийн төслийг хүргүүлж байна.

1. “Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын даалгаврын За-д заагдсан Сангийн сайд, Зам, тээврийн сайдын хамтарсан “Авто зам, замын байгууламжийг тоолж, бүртгэл хөтлөн паспортжуулах, үл хөдлөх үндсэн хөрөнгийн бүртгэлд авах” журмын төсөл
2. Гэрээ, ажлын даалгаврыг хэрэгжүүлэх зорилго бүхий “Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл, үзлэг, хэмжилтийг газар дээр нь гүйцэтгэх удирдамж”-ийн төсөл
3. Орон нутгийн чанартай замуудын тооллого, бүртгэлийн чиглэлээр Зам, тээврийн сайдаас аймгуудын Засаг дарга нарт хүргүүлэх албан тоотын төсөл
4. Олон улс, Улсын чанартай замуудад Монгол улсын хилийн боомт хүртлэх замууд хамрагддаг, эдгээр замуудын тооллого, бүртгэл, паспортжуулалтын ажил гүйцэтгэхэд хилийн зурваст нэвтрэх зайлшгүй шаардлагатай болох учраас Хил хамгаалах ерөнхий газраас албан ёсны зөвшөөрөл хүссэн албан тоотын төсөл
5. Зам, тээврийн хөгжлийн төв, Улс, орон нутгийн чанартай зам хариуцагч байгууллагууд, Замын цагдаа, тээврийн байгууллагад хандсан, Ажлын даалгаварт тусгагдсан улс, орон нутгийн чанартай замуудын тооллого, бүртгэл, паспортжуулалттай холбоо мэдээллүүдийг саадгүй шуурхай гаргаж өгөх, батлагдсан удирдамжийг хэрэгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх чиглэл бүхий ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын албан тоотын төсөл
6. Багийн ахлагч Зөвлөх инженерүүдэд “Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлыг гүйцэтгэж байгааг илтгэсэн 2017 оны 6-р сарын 01 хүртэл хүчинтэй түр үнэмлэхийн төсөл

Эдгээр баримт бичгүүдийн төслийг хянан үзэж, яаралтай шийдвэрлэж өгнө үү.

Баримт бичгүүдийн төслийг хавсаргав. /27 хуудас/


Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



А.ЗОЛЖАРГАЛ

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт"-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



АР ДИ ЭЙ СИ ХХК
17012 ХУД, УЛААНБААТАР ХОТ
Утас, факс: 70001242, 99074526

email: rdac8888@gmail.com
2016.04.25 № 03-16/21

танай 2016.04.22-ы № 02/1669

ЗАМ ТЭЭВРИЙН ЯАМ-Д

[Гэрээнд заасан тайлангийн хугацааг
наашлуулах тухай.]

“Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлыг гүйцэтгэхээр 2016 оны 3-р сарын 18 –ний өдөр ЗТЯ-тай байгуулсан №85 тоот гэрээнд заасны дагуу урьдчилгаа төлбөр авах заалт гэрээний тусгай нөхцлийн 6.4-д тусгагдсан боловч, заавал урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргах шаардлагыг ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2016.04.22-ны №02/1669 тоотор бидэнд мэдэгдсэн.

Гэрээнд заагдаагүй баталгааг гаргахад ихээхэн чирэгдэлтэй, хугацаа шаардсан ажил болж байгаа учраас Зөвлөхийн зүгээс урьдчилгаа төлбөр авахаас татгалзаж байна. Үүнтэй уялдуулаад эхний болон дунд шатны тайлангийн хугацааг наашлуулж, тайлан бүрийн дараа санхүүжилтээ авч байхаар санал оруулж байгааг хүлээн авч шийдвэрлэж өгнө ҮҮ.

Гэрээний нэмэлт төслийг хавсаргав. /2 хуудас/


Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



А. ЗОЛЖАРГАЛ

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



АР ДИ ЭЙ СИ ХХК
17012 ХУД, УЛААНБААТАР ХОТ
Утас, факс: 70001242, 99074526
email: rdec8800@gmail.com
2016.06.07 № 08-53

ЗАМ ТЭЭВРИЙН ЯАМ-Д

Танай _____-ны № _____-ийн

[Тайлангийн хүргүүлэх тухай.]

“Ар Ди Эй Си” ХХК-ний ЗТЯ-тай 2016 оны 3-р сарын 18 –ний өдөр байгуулсан №85 тоот гэрээ, 2016 оны 5-р сарын 30–ний өдөр байгуулсан №133 тоот нэмэлт гэрээний дагуу “Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт”-ын зөвлөх үйлчилгээний ажлын эхний шатны тайланг 2% хүргүүлж байна.

Манай компани урьдчилгаа болон бусад төрлийн ямар нэгэн санхүүжилт аваагүй бөгөөд одоо улс, орон нутгийн чанартай замын тооллогонд яаралтай гарах шаардлагатай байгаа тул, холбогдох санхүүжилтийг шуурхай хийж өгнө үү.

Гэрээний дагуу санхүүжих эхний нэхэмжлэхийг хавсаргав.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



А.ЗОЛЖАРГАЛ

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт"-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



АР ДИ ЭЙ СИ ХХК

БГД 3-Р ХОРОО, ДУНД ГОЛЫН ГУДАМЖ
ДАЛАН ДАВАА ХХК БАЙР 502 ТООТ
УЛААНБААТАР ХОТ

Утас, факс: 70001242, 99074526

email: rdac8888@gmail.com

2016-07-04 № 03/04

танай _____-ны № _____-т

[ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАРТ]

[Зөвшөөрөл хүсэх тухай]

Авто замын салбарын норматив баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох төлөвлөгөөний 2015-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлыг манай компани ЗТЯ-тай 2016-3-18 –ны өдөр байгуулсан №85 тоот гэрээний дагуу гүйцэтгэж байна.

Монгол улсын Авто замын тухай хуулийн дагуу Олон улс, Улсын чанартай замуудад Монгол улсын хилийн боомт хүртлэх замууд хамрагддаг учраас эдгээр замуудын тооллого, бүртгэл, паспортжуулалтын ажил гүйцэтгэхэд манай компанийн Зөвлөх багийн бүрэлдэхүүн хилийн зурваст богино хугацаагаар ажиллах зайлшгүй шаардлага гарч байна.

Иймд Зам, тээврийн сайдын 2016.05.10-ны 01/1977 тоот бичгийг үндэслэн дээрх ажлыг гүйцэтгэж байгаа Зөвлөх инженерүүдийн багт 2016 оны 7-р сарын 15-наас 2016 оны 9-р сарын 15 хооронд хилийн зурваст ажиллах зөвшөөрөл олгож, туслалцаа үзүүлнэ үү.

Баг	Хилийн боомт
I	Улхан, Эрэнцав, Хавирга, Баянхошуу, Сүмбэр, Бичигт, Замын-Үүд, Ханги, Гашуунсухайт
II	Бургастай, Булган, Даян, Цагааннуур, Боршоо, Тэс, Арц суурь
III	Шивээхүрэн, Ханх, Бага Илэнх, Алтанбулаг,

Холбогдох баримт бичиг, материалыг хавсаргав. 46 хуудас.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



А.ЗОЛЖАРГАЛ

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт"-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



АР ДИ ЭЙ СИ ХХК

БГД З-Р ХӨРӨӨ, ДУИД ГОЛЫН ГУДАМЖ
ДАЛАН ДАВАА ХХК БАЙР 502 ТООТ
УЛААНБААТАР ХОТ

Утас, факс: 70001242, 99074526

email: rda8888@gmail.com

2016-07-22 № 03/64

танай _____-ны № _____-т

[ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАРТ]

[Зөвшөөрөл хүсэх тухай]

Манай компаний 2016 оны 07-р сарын 04-ны өдрийн 03/64 тоот зөвшөөрөл хүссэн албан тоотын дагуу 2016 оны 7 дугаар сар 06-ны өдрийн Дугаар 0636 тоот хилийн бүс, зурваст нэвтрэх зөвшөөрөл гарсан.

Зөвлөх инженерийн багын Уламбаяр овогтой Сандагпүрэв /ХЕ54041611/ эрүүл мэндийн нөхцөл байдлаас ажиллах боломжгүй болсон тул, Шагдарсүрэн овогтой Гантулга /ШГ61103113/, Төрхувьт овогтой Цогтбаяр /ГН91012615/ нар ажиллах зайлшгүй шаардлага гарч байна. Иймд хилийн зурваст ажиллах зөвшөөрлийг дахин олгож, бидний ажилд туслалцаа үзүүлнэ үү.

Баг	Хилийн боомт
1	Улхан, Эрэнцав, Хавирга, Баянхошуу, Сүмбэр, Бичигт, Замын-Үүд, Ханги, Гашуунсухайт

Холбогдох баримт бичиг, материалыг хавсаргав. 8 хуудас.


Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



ЗОЛЖАРГАЛ

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт"-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



АР ДИ ЭЙ СИ ХХК

17012 ХУД, УЛААНБААТАР ХОТ

Утас, факс: 70001242, 99074526

email: rdac8888@gmail.com

2016.11.29 № 05/13

танай _____-ны № _____-г

[ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ-Д]

[Тайлангийн хүргүүлэх тухай.]

“Ар Ди Эй Си” ХХК-ний ЗТЯ-тай 2016 оны 3-р сарын 18 –ний өдөр байгуулсан №85 тоот гэрээ, 2016 оны 5-р сарын 30–ний өдөр байгуулсан №133 тоот нэмэлт гэрээний дагуу “Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт”-ын зөвлөх үйлчилгээний ажлын дунд шатны тайланг 2% хүргүүлж байна.

Гэрээний дагуу санхүүжих дунд шатны тайлангийн нэхэмжлэхийг хавсаргав.

Хавсралт-10 боть, 1 CD
Нэхэмжлэх-№8

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



А.ЗОЛЖАРГАЛ

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



АР ДИ ЭЙ СИ ХХК

17012 ХУД, УЛААНБААТАР ХОТ
Утас, факс: 70001242, 99074526
email: rdac888@gmail.com
2016.05.13 № 03-16/39

танай _____-ны № _____-т

["БАГАНУУР-АЗЗА" ТӨХК-Д]

[Хамтран ажиллах тухай.]

Манай компани "Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт"-ийн ажлыг Зам, Тээврийн яамны захиалгаар гүйцэтгэж байна.

Энэ ажлын үр дүнд Монгол улсын нийт ард түмний өмч болох нийтийн зориулалттай авто зам, замын байгууламж нь албан ёсоор үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд орж, эдийн засгийн эргэлтэд орох нөхцөл бүрдэж, Авто зам, замын байгууламжийн бүртгэл мэдээллийн энгийн, ойлгомжтой, хэн ч ашиглаж болохуйц цахим сан бий болж, авто замын ашиглалт сайжрах болно.

Та бүхний гаргаж өгсөн мэдээлэлд үндэслэн аймаг бүрт байгаа орон нутгийн чанартай замуудын дэлгэрэнгүй бүртгэл гаргаж, аймаг, сум, баг, суурин газрын хоорондох замын чиглэл, зураглалыг тодорхой болгож, замын уртыг баталгаажуулна. Мөн орон нутагт яаралтай засах шаардлагатай замуудын жагсаалт, ажлын тоо хэмжээ гаргах.

Иймд аймаг, сум бүрийн авто замын сүлжээний зураглалыг багийн төв, суурин газрууд, бусад шаардлагатай цэгүүдийг оролцуулан 2016 оны 7-р сарын 05-ны дотор аймгийн захиргаатайгаа хамтран гаргаж, дээрх ажлыг гүйцэтгэж байгаа Зөвлөх инженерүүдийн багт албан ёсоор хүлээлгэн өгч, хамтран ажиллахыг хүсье. /Зөвлөхүүд аймаг бүрт очиж, хянан үзээд хүлээн авах болно./

Жич: Орон нутгийн замын сүлжээний тооллого, бүртгэлийн талаар Зам, тээврийн сайдын 2016 оны 05-р сарын 10-ны өдрийн 01/1978 тоот албан бичиг аймгуудын Засаг нарт очсон болно.

Холбогдох утасны дугаар болон хаяг: Монгол улсын Зөвлөх инженер Доржцэвээн овогтой Баасанхүү, утас 99114586, мэйл хаяг d_baasanhuu@yahoo.com /Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Төв/

Монгол улсын Зөвлөх инженер Нямжав овогтой Адилбиш, утас 99110615, мэйл хаяг adilbish2000@yahoo.com /Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан, Дундговь, Дорноговь, Өмнөговь, Говьсүмбэр/

Монгол улсын Зөвлөх инженер Равжир овогтой Балжир, утас 99097571, мэйл хаяг rbaljir@gmail.com /Хөвсгөл, Архангай, Өвөрхангай, Булган, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ /

Байршлын хаяг: Улаанбаатар, Баянгол дүүрэг, 3-р хороо, Дунд голын гудамж, Далан даваа ХХК байр, 502 тоот

Зам, Тээврийн яамны албан тоотыг хавсаргав-1%

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



А.ЗОЛЖАРГАЛ

Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

2016 оны 07-р сард хийсэн сургалтын үеийн зургуудаас



Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН



Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт”-ийн ажлын ЭЦСИЙН ШАТНЫ ТАЙЛАН

